



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 04. 30 № ЗГ-1/52
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 04. 30 № ХЭГ/1166
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй
холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын
хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний
дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт/Хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

100255005044

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.04.30 № 01/8590

танай 2025.04.25-ны № 01/1093 -т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Л.ГАНТӨМӨР ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000814



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26-75-33

Цахим шуудан: info@mojha.gov.mn

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.04.29

№

1/2283

танай

-ны №

-т

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Л.ГАНТӨМӨР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Хууль зүй, дотоод хэргийн яам

Удирдлага

Сайд

Оюунсайхан Алтангэрэл

2025.04.30 10:06



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2026 оны төсвийн зарлагын хязгаар, 2027-2028 оны дунд хугацааны зарлагын төсөөлөл болон Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох

тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Стратегийн баримт бичгийн төслийг, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг баримталсан бөгөөд Төсвийн тухай хууль 28¹.4 дэх заалт болон холбогдох журмын дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сард зохион байгуулж, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэн боловсруулсан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хууль 28¹.4-т заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сард зохион байгуулж, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлсэн болно. Мөн хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

- **Тэнцвэржүүлсэн орлого:** Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэснээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан тооцсон.
- **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026 онд ДНБ-ий 3 хувь, 2027-2028 онд 2 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн

төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх хуулийн шаардлагыг хангаж байна.

- **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ:** Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 онд 22 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2026 онд ДНБ-ий 50 хувь, 2027-2028 онд 45 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6.0 хувь, 2027-2028 онд тус тус 6.5 хувь байхаар тооцон тусгалаа. Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой түвшинд хадгалахад уул уурхайн салбарт хэрэгжиж буй том төслүүд хэвийн үргэлжлэх, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан мега төслүүд үе шаттай хэрэгжих зэрэг хүчин зүйлс чухал ач холбогдолтой байна. Мөн хуулийн төсөлд инфляцыг 2026 онд 7.0 хувь, 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6.0 хувь байхаар тусгалаа. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх, төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээ 2026 онд 33,479.5 тэрбум төгрөг, 2027 онд 35,628.6 тэрбум төгрөг, 2028 онд 39,086.0 тэрбум төгрөг байхаар тооцов. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд ДНБ-ий 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар төлөвлөсөн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2026 оны төсвийн зарлагын хязгаар, 2027-2028 оны дунд хугацааны зарлагын хязгаар төсөөлөл болон Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**



УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТӨСӨӨЛӨЛ	1
1.1. Монгол Улсын эдийн засгийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	1
1.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн	1
1.1.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт	5
1.1.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	6
1.1.4. Гадаад худалдааны урсгал тэнцэл	8
1.1.5. Төлбөрийн тэнцэл	11
1.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл.....	12
1.2.1. Дэлхийн эдийн засгийн төлөв.....	12
1.2.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага.....	14
1.2.3. Дотоодын нийт бүтээгдэхүүн	16
1.2.4. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт	17
1.2.5. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	18
1.2.6. Гадаад худалдааны урсгал тэнцэл	19
1.2.7. Төлбөрийн тэнцэл	20
1.3. Макро эдийн засгийн төлөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцсон арга зүй, тооцооны үндэслэл	29
2. ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨСӨӨЛӨЛ	31
2.1. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	31
2.1.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл.....	31
2.1.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт	33
2.1.3. Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ	34
2.1.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл.....	35
2.1.5. Улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалт	36
2.1.6. Засгийн газрын болзошгүй өр төлбөр.....	40
2.1.7. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал	41
2.2. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл.....	42
2.2.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2026-2028 оны төсөөлөл	42
2.2.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт	43
2.2.3. Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ	45
2.2.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт.....	45
2.3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн тоог ашиглаагүй бол үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлсон тайлбар	46
3. ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР	53
3.1. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, стратегийн зорилт	53

3.2. Төсвийн тусгай шаардлага хангасан байдал.....	55
3.3. Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ	56
3.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл.....	58
4. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	59
5. ХАВСРАЛТ	61
5.1. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн.....	61
5.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	69

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1	Эдийн засгийн өсөлтийн бүтэц.....	4
Хүснэгт 1.2	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	13
Хүснэгт 1.3	Цагаан алт хөдөлгөөний зорилт	22
Хүснэгт 1.4	Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилт	23
Хүснэгт 1.5	Бизнесийн эрхлэхүйн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, шалгуур үзүүлэлтээр	24
Хүснэгт 2.1	Нэгдсэн төсвийн 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)	31
Хүснэгт 2.2	Нэгдсэн төсвийн 2024 оны төлөвлөгөө, урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	32
Хүснэгт 2.3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөг)	32
Хүснэгт 2.4	Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг)	33
Хүснэгт 2.5	Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)	34
Хүснэгт 2.6	Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум төгрөг).....	35
Хүснэгт 2.7	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-д эзлэх хувь).....	35
Хүснэгт 2.8	Засгийн газрын өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг).....	37
Хүснэгт 2.9	Гадаад үнэт цаас, 2024.12.31-ний өдрийн байдлаар (тэрбум төгрөг).....	38
Хүснэгт 2.10	Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд, түүний гүйцэтгэл (тэрбум төгрөг)	41
Хүснэгт 2.11	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг)	42
Хүснэгт 2.12	Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг).....	43
Хүснэгт 2.13	Нийгмийн халамжийн сангийн зардлын төсөөлөл (тэрбум төгрөг)	44
Хүснэгт 2.14	Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)	45
Хүснэгт 2.15	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийн таамаглал.....	47
Хүснэгт 3.1	Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь).....	55
Хүснэгт 3.2	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)	55
Хүснэгт 3.3	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)	55
Хүснэгт 3.4	Гол нэр төрлийн эрдэс баялгийн татварын орлогын нийт төсвийн орлогод эзлэх хувь	56
Хүснэгт 3.5	Тэнцвэржүүлсэн үнийн тооцоолол.....	56
Хүснэгт 3.6	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт	58
Хүснэгт 5.1	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс ирүүлсэн задгай санал	61
Хүснэгт 5.2	Төрийн байгууллагын төлөөллөөс ирүүлсэн задгай санал.....	65

ЗУРАГ

Зураг 1.1	Эдийн засгийн өсөлтийн бүтэц	4
Зураг 1.2	Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл	6
Зураг 1.3	Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд	7
Зураг 1.4	Хүн амын насны суварга, 2024 он	8
Зураг 1.5	Гадаад худалдааны үзүүлэлт	10
Зураг 1.6	Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц	12
Зураг 1.7	Дэлхийн тодорхой бус байдлын индекс	13
Зураг 1.8	Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	14
Зураг 1.9	Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)	14
Зураг 1.10	Коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	15
Зураг 1.11	Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	15
Зураг 1.12	Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)	16
Зураг 1.13	Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл (хувь, их наяд төгрөг)	16
Зураг 1.14	Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн төсөөлөл (тэрбум ам.доллар)	19
Зураг 2.1	Улсын нийт гадаад өрийн статистик (тэрбум ам.доллар)	36
Зураг 2.2	Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж	38
Зураг 2.3	Улс орнуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ	45
Зураг 2.4	Улс орнуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ	45
Зураг 2.5	Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж	46
Зураг 2.6	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж	46
Зураг 2.7	Инфляцын жилийн түвшин, 3 жилийн дундаж	46
Зураг 3.1	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	57
Зураг 3.2	Төсвийн төлөв, үйлдвэрлэлийн зөрүү	57

ШИГТГЭЭ

Шигтгээ 1.1	Хөдөө аж ахуй, боловсруулах салбарт хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн зорилт	23
Шигтгээ 1.2	Бизнес эрхлэх орчны үнэлгээ	25
Шигтгээ 1.3	Мега төслүүд	29
Шигтгээ 2.1	Хөгжиж буй орнуудын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, түүний харьцуулалт	45
Шигтгээ 2.2	Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс	46
Шигтгээ 3.1	Тэнцвэржүүлсэн үнэ	56

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БҮ	Бараа, үйлчилгээ
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХТХМ	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕАЭЗХ	Евразийн эдийн засгийн холбоо
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НХ	Нийгмийн халамж
НХС	Нийгмийн халамжийн сан
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТБЗ	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УЦС	Усан цахилгаан станц
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

ХУРААНГУЙ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Стратегийн баримт бичгийн төслийг, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах” гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хууль 28¹.4-т заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сард зохион байгуулж, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлсэн болно. Мөн хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

- **Тэнцвэржүүлсэн орлого:** Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэснээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан тооцсон.
- **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026 онд ДНБ-ий 3 хувь, 2027-2028 онд 2 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ:** Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 онд 22 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2026 онд ДНБ-ий 50 хувь, 2027 онд 45 хувь, 2028 онд 45 хувь байхаар

тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6.0 хувь, 2027-2028 онд тус тус 6.5 хувь байхаар тооцож, тусгалаа. Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой түвшинд хадгалахад уул уурхайн салбарт хэрэгжиж буй том төслүүд хэвийн үргэлжлэх, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан мега төслүүд үе шаттай хэрэгжих зэрэг хүчин зүйлс чухал ач холбогдолтой байна. Мөн хуулийн төсөлд инфляцыг 2026 онд 7.0 хувь, 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6.0 хувь байхаар тусгалаа. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх, төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээ 2026 онд 33,479.5 тэрбум төгрөг, 2027 онд 35,628.6 тэрбум төгрөг, 2028 онд 39,086.0 тэрбум төгрөг байхаар тооцов. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд ДНБ-ий 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар төлөвлөсөн болно.

1. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТӨСӨӨЛӨЛ¹

1.1. Монгол Улсын эдийн засгийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

1.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2023 оны гүйцэтгэл: ДНБ 2023 онд нэрлэсэн дүнгээр 70.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 31 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит дүнгээр 30.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.4 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв.

Нүүрс болон газрын тос олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэн нөлөөгөөр 2022 онд 15.3 хувиар агшсан уул уурхайн салбар 2023 онд 23.4 хувиар тэллээ. Тухайлбал, нүүрс олборлолт 2023 онд 85.3 сая тоннд хүрч, өмнөх оноос 1.3 дахин, Оюу толгойн гүний уурхайн үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар сард эхэлснээр зэсийн баяжмалын үйлдвэрлэл 2023 онд 1,395 мянган тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар тус тус өсөв. Түүнчлэн, 2022 оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас үүдэн зогсоод байсан газрын тос олборлолт 2023 онд сэргэж, 4.9 сая баррельд хүрсэн нь өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэн үзүүлэлт боллоо. Харин алт олборлолт 14.9 тоннд, төмрийн хүдэр олборлолт 7.6 сая тоннд хүрч, өмнөх оноос 23 хувь болон 19 хувиар тус тус буурлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, тээвэр зохион байгуулалт сайжирсан, авто болон төмөр замаар тээсэн ачаа, мөн дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдсэн нөлөөгөөр тээврийн салбар 2023 онд 39.6 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлэв.

Өрхийн бодит орлого сэргэж, аялал жуулчлал, дотоодын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн нөлөөгөөр 2023 онд худалдаа, үйлчилгээний салбарууд болон цэвэр татварын орлого өслөө. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбар 2023 онд 6.8 хувиар тэллээ. Үйлчилгээний бусад салбаруудын хувьд, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, зочид буудал, нийтийн хоол, шинжлэх ухааны үйл ажиллагаа, урлаг, үзвэрийн үйлчилгээний салбарууд өсөлттэй байлаа. Мөн 2023 оны 2 дугаар сард махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалсантай холбоотойгоор 2023 онд мах боловсруулах үйлдвэрлэл болон боловсруулсан махны экспорт өссөнөөр боловсруулах салбар өмнөх оноос 5.1 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.4 нэгж хувийг бүрдүүлэв.

Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдлаас шалтгаалсан барилгын материалын нийлүүлэлтийн тасалдлаас үүдэлтэй барилгын өртгийн өсөлт үргэлжилснээр 2023 онд барилгын салбарын өсөлт 3.1 хувь болж саарлаа. Барилгын салбарын өсөлтөд худалдаа, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, соёлын зэрэг орон сууцны бус барилгын өсөлт гол нөлөө үзүүлсэн бол инженерийн болон орон сууцны барилга өсөлтийг хязгаарлалаа. 2022 он төмөр зам, авто замын томоохон бүтээн байгуулалт

¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "12.3.4. Өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны урсгал тэнцлийн талаарх макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд;"

хэрэгжсэн жил байсантай холбоотойгоор инженерийн барилга байгууламж 2023 онд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй гарлаа.

Харин өвөлжилт хүндэрснээр хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл буурч, нийт эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Оны эхнээс өвөлжилт, хаваржилт хүндэрснээс шалтгаалан төл бойжилт 2023 онд 28 хувиар буурч, малын хорогдол өмнөх оноос 6.4 дахин нэмэгдсэнээр мал аж ахуйн салбар 10.3 хувиар агшсан нь нийт эдийн засгийн өсөлтийг 1.4 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв. Харин газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 8 хувиар өсөж, нийт өсөлтөд эергээр нөлөөлсөн байна.

Эрэлт талаас эдийн засгийн өсөлтөд экспортын эрчимжилт голлон нөлөөллөө. Засгийн газраас экспортын орлого, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд нүүрсний экспорт 2023 онд түүхэн дээд хэмжээнд хүрч, бараа, үйлчилгээний экспорт бодит дүнгээр 33.2 хувиар өслөө. Улмаар гадаад худалдааны тэнцэл 5.7 хувиар сайжирсан нь эдийн засгийн өсөлтийг 1.8 нэгж хувиар дэмжсэн байна.

Нөгөөтээгүүр инфляц, ханш тогтворжсоны зэрэгцээ Засгийн газраас иргэдийн бодит орлогыг дэмжих хүрээнд цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийг нэмэгдүүлсэн нь өрхийн бодит орлого 6.1 хувиар сайжрахад нөлөөллөө. Улмаар өрхийн хэрэглээ 9.7 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 6.3 нэгж хувийг бүрдүүлсэн байна.

Уул уурхайг дагасан бүтээн байгуулалтын эерэг нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 2023 онд 5.3 хувиар нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд 1.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Харин экспорт эрчимжсэнтэй холбоотойгоор түүхий эдийн овоолго нөөц буурснаар материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал нийт эдийн засгийн өсөлтийг 3.3 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн байна.

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: ДНБ 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 80 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар, бодит дүнгээр 32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9 хувиар тус тус өслөө. Үйлчилгээний болон уул уурхай, барилгын салбаруудын үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн бол хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын гарц буурлаа.

Уул уурхайн салбар 2024 онд 10.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд, нүүрс олборлолт 101 сая тоннд хүрч, өмнөх оноос 25 хувиар, зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оноос 12 хувиар, төмрийн хүдэр, баяжмалын олборлолт өмнөх оноос 32 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Харин алт олборлолт 15 хувиар, газрын тос олборлолт 14 хувиар тус тус буурсан байна.

Нийт эдийн засгийн 52 хувийг бүрдүүлж буй үйлчилгээний салбаруудын идэвх хадгалагдаж, 2024 онд 9.8 хувиар өслөө. Үүнд, тээвэр, бөөний болон жижиглэн худалдаа, санхүү, даатгал болон мэдээлэл, холбооны салбаруудын үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, дотоодын болон импортын ачаа тээвэр нэмэгдсэн нөлөөгөөр тээврийн салбар 23.1 хувиар тэлэв. Тухайлбал, 2024 онд авто замаар тээсэн ачаа 85.2 сая тоннд хүрч өмнөх оноос 22 хувиар, төмөр замаар тээсэн ачаа 45.9 сая тоннд хүрч өмнөх оноос 26 хувиар тус тус өссөн байна.

Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 2024 онд 6.6 хувиар тэллээ. Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон ажилчдын тоо нэмэгдэж, шинээр олгосон зээл бусад салбартай харьцуулахад хамгийн их дүнгээр өссөн байна.

Түүнчлэн, мэдээлэл холбооны салбар дахь хөрөнгө оруулалт, сүлжээний бүтээн байгуулалт нэмэгдсэн нөлөөгөөр тус салбар 2024 онд 15.5 хувиар өссөн бол үйлчилгээний бусад салбаруудын үйл ажиллагаа 7.8 хувиар нэмэгдсэн байна.

Барилгын салбар эрчим хүч, далан суваг, шугам сүлжээ, авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн өсөлтийн голлох нөлөөгөөр 2024 онд 10.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтөд 0.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Тухайлбал, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 50МВт-ын хүчин чадалтай, 200МВт/цагийн багтаамжтай батарей хуримтлуурын станц, Төв аймагт 150МВт-ын хүчин чадалтай Бөөрөлжүүтийн ЦС, Завхан аймагт 22МВт-ын хүчин чадалтай Тосон ДЦС ашиглалтад орж, Сэлэнгэ аймагт 50МВт-ын хүчин чадалтай ДЦС зэрэг эрчим хүчний барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Түүнчлэн, Улаанбаатар-Дархан-Уул чиглэлийн авто зам, Өмнөговь, Ховд, Сэлэнгэ аймгуудын авто замын шинэчлэл болон Улаанбаатар хотын авто зам, гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил барилгын салбарын өсөлтийг голлон дэмжлээ.

Хөдөө аж ахуйн салбарын дийлэнх хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл он дамнасан зудын хүндрэлийн нөлөөгөөр буурснаар хөдөө аж ахуйн салбар 2024 онд 28.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарлалаа. Улсын хэмжээнд зудын хүндрэлээр 9.4 сая толгой том мал хорогдож, төл бойжилт өмнөх оноос 2.1 сая толгой малаар буурч 16.2 сая толгойд хүрснээр улсын хэмжээнд 2024 оны эцэст нийт 57.6 сая толгой мал тоологдлоо. Энэ нь 2015 оны үетэй ойролцоо түвшин юм. Мөн 2024 онд нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, нийт тариалсан талбайн 60 орчим хувийг бүрдүүлдэг улаанбуудайн тариалсан талбай 5.4 хувиар тус тус буурснаар хураасан улаанбуудайн хэмжээ өмнөх оноос 10.4 хувиар буурч, хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлалаа.

Хөдөө аж ахуйн салбарын уналтыг даган боловсруулах салбарын 45-50 орчим хувийг бүрдүүлдэг гурил, мах, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл буурснаар боловсруулах салбар 2024 онд 1.2 хувиар агшлаа. Үүнд, үхрийн махны үйлдвэрлэл 5.8 мянган тоннд хүрч өмнөх оноос 33 хувиар, гурилын үйлдвэрлэл 144 мянган тоннд хүрч өмнөх оноос 24 хувиар, самнасан ноолуур 626 тоннд хүрч өмнөх оноос 46 хувиар, ноолууран сүлжмэл эдлэл 368 мянган ширхэгт хүрч өмнөх оноос 21 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлөв. Харин дотоод эдийн засгийн идэвхийг даган боловсруулах салбарын 15 орчим хувийг бүрдүүлдэг бүх төрлийн ундааны үйлдвэрлэл тэлж, уул уурхайн салбарын эрчимжилтийг даган тэсэлгээний зориулалттай химийн бодис үйлдвэрлэл өссөн нь боловсруулах салбарын уналтыг саарууллаа.

Эрчим хүч, усан хангамжийн салбар эдийн засгийн өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв. Тухайлбал, 2024 онд нийт 8,708 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэж (үүнээс цахилгаан эрчим хүч 7,915 сая кВт.ц, сэргээгдэх эрчим хүч 793 сая кВт.ц), үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 5.5 хувиар өссөн бол түгээсэн цэвэр ус өмнөх оны түвшинтэй харьцуулахад 3.5 хувиар нэмэгдлээ.

Эрэлт талаас тооцсон бодит ДНБ 2024 онд 5.0 хувиар өслөө. 2024 онд эцсийн хэрэглээ 14.1 хувиар, хөрөнгийн хуримтлал 22.2 хувиар тус тус нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд 21.4 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэн, хөдөлмөр эрхлэлт өссөний зэрэгцээ инфляц оны эхний 10 сарын турш төв банкны зорилтот интервалд хадгалагдсанаар өрхийн бодит орлого 10.3 хувиар сайжирч, өрхийн хэрэглээ


12.9 хувиар тэлэв. Том малын зүй бус хорогдол 2024 онд 9.4 сая толгойд хүрснээр биологийн өсөж үрждэг хөрөнгө буурсан ч машин, тоног төхөөрөмжийн нөөц 36.3 хувиар, төмөр зам, авто замын барилга угсралтын ажлууд эрчимжсэн нөлөөгөөр барилга, байгууламжийн нөөц 22.9 хувиар тус тус нэмэгдсэнээр нийт хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Дотоод эдийн засгийн идэвхжил, эрэлтийн өсөлтийг даган нийт бараа, үйлчилгээний импорт 2024 онд 17.7 хувиар өссөнөөр цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг 16.4 нэгж хувиар буруулах нөлөө үзүүлэв.

Хүснэгт 1.1 Эдийн засгийн өсөлтийн бүтэц

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
ДНБ	-4.6	1.6	5.0	7.4	4.9
ХАА	0.8	-0.8	1.7	-1.3	-3.6
Үйлдвэрлэл	-1.3	-0.6	-1.2	3.2	1.7
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах	0.3	-0.1	0.5	0.4	-0.1
Цахилгаан, ус	0.0	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.3
Үйлчилгээ	-3.0	1.8	3.2	4.7	4.8
Худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Бусад	-0.6	1.5	1.7	2.1	2.8
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.0

Зураг 1.1 Эдийн засгийн өсөлтийн бүтэц



Эх сурвалж: ҮСХ

2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Эдийн засгийн өсөлт 2025 оны эцэст 7.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч үзвэл, уул уурхайн салбарын өсөлт эрчимжиж, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын үйлдвэрлэл сэргэх бол үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой байх төлөвтэй байна. Тухайлбал, уул уурхайн салбарт нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт өмнөх оноос нэмэгдэж, Оюу толгойн гүний уурхайн нөлөөгөөр баяжмал дахь зэс, алтны агуулга өсөхөөр байгаа нь салбарын өсөлтөд томоохон нөлөөг үзүүлэхээр байна. Мөн Баянхөндийн алтны төсөл 2025 оны сүүлийн хагасаас олборлолт хийж эхэлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлнэ. Уул уурхайг дагасан тээврийн салбарын өсөлт болон бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт үйлчилгээний салбарын үйл ажиллагааг дэмжиж, нийт үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтөд 2.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Түүнчлэн, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Атар-4” аяны хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр байна. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2024 онд нийт 1,261 тэрбум төгрөгийн, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд эргэлтийн хөрөнгийн 169 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын 75 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгосон бол “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд 2025 онд 800 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөсөн байна. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20-40 хувь, ноосны боловсруулалтын түвшнийг 25-55 хувь, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30-50 хувь хүртэл нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Эдгээр зорилтууд нь үйлдвэрлэлийн түвшин, бүтээмжийг нэмэгдүүлэх

замаар салбарын тогтвортой өсөлтийг дэмжихээр байна. Мөн Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор ноолуурыг самнаж экспортлохоор шийдвэрлэсэн нь ноолуурын нэмүү өртгийг нэмэгдүүлж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Түүнчлэн газар тариалангийн талбайг нэмэгдүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг өсгөх зорилт бүхий “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хэрэгжилт хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ.

Барилгын салбарт томоохон бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдэж, салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төв, Эмээлт аж үйлдвэрийн парк, Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2 дугаар блок, Төв аймгийн Баян суманд баригдах 660МВт-ын ДЦС-ын бүтээн байгуулалтын ажил эрчимжихийн зэрэгцээ орон сууцны зориулалттай зээлийн эрэлтийг дагаж орон сууцны барилгын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдэхээр байна.

Эрчим хүчний салбарт өмнөх онд Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 МВт-ын хүчин чадал бүхий 1 дүгээр блок ашиглалтад орсон нь салбарын үйлдвэрлэл болон эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлнэ.

Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалт болон экспорт дэмжих хүлээлттэй байна. Барилгын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжиж эхлэхийн зэрэгцээ 2023-2024 онд тохиосон зудын дараа эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Нөгөөтээгүүр Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулгын өсөлт экспортын бодит өсөлтийг нэмэгдүүлэхээр байна. Харин нийт эрэлтийн 70 орчим хувийг бүрдүүлдэг өрхийн хэрэглээ 2025 онд 5 орчим хувиар өсөх хүлээлттэй байна.

1.1.2. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт

2023 оны гүйцэтгэл: Инфляц 2023 онд дунджаар 10.4 хувь, оны эцэст 7.9 хувь гарлаа. Нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт тогтворжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш жилийн өмнөх түвшнээс чангарсан, гадаад үнэ болон тээврийн зардлын өсөлт саарсны зэрэгцээ макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд инфляц 2023 онд алгуур буурсан хандлагатай байв. Арилжааны банкнуудын зээл олголт эрчимжсэнээр зээлийн үлдэгдлийн өсөлт 2023 оны эцэст 23.4 хувьд хүрлээ. Зээлийн үлдэгдлийн өсөлтөд иргэдийн цалин, тэтгэврийн зээлийн өсөлт голлон нөлөөллөө.

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өслөө. Үүнд төлбөрийн тэнцэл сайжирсантай холбоотойгоор арилжааны банкнуудын гадаад цэвэр актив нэмэгдсэн болон дотоод зээл олголт өссөн нь голлон нөлөөлсөн байна. Эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлт өсөхөд голлон нөлөөллөө. Тухайлбал, нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 23.9 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж бүрдүүлсэн бол 2.7 нэгж хувийг гадаад валютын харилцах, хадгаламж бүрдүүлсэн байна.


2024 оны гүйцэтгэл: Инфляц 2024 онд дунджаар 6.8 хувь, оны эцэст 9.0 хувь гарлаа. Эдийн засгийн дотоод идэвхжилээс үүдэлтэйгээр эрэлтийн шалтгаантай инфляц өссөний зэрэгцээ импортын болон үйлчилгээний инфляц эрчимжсэн байна. Инфляц оны эцэст өмнөх оны мөн үеэс өсөхөд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээсийн зардал болон хувцасны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Төв банк 2023 оны турш 13 хувьд хадгалсан бодлогын хүүг 2024 онд 10 хувьд хүргэж буурууллаа.

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2024 оны эцэст 36.8 их наяд төгрөгт хүрч, зээлийн өсөлт 35.5 хувьд хүрч эрчимжсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр өсөлт болов. Зээлийн өсөлтөд цалин, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа болон уул уурхайн салбарын зээлийн өсөлт голлон нөлөөллөө.

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эцэст 43.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өслөө. Эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлөв. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 17.8 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж, -2.8 нэгж хувийг гадаад валютын харилцах, хадгаламж тус тус бүрдүүлсэн байна.

2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Инфляц 2025 оны 3 дугаар сард 9.1 хувь гарлаа. Инфляц энэ онд дунджаар төв банкны зорилтот түвшнээс өндөр байх хүлээлттэй байна. Тодруулбал, хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Мөн 2025 оны 2 дугаар сард нийтийн тээврээр зорчих үнэ шинэчлэгдсэн нь инфляцыг нэмэгдүүлж байна. Цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.

Зураг 1.2 Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

1.1.3. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин


2023 оны гүйцэтгэл: Ажилчдын тоо 2023 оны байдлаар өмнөх оноос 11 мянган хүнээр өсөж 1 сая 295 мянгад хүрсэн байна. Дотоодын эдийн засаг идэвхжиж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, экспорт нэмэгдэж өрхийн хэрэглээ сэргэснээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр хөдөө аж ахуй, худалдаа, уул уурхайн салбарын ажилчид өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Харин боловсруулах, тээвэр, үйлчилгээ, барилгын салбарын ажилчид буурсан нь ажилчдын тооны өсөлтийг саарууллаа.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 15 мянгаар буюу 17 хувиар буурч 73 мянгад хүрснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч 5.3 хувьд хүрсэн байна. Ажилчдын тооны өсөлт харьцангуй бага, ажилгүй иргэдийн тоо буурснаас ажиллах хүч өмнөх оноос 3 мянгаар багасаж 1 сая 367 мянгад хүрснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.8 нэгж хувиар буурч 59.5 хувьд хүрчээ.


2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл²: Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа идэвхжиж, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд сайжирч, худалдаа, үйлчилгээ, барилга болон тээврийн салбарын тэлэлттэй уялдан ажилчдын тоо 36 мянгаар буюу 2.8 хувиар өсөж 1 сая 330 мянгад хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч хөдөө аж ахуйн салбарын уналт нь ажил эрхлэлтийн өсөлтийг сааруулах төлөвтэй байна.

Зураг 1.3 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

1. Ажилчид, ажилгүй хүний тоо (мянган хүн)



2. Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин (баруун тэнхлэг), (хувь)



Эх сурвалж: ҮСХ, ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: *хүлээгдэж буй гүйцэтгэл

Дундаж цалингийн хувьд цар тахлаас хойш 2022 онд 18 хувь, 2023 онд 25 хувиар тус тус нэмэгдэж 2022 онд 1 сая 504 мянга, 2023 онд 1 сая 882 мянга болсон. Дундаж цалингийн хэмжээ ажилчдын тоо өсөхийн хэрээр нэмэгдэх хандлагатай байгаа нь дотоодын хэрэглээг дэмжиж, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх хүлээлттэй байна. 2024 онд дундаж цалин өмнөх оноос 470 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өсөж 2 сая 350 мянган төгрөгт хүрэх төлөвтэй байна. Бодит цалингийн хэмжээ мөн инфляцын нөлөөг үл харгалзан 232 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өсөж 1.6 сая төгрөгт хүрэхээр тооцоологдож байна.

Түүнчлэн ажиллах хүчнээс гадуур байсан иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхол, боломж нэмэгдсэнээр хөдөлмөрийн нийлүүлэлт өсөж ажиллах хүч өмнөх оноос 42 мянган хүнээр буюу 3 хувиар тэлж 1 сая 410 мянгад хүрнэ гэж үзэж байна. Энэ нь ажиллах хүчний оролцооны түвшнийг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 61 хувьд хүргэх хүлээлтийг бий болгож байна. Нөгөөтээгүүр ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 6.8 мянгаар буюу 9 хувиар өсөж 79 мянгад хүрэх төлөвтэй байна. Үүнээс шалтгаалан ажилгүйдлийн түвшин 5.6 нэгж хувьд хүрч өмнөх оноос 0.3 нэгж хувиар нэмэгдэж гарах хүлээлттэй байна.


Энэхүү хүлээлтийг мөн Хэрэглэгчийн итгэлийн индекстэй³ уялдуулан харж болох юм. Хэрэглэгчийн итгэлийн индекс 2024 оны 4 дүгээр улиралд 104.7 нэгжид хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 нэгжээр өссөн. Энэ өсөлт нь бизнесийн орчны үнэлгээ сайжирч, ажлын

² Хөдөлмөрийн зах зээлийн 2024 оны үзүүлэлтүүд 2025 оны 6 дугаар сард зарлагдана.

³ Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг тус индекс нь эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр өөдрөг харж байгааг хэмждэг. Ингэхдээ Өнөөгийн байдлын индекс (бизнесийн нөхцөл, ажлын олдоц), Ирээдүйн хүлээлтийн индекс (бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого) гэсэн 2 дэд индекс (5 үзүүлэлт)-ийг ашиглан тооцдог. Индексийн үнэлгээ 0-200 онооны хооронд үнэлэгддэг.

байрны олдоц нэмэгдсэнтэй холбоотойгоор эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг илэрхийлдэг өнөөгийн байдлын индекс 32.9 нэгжээр өссөнтэй холбоотой юм. Энэ нь хэрэглэгчид эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг өмнөх үеэс илүү эергээр үнэлж буйг илтгэж байгаа бөгөөд дотоодын хэрэглээ, хэрэглэгчдийн зарцуулалтын хандлага цаашид нэмэгдэх боломжтойг харуулж байна.

Зураг 1.4 Хүн амын насны суварга, 2024 он



Эх сурвалж: ҮСХ, ЭЗХЯ-ны тооцоолол

2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд цаашид өндөр түвшиндээ хадгалагдах төлөвтэй байх хэдий ч 1990-2005 онд төрөлтийн түвшин бага байснаас одоо үеийн залуу боловсон хүчин болох 20-34 насны залуучуудын тоонд нөлөө үзүүлж байгаа нь (Зураг 1.4) хөдөлмөрийн нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах хүчин зүйл болж байна. Үүний улмаас ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд буурах хандлагатай байна. Энэхүү хүн ам зүйн шалтгааны талаар Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд⁴ мөн дурдсан байдаг.

Ажилчдын тоо 2025 онд 31 мянгаар буюу 2 орчим хувиар нэмэгдэж 1 сая 361 мянгад хүрэх төлөвтэй байна. Уг өсөлтөд тээвэр, худалдаа, уул уурхай, боловсруулах салбаруудын идэвхжил голлон нөлөөлөх бөгөөд нөгөө талаас хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн нөлөөгөөр салбарын ажилчдын тоо аажмаар буцаж сэргэх хүлээлттэй байгаа нь нийт ажил эрхлэлтийн өсөлтийг дэмжихээр байна.

Түүнчлэн хөдөлмөрийн эрэлтийн өсөлт, хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдсэнтэй холбоотойгоор ажиллах хүч 32 мянган хүнээр буюу 2 орчим хувиар нэмэгдэж 1 сая 441 мянгад хүрэх төлөвтэй байна. Үүний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 1 нэгж хувиар өсөж, 2025 онд 62.1 хувьд хүрнэ гэж үзэж байна.

Мөн дээрх хүлээлтийг Хэрэглэгчийн итгэлийн индексийн ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх иргэдийн хүлээлтийг илэрхийлдэг дэд индекс болох *ирээдүйн хүлээлтийн индекстэй* уялдуулан харвал, дэд индексийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 11.5 нэгжээр өссөн эерэг үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь ирэх зургаан сарын хугацаанд ажлын байрны боломж, бизнесийн орчныг өөдрөгөөр үнэлэх иргэдийн хувь нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нөгөө талаас ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 1 мянгаар өсөж, 80 мянгад хүрэх хандлагатай байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 5.6 хувьд хадгалагдах төлөвтэй байна.

1.1.4. Гадаад худалдааны урсгал тэнцэл

2023 оны гүйцэтгэл: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 онд 24.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 15.0 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

⁴ ГБХННЯ, ХНХСҮСИ болон Эм-Эм-Си-Жи ХХК хамтран боловсруулсан 2024 оны судалгааны тайлан

Экспорт 2023 онд 15.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 21.1 хувиар өслөө. Өсөлтөд нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Тухайлбал, уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 13.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 19.1 хувиар өссөн байна. Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулагдаж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтэрсэн, Оюу толгойн гүний уурхай ашиглалтад орсон нөлөөгөөр Монгол Улс 2023 онд 69.6 сая тонн нүүрс, 1,525 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна. Түүнчлэн, 2022 оны эхний хагас жилд хаагдаад байсан Дорнод аймаг дахь хилийн боомтуудын үйл ажиллагаа 2023 онд тогтворжсон, төмөр замын зохион байгуулалт сайжирсантай холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 5.6 сая тонн, газрын тосны экспорт 4.7 сая баррельд хүрч нэмэгдлээ.

Харин уул уурхайн бус экспорт 1.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 48.7 хувиар өслөө. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 743 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 37 хувиар, аж үйлдвэрлэлийн салбарын экспорт 387 сая ам.долларт хүрч өмнөх оноос 58 хувиар тус тус өссөн байна. Махны экспортыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд Засгийн газраас махны экспортод тавих хязгаарлалтыг цуцалснаар 2023 онд махны экспорт 310 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6 дахин нэмэгдлээ. Мөн Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоолын хавсралтын боловсруулаагүй арьс, ширний экспортыг хориглох тухай заалтыг Засгийн газрын 2023 оны 372 дугаар тогтоолоор хүчингүй болгосноор 2013 оноос хойш 10 дахин буураад байсан арьс, ширний экспорт 2023 онд 4.7 сая ам.долларт хүрч, ОХУ, Турк, Итали, Узбекистан улсууд руу түүхий арьс, шир экспортолж эхэлсэн.

Нийт импорт 2023 онд 9.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 6.3 хувиар буюу 0.5 тэрбум ам.доллараар өслөө. Үүний 95 хувийг биет хэмжээний өсөлт, 5 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлж, импортын барааны үнийн өсөлтийн дарамт бага байлаа. Үүнд, БНХАУ-ын инфляцын бууралт болон ОХУ-Украины дайнаас үүдэн эрчимтэй өсөөд байсан нефтийн бүтээгдэхүүн, бордоо, үр тарианы үнэ 2023 онд тогтворжиж, буурсан нь голлох нөлөөг үзүүллээ.

Уул уурхай, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлтийг дагаж тоног төхөөрөмж, машин механизм, дизелийн түлшний импорт өндөр байсан нь нийт импортын өсөлтөд голлох нөлөөг үзүүллээ. Тухайлбал, 2023 онд нүүрс тээвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор дизелийн түлшний импорт 1,090 мянган тоннд хүрч, өмнөх оноос 39.0 хувиар өссөн бол хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлснөөр энэ төрлийн барааны импорт 255 сая ам.доллар болж, өмнөх оноос 55.8 хувиар өслөө.

2024 оны гүйцэтгэл: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 12.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2024 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 3.9 хувиар өслөө. Өсөлтөд зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн, алтны дэлхийн зах зээл дэх үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөллөө.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна. Хилийн голлох боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирч, ажиллах цагийн хуваарь уртассанаар нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар нэмэгдлээ. Оюу толгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн

баяжмалын экспорт 2024 онд 1,695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11 хувиар, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7,511 мянган тоннд хүрч, өмнөх оноос 31 хувиар тус тус өслөө.

Харин уул уурхайн бус экспорт 1.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 13.9 хувиар буурлаа. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 493 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 33.6 хувиар буурсан байна. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, 2024 оны эцсийн байдлаар малын махны экспорт 14 хувиар, ноолуурын экспорт 11 хувиар, арьс ширний экспорт 5 хувиар тус тус буурсан байна.

Зураг 1.5 Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: Импортын бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ангилла.

Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, дотоод идэвхжил өндөр байснаар бараа, бүтээгдэхүүний импорт 2024 онд 11.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар буюу 26 хувиар өслөө. Импортын дүн өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар өссөний 90 орчим хувийг тоо хэмжээ, 10 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Худалдааны гол түнш орнуудад үнийн өсөлт саарсан нь импортын барааны үнийн өсөлт бага түвшинд хадгалагдахад нөлөөлөв.

Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт өсөлтийн 11.6 нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик, тоног төхөөрөмж, барилгын материал, 10.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 3.3 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, нүүрсний олборлолт 23 хувиар, экспортын биет хэмжээ 20 хувиар тус тус өссөн нь уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүллээ. Тухайлбал, экскаватор, шанагат ухагчийн импорт 362 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 2 дахин, ачаа бараа тээвэрлэх тээврийн хэрэгслийн импорт 722 сая ам.долларт хүрч 67 хувиар, дизель түлшний импорт 1,296 сая ам.долларт хүрч 17 хувиар тус тус өссөн байна.

Өрхийн орлого сайжирч, хэрэглээний зээл нэмэгдсэн нь хэрэглээний бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын автомашины импортыг өдөөлөө. Тухайлбал, иргэдэд шинээр олгосон зээл 2024 онд 34 хувиар өсөж, суудлын автомашины импорт өмнөх оноос 67 хувиар

өссөн байна. Суудлын автомашины импорт нэмэгдэж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээний тоо өссөнтэй холбоотойгоор авто бензиний импорт 643 сая ам.долларт хүрч, 23 хувиар өслөө.

2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: 2025 оны эхний 3 сарын байдлаар экспорт 3.0 тэрбум ам.доллар, импорт 2.5 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 465 сая ам.долларын ашигтай байна. Нийт гадаад худалдааны бараа эргэлт 2025 оны эцэст 30.0 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна.

Нийт экспорт 2025 онд 17.1 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 15.8 тэрбум ам.долларт, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1.3 тэрбум ам.доллар, тэр дундаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 717 сая ам.долларт тус тус хүрэхээр байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсноор хилийн Гашуунсухайт боомтын нүүрс тээврийн эргэлт сайжрах, Тавантолгой-Ханги чиглэлийн төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулснаар хилийн Ханги боомтын нүүрс тээвэр нэмэгдэж, нүүрсний экспорт 2025 онд 90 сая тоннд хүрэхээр байна. Түүнчлэн, Оюу толгойн гүний уурхайн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэж зэсийн баяжмалын экспорт 2,030 мянган тонн, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 8,110 мянган тоннд хүрэхээр төсөөлж байна.

Нийт импорт 2025 онд 12.9 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй байна. Мөн газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Монгол-Францын хамтарсан ураны төсөл, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өсөхөөр байна.

1.1.5. Төлбөрийн тэнцэл


2023 оны гүйцэтгэл: Засгийн газраас авч хэрэгжүүлсэн гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээнүүдийн үр дүнд 2023 онд экспортын орлого нэмэгдэж, урсгал данс 15 жилийн дараа анх удаа ашигтай гарлаа. Улмаар 2023 оны эцэст төлбөрийн тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрч нэмэгдлээ.

Засгийн газар 2023 онд “Сенчири-2” болон “Сенчири-3” төслүүдийн хүрээнд нийт 1 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах зээлд арилжаалж, өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх дарамтыг бууруулж, өрийн дефолтын эрсдэлээс сэргийлж, зээлжих зэрэглэлийг 2023 онд тогтвортой хадгалж чадлаа.

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Импортын өсөлтийн нөлөөгөөр барааны худалдааны ашиг өмнөх оноос 1.6 тэрбум ам.доллараар буурснаар урсгал дансны тэнцэл 2024 онд 2.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал данс алдагдалтай гарсан ч санхүүгийн дансны ашиг нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын нөөц оны эцэст 5.5 тэрбум ам.долларт хүрч нэмэгдлээ.

Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юань буюу 620 сая ам.долларын эргэн төлөлтийг хийсэн нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүллээ. Нөгөө талаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гадаад зах зээлд шинэ бондууд гаргаснаар гадаад валютын орох урсгал нэмэгдэж, санхүүгийн дансны ашиг 2024 онд 3.2 тэрбум ам.долларт хүрлээ.

Зураг 1.6 Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк

2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 2 сарын байдлаар 742 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 3 дугаар сарын эцэст 4,996 сая ам.доллар байна. Төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс буурахад нүүрсний үнийн уналтаас шалтгаалан экспортын орлого буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад санхүүгийн дансны ашиг бага байсан нь голлон нөлөөллөө. Засгийн газраас экспортын орлого, санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлж, гадаад валютын улсын нөөцийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

1.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл

1.2.1. Дэлхийн эдийн засгийн төлөв


Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индексийн үзүүлэлтээр дэлхийн тодорхой бус байдал сүүлийн саруудад цар тахлын дараах хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Үүнтэй холбоотойгоор ОУВС дэлхийн эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 2.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 3.0 хувь болгож, энэ оны 1 дүгээр сард зарласан төсөөллөөс тус тус 0.5 нэгж болон 0.3 нэгж хувиар бууруулаад байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрхи Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдал зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Хүснэгт 1.2 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2024	2025*	2026*
ОУВС (%)	3.3	2.8	3.0
Дэлхийн банк (%)	2.7	2.7	2.7
OECD (%)	3.2	3.1	3.0

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2025 оны 1-4 дүгээр сар

Зураг 1.7 Дэлхийн тодорхой бус байдлын индекс



Эх сурвалж: World Uncertainty Index

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 5.0 хувь гарч, тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. Тус улсын засгийн газраас 2025 онд дотоод эрэлт, тэр дундаа өрхийн хэрэглээг дэмжих бодлогыг баримталж, эдийн засгийн өсөлтийг 5.0 орчим хувьд хүргэх зорилтыг зарлаад байна. Энэ хүрээнд хэрэглээг дэмжихэд чиглэсэн татаас, урамшуулал, татварын дэмжлэгийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ төсвийн алдагдлыг ДНБ-ий 3 хувиас 4 хувьд, засгийн газрын урт хугацаат бондын хэмжээг 1.3 их наяд юань, орон нутгийн бондын хэмжээг 4.4 их наяд юаньд хүргэж тус тус нэмэгдүүлэхээ зарлаад байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг ОУВС 2025 болон 2026 онд 4 хувь байх төсөөллийг энэ оны 4 дүгээр сард зарлаад байна. Гэсэн хэдий ч худалдааны дайнтай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

ОХУ: Дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлтийн голлох нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг 2024 онд 4.1 хувиар өслөө. Цаашид дайнтай холбоотойгоор тус улсын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 1.5 хувь, 2026 онд 0.9 хувь орчимд байна гэж ОУВС тооцоолж байна.

АНУ: Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2024 онд 2.8 хувиар тэллээ. Үнийн өсөлт болон хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалтай уялдуулан Холбооны нөөцийн банк бодлогын хүүг 2024 онд 3 удаа бууруулаад байна. Худалдааны дайн, бодлогын тодорхой бус байдал болон эрэлт буурах төлөвөөс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 1.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 1.7 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.9 нэгж хувь болон 0.4 нэгж хувиар бууруулаад байна. Тус улсын өрнүүлж буй худалдааны дайны цар хүрээ улам бүр нэмэгдэж байгаа нь АНУ төдийгүй дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдах, инфляц өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.


Евро бүс: Евро бүсийн эдийн засаг 2024 онд 0.8 хувиар тэллээ. Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Худалдааны дайнтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт 2025 онд 0.8 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр бүсийн өсөлт 1.2 хувьд хүрч эрчимжинэ гэж ОУВС тооцоолж байна.

1.2.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэсийн үнэ: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 онд 9,145 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 3 сарын байдлаар дундаж үнэ 9,333 ам.доллар болж, өмнөх оноос 2.1 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлоготой холбоотойгоор томоохон үйлдвэрүүд зэсийн нөөцөө нэмэгдүүлж эхэлсэн нь оны эхэнд үнэ өсөхөд нөлөөлсөн хэдий ч 4 дүгээр сар гараад тарифын бодлого хэрэгжиж эхэлснээр зэсийн үнэ сүүлийн 3 сарын доод түвшинд хүрч буураад байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар, 2026 онд 9,700 ам.долларт хүрэхээр байна.

Алтны үнэ: Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2024 онд 2,389 ам.доллар болж, өмнөх оноос 22.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 3 сарын байдлаар дундаж үнэ 2,872 ам.доллар болж, өмнөх оноос 20.2 хувиар өссөн байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.доллар, 2026 онд 2,600 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.8 Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 1.9 Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)




Эх сурвалж: Блүүмберг терминал


Коксжих нүүрсний үнэ: Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 онд 243 ам.доллар болж, өмнөх оноос 17.9 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 3 сарын байдлаар дундаж үнэ 186 ам.доллар болж, өмнөх оноос 25.9 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч том хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын цагаан сарын баярын амралтаас шалтгаалан ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2025 онд 180 ам.доллар, 2026 онд 178 ам.долларт хүрч буурахаар байна. Монгол Улсын нүүрсний экспортын дундаж үнэ 2025-2026 онд 80 ам.доллар байхаар тооцоолж байна.

Зураг 1.10 Коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)

1. Дэлхийн зах зээлийн үнэ (ам.доллар/тонн)



2. Экспортын хилийн үнэ (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал, Гаалийн ерөнхий газрын статистик, ЭЗХЯ-ны тооцоолол


Төмрийн хүдрийн үнэ: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2024 онд 110 ам.доллар болж, өмнөх оноос 8.0 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 3 сарын байдлаар дундаж үнэ 103 ам.доллар болж, өмнөх оноос 6.4 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.доллар, 2026 онд 90 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 2025 онд 72 ам.доллар, 2026 онд 69 ам.доллар байхаар тооцоолж байна.

Зураг 1.11 Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)

1. Дэлхийн зах зээлийн үнэ (ам.доллар/тонн)




2. Экспортын хилийн үнэ (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал, Гаалийн ерөнхий газрын статистик, ЭЗХЯ-ны тооцоолол

Газрын тосны үнэ: Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 онд 80 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 2.8 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 3 сарын байдлаар дундаж үнэ 74 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 7.5 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн идэвхжилийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 70 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын газрын тосны экспортын дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 72 ам.доллар байхаар тооцоолж байна.

Зураг 1.12 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



1.2.3. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлт 2026 онд 6.0 хувь, 2027 онд 6.5 хувь, 2028 онд 6.5 хувь орчимд байх төлөвтэй байна. Уул уурхайн салбарт зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс, төмрийн хүдэр болон алтны олборлолт нэмэгдэж, салбарын өсөлт 2026 онд 10 орчим хувьд хүрч, эдийн засгийн өсөлтийг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал, Оюу толгойн гүний уурхайн олборлолт үргэлжилж, зэсийн баяжмал үйлдвэрлэл нэмэгдэхийн зэрэгцээ цэвэр зэсийн агуулга нэмэгдэх нь уул уурхайн салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. Мөн шороон ордын алт тушаалт нэмэгдэж, алтны үндсэн ордууд эдийн засгийн эргэлтэд орж, геологи хайгуулын ажил эрчимжсэнээр үндсэн болон шороон ордуудын нөөц өсөх хүлээлттэй байна. Түүнчлэн, Баянхөндийн алтны төсөл 2025 оны сүүл хагасаас олборлолтоо эхлүүлж, 2026 оноос олборлолт нэмэгдэх төлөвтэй байна. Үүний үр дүнд 2026 оноос нийт алтны олборлолт нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцоолж байна.

Дунд хугацаанд уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт тогтворжиж, эдийн засгийн өсөлтөд 2027 онд 0.8 нэгж хувь, 2028 онд 0.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэхээр байна. Тухайлбал, боомтуудын хил дамнасан төмөр замын холболттой холбоотойгоор нүүрс олборлолт нэмэгдэх бол Монгол-Францын хамтарсан ураны төсөл 2028 оноос олборлолт эхлүүлэхээр байгаа нь салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр байна.

Уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл 2026 онд 5.9 хувиар, 2027-2028 онд тус тус 6.6 хувь болон 6.8 хувиар өсөхөөр төсөөлж

Зураг 1.13 Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл (хувь, их наяд төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ-ны статистик

байна. Тээврийн салбарт уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдэн, боомтуудын хил холболтын бүтээн байгуулалт хийгдэж, тээврийн дэд бүтэц сайжирснаар тус салбар дунд хугацаанд 5.6 орчим хувийн өсөлттэй байхаар байна.

Хөдөө аж ахуй, боловсруулах салбарын өсөлт “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Атар-4” аяны нөлөөгөөр дунд хугацаанд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна. Тухайлбал, “Атар-4” аяны хүрээнд 2026-2028 онд 950 тэрбум төгрөгийн, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд 2026 онд 246 тэрбум төгрөгийн, “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд 2026 онд 426 тэрбум төгрөгийн зээлийг олгох төлөвлөгөөтэй байна. “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд 2028 он гэхэд ноолуурын боловсруулалтын түвшнийг 20 хувиас 40 хувьд, ноосны боловсруулалтын түвшнийг 25 хувиас 55 хувьд, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30 хувиас 50 хувьд хүртэл нэмэгдүүлэх зорилтыг тавьсан. Энэ хүрээнд нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл жил бүр дунджаар 5 орчим хувиар тогтвортой нэмэгдэж, 2028 оны эцэст зорилтот түвшинд хүрэхээр тооцоолж байна. 2028 он гэхэд гурилын хэрэглээг дотоодоос бүрэн хангах, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээлийг 200 мянган тонноор нэмэгдүүлэх Атар-4 аяны зорилтуудтай уялдуулан улаанбуудайн ургацын хэмжээ 2026 онд 445 мянган тоннд хүрч, 2027-2028 онд тогтвортой нэмэгдэх, газар тариалангийн үйлдвэрлэл болон боловсруулах салбарын үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөөр тооцоолж байна.

Харин боловсруулах салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах үйлдвэрлэлийн дунд хугацааны өсөлтөд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт нөлөө үзүүлнэ гэж хүлээж байна. Уг техникийн зохицуулалтын хүрээнд хоол үйлдвэрлэл, худалдааны газарт борлуулах мах болон цэцэрлэг, эмнэлэг, сургуулийн хоолонд “мал төхөөрөх үйлдвэр”-т бэлтгэсэн мах хэрэглэхээр заасан. Иймд тус техникийн зохицуулалтын хүрээнд сургууль, цэцэрлэгийн нийт хэрэглээний махны мах боловсруулах үйлдвэрт бэлтгэгдэх хэмжээг 2026 онд 10 хувь, 2027-2028 онд тогтвортой нэмэгдэхээр, мөн мах, махан бүтээгдэхүүний экспортыг хориглох аливаа шийдвэр 2025 оны 6 дугаар сараас хойш гарахгүй байх суурь нөхцөлийн хүрээнд мах боловсруулах үйлдвэрлэлийн төсөөллийг боловсрууллаа.

Түүнчлэн, ирэх онуудад хэрэгжих томоохон төслүүд барилга, эрчим хүч, боловсруулах салбарын өсөлтийг голчлон тэтгэхээр байна. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, газрын тос боловсруулах үйлдвэр, Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, Улаанбаатар-Шинэ Хархорум хот чиглэлийн автозамын өргөтгөл шинэчлэл, зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс-химийн цогцолбор, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв зэрэг бүтээн байгуулалтын төслүүд барилга, эрчим хүч, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжих хөшүүрэг болно.

Мөн эдийн засгийн дотоод эрэлт хадгалагдаж, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилснээр үйлчилгээний салбар 2026-2028 онд эдийн засгийн өсөлтөд жил бүр 2.2-2.8 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулахаар байна.

1.2.4. Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт

Инфляц 2026 онд дунджаар 7.0 хувь буюу төв банкны зорилтот интервалд хадгалагдах төлөвтэй байна. Тодруулбал, ирэх онд цахилгааны тариф болон нийтийн тээврийн

үйлчилгээний үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилж, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурснаар инфляц төв банкны зорилтот интервалд хүрч тогтворжихоор байна.

Дунд хугацаанд инфляц 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Тодруулбал, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дунд хугацаанд хүнсний үнийн өсөлт буурах хүлээлттэй байна. Мөн төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу төв банк 2027 оноос инфляцын зорилтыг 5 хувь болгон бууруулах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр байна.

Түүнчлэн, Засгийн газраас баримталж буй гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг хязгаарлахад чиглэсэн бодлогын нөлөөгөөр инфляц үргэлжлэн буурахаар байна. Мөн импортын гол боомт болох Замын-Үүд боомтод хийгдэж буй нарийн царигийн хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд тус боомтын нэвтрүүлэлтийн хүчин чадал нэмэгдэж, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэй үнийн өсөлтийн эрсдэлийг бууруулахаар байна.

1.2.5. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын судалгаагаар дундаас дээш орлоготой улс орнуудын ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 66 хувь байдаг бөгөөд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт ажиллах хүчний оролцооны түвшнийг дээрх улс орнуудын түвшинд хүргэх буюу 2025 онд 63 хувь, 2030 онд 65 хувьд хүргэх зорилт тавьсан. Энэ хүрээнд Засгийн газраас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээнд нийцсэн орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгох, хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн платформ бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих бодлого, арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн төрөлтийн түвшин 1990-2005 оны хооронд буурснаас шалтгаалан хөдөлмөрийн насны хүн амын өсөлт удааширч, ажиллах хүчний нийлүүлэлт саарч буй байдал 2026 оноос эхлэн суларч, хөдөлмөрийн насны хүн амын өсөлт эргэн нэмэгдэх хандлагатай байна.

Нөгөөтээгүүр, 2026-2028 онд жилд дунджаар 34 мянган хүн тэтгэвэрт гарах төлөвтэй байгаа бол хөдөлмөрийн зах зээлд жилд дунджаар 58 мянган шинэ төгсөгч нийлүүлэгдэхээр байна. Иймд жил бүр шинээр төгссөн 24 мянган хүнийг ажлын байраар хангах шаардлага үүсэж байна. Судалгаагаар⁵ цар тахлаас өмнөх 4 жилийн хугацаанд жилд дунджаар 75 мянган ажлын байр, үүний дотор 45 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй байсан бол цар тахлаас хойших онуудад жилд дунджаар 85 мянган ажлын байр, үүнээс 52 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй болж нэмэгдсэн байна. Түүнчлэн уул уурхай, боловсруулах зэрэг салбаруудад хэрэгжих томоохон бүтээн байгуулалтын төслүүдэд ойрын жилүүдэд урьдчилсан байдлаар 12 мянган⁶ ажлын байр шаардагдахаар байх тул хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

⁵ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа

⁶ Мега төслүүд хариуцсан салбар яамд болон төслүүдийн ТЭЗҮ-ээс авсан урьдчилсан судалгаа

Эдгээрийн үр дүнд ажилчдын тоо 2026 онд 1 сая 386 мянгад хүрч, цаашид өсөлтөө тогтвортой хадгалан 2027-2028 онд ойролцоогоор 1 сая 450 мянгад хүрэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, сонирхол нэмэгдсэнээр ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурна гэж таамаглаж байна. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшнийг 2026 онд 62.6 хувь, цаашлаад 2028 онд 64.5 хувьд хүргэх бөгөөд 2026-2028 онд ажилгүйдлийн түвшин 5.5 хувь орчимд хэлбэлзэх хандлагатай байна.

1.2.6. Гадаад худалдааны урсгал тэнцэл


Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2026-2028 онд дунджаар 3.2 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна.

Нийт экспорт 2026 онд 18.0 тэрбум ам.доллар, 2027 онд 18.3 тэрбум ам.доллар, 2028 онд 19.2 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 2026-2028 онд дунджаар 3 орчим хувиар өсөхөөр төсөөлж байна. Тухайлбал, дунд хугацаанд нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсэнд эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөхийн зэрэгцээ Оюу Толгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэж, экспортын орлогыг нэмэгдүүлэхээр байна. Мөн Баянхонгор аймаг дахь Баянхөндий төслийн олборлолт эхлэх, алтны олборлолтыг дэмжих арга хэмжээнүүд хэрэгжих зэргээс шалтгаалан алтны экспорт 2026 онд 20 тонн, 2027-2028 онд 24 тоннд хүрч нэмэгдэхээр байна. Түүнчлэн, төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, Гашуунсухайт, Шивээхүрэн болон Ханги боомтын хил холболтын ажлыг 2027 онд бүрэн хэрэгжүүлж дууссанаар нүүрсний экспорт 2027 онд 95 сая тонн, 2028 онд 100 сая тонн, төмрийн хүдрийн экспорт 2027-2028 онд 9.6 сая тоннд хүрч тус тус нэмэгдэхээр байна.

Хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр ноолуур, арьс шир, малын мах зэрэг уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 2026-2028 онд дунджаар 10 орчим хувиар өсөхөөр байна.

Нийт импорт 2026 онд 14.2 тэрбум ам.доллар, дунд хугацаанд буюу 2028 онд 16.4 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, өмнөх онуудад эхэлсэн төслүүд болон 2026 оноос бүтээн байгуулалт шинээр эхлэх зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс-химийн цогцолбор зэрэг том төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр импортын өсөлт дунджаар 8 орчим хувьд хадгалагдахаар байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтуудын хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Зураг 1.14 Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн төсөөлөл (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Гаалийн ерөнхий газрын статистик

1.2.7. Төлбөрийн тэнцэл

Дунд хугацаанд манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ буурах төлөвтэй байгаа нь урсгал дансны алдагдал нэмэгдэх дарамтыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар гадаад зах зээлээс татах хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, зээлжих зэрэглэлийг үргэлжлүүлэн ахиулах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаад зах зээлээс хөрөнгө татах өртөг, зардлыг бууруулах бодлогыг баримталж байна. Түүнчлэн, өрийн удирдлагын хүрээнд 2026-2028 онд төлөгдөх “Номад”, “Сенчири-1”, “Сенчири-2” бондын нийт 1.1 тэрбум ам.долларын төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар төлөх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөн

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын дагуу “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг 2022-2026 онд хэрэгжүүлж байна. Энэхүү хөдөлгөөн нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлэх зорилготой. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, газар тариалан, мал аж ахуй болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд нийт 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Тус хөдөлгөөний үр дүнд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, гурил ба гурилан бүтээгдэхүүн, өндөг, цөцгийн тос, элсэн чихэр, цөцгийн тос, төрөл бүрийн будаа, жимс, жимсгэнэ зэрэг гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цаашлаад хүнс экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх юм. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 2022-2026 онд нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 оны улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлж байна. 2024 оны эцсийн байдлаар арилжааны банкаар дамжуулан 5-6 хувийн хүүтэй, 3-5 жилийн хугацаатай, нийт 1,261 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3,160 аж ахуйн нэгжид олгосон байна. Нийт олгосон зээлийн 65 хувийг хүнсний, 27 хувийг газар тариалан, 8 хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлж байна.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн үр дүнд хүнсний салбарт 39 үйлдвэр шинээр ашиглалтад орсон ба газар тариалангийн салбарын зоорины хүчин чадал 2021 оны суурь түвшинтэй харьцуулахад 62.2 мянган тонноор нэмэгдэж, 292.2 мянган тонн болжээ. Тус хөдөлгөөний үр дүнд 19 гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаснаар нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт буурч, иргэдийн бодит орлого нэмэгдэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой.

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

“Цагаан алт” хөдөлгөөн

Монгол Улс жилд дунджаар 30-35 мянган тонн хонины ноос, 10 мянга орчим тонн ямааны ноолуур, 2 мянга орчим тонн тэмээний ноосны түүхий эдийн нөөцтэй байна. Бэлтгэсэн түүхий эдийн нөөцийн 70-75 орчим хувийг угаан экспортолж байна. Тухайлбал, ямааны ноолуурын боловсруулалтын түвшний хувьд 70 орчим хувийг угааж, 10 орчим хувийг самнаж, 20 орчим хувиар бэлэн бүтээгдэхүүн болгож байна. Харин хонины ноосны 75 орчим хувийг угааж, 25 хувиар бэлэн бүтээгдэхүүн, тэмээний ноосны 90 хувийг угааж, 10 хувиар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Харин жилд дунджаар 18 сая ширхэг арьс, ширэн түүхий эд нөөц бэлтгэх нөөцтэй хэдий ч 30 хүрэхгүй хувийг нь боловсруулж, үлдсэн хувийг нь боловсруулж чадахгүй байна. Тухайлбал, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд 2023 онд нийт 5.5 сая ширхэг нь боловсруулсны 3.3 сая ширхэгт хагас боловсруулалт, 2.3 сая ширхэгт гүн боловсруулалт хийсэн бол 12.5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй байна.

Иймд уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн ноос, ноолуурын нөөцийг дотооддоо бүрэн боловсруулж, нэмүү өртөг болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар боловсруулах салбарын өсөлтийг хадгалж, экспортын орлогыг дэмжих боломжтой. Энэ хүрээнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын дагуу “Цагаан алт” хөдөлгөөнийг эхлүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр заасан.

“Цагаан алт” хөдөлгөөн нь салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих, үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах гэсэн үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжинэ. Тус хөдөлгөөний хүрээнд 2028 он гэхэд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20 хувиас 40 хувьд, ноосны боловсруулалтын түвшнийг 25 хувиас 55 хувьд, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30 хувиас 50 хувьд хүргэж нэмэгдүүлэх зорилтыг тавьсан. Эдгээр зорилт, арга хэмжээ нь боловсруулах салбарын өсөлтийг дэмжихэд чухал нөлөөтэй байна.

Хүснэгт 1.3 Цагаан алт хөдөлгөөний зорилт

Хүрэх үр дүн			Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилт 2028
Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинд нэмэгдүүлнэ			хувь	20	40
Ноосны боловсруулалт, ашиглалтын хувь хэмжээг нэмэгдүүлнэ			хувь	25	55
Арьс, ширний ашиглалт, гүн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ	Гүн боловсруулалтын түвшин		хувь	30	50
	Арьс, ширний ашиглалт	Гүн боловсруулсан	сая, ширхэг	2.3	4.0
		Хагас боловсруулсан		3.3	5.2
		Боловсруулаагүй		12.5	8.8

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”

Монгол Улсын тариалангийн талбайн 61.6 хувь нь хүчтэй элэгдсэн, 47.7 хувь нь маш бага үржил шимтэй байна. Газар тариалангийн салбарын хөрөнгө оруулалт алгуур нэмэгдэж, тариалсан талбайн хэмжээ өсөж байгаа ч таримал ургамлын үр сортын тогтолцоо алдагдсан, таримлын үрийн чанар, үр үйлдвэрлэл, хуваарилалтын тогтолцоо бүрдээгүй, нутагшсан сортын үрийн хүрэлцээ хангамж дутагдах зэрэг асуудлууд нь газар тариалангийн салбарын бүтээмж, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байна. Иймд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах зорилгоор “Атар-4” аяныг хэрэгжүүлэхээр тусгасан. Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилго нь тариалангийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хөрс, уур амьсгалын онцлогт тохирсон шинэ болон ашигт таримлыг нутагшуулах, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар газар тариалан, мал аж ахуйн төгс хослолыг бий болгож, төвийн бүсийг хөдөө аж ахуйн жишиг бүс болгон хөгжүүлэхэд чиглэж байна.

Энэ хүрээнд эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах, тариалангийн талбайн хөрсний элэгдэл эвдрэлийг хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттай нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлэх, үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх усалгааны дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тус аяныг хэрэгжүүлснээр хөдөө аж ахуйн салбарын боломжит нөөцийг бүрэн ашиглах, өртөг

шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амыг баталгаат хүнсээр, үйлдвэрлэлийг түүхий эдээр тогтвортой хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрч эдийн засагт тодорхой өсөлт бий болно гэж хүлээж байна.

Атар-4 аяны хүрээнд газар тариалангийн талбайг 200 мянган га талбайгаар нэмэгдүүлэх, гурилыг дотоодоос 100 хувь хангах, үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн тэжээлийг 200 мянган тонноор нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Мөн газар тариалангийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэхэд мах, сүүний кластер байгуулах, агуулахын хүчин чадлыг 100 мянган тонноор нэмэгдүүлэх, өвлийн хүлэмж байгуулах зэрэг зорилт, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр зорилт, арга хэмжээ нь хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт дунд хугацаанд тогтвортой хадгалагдахад гол нөлөө үзүүлнэ.

Хүснэгт 1.4 Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилт

Хүрэх үр дүн		Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилт 2028
Газар тариалангийн талбайг 200 мян.га-аар нэмэгдүүлэх		мянган га	962.0	1,162.0
Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. Үүнд:	Малын тэжээл тариалалтын талбайг 105 мян.га-аар	мянган га	94.9	200.0
	Малын тэжээл үйлдвэрлэл 353 мян.тонн-оор	мянган тонн	246.9	600.0
	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл 200 мян.тонн-оор	мянган тонн	278.0	390.0
Дотоодын гурилын хангамж		хувь	59.1	100.0
Мах, сүүний кластер байгуулах хүрээнд үүлдрийн үхрийг 200 мянгаар		кластерийн тоо	-	15.0
Агуулахын хүчин чадлыг 100 мян.тонн-оор нэмэгдүүлэх		мянган тонн	355.0	455.0
Шинээр болон сэргээн засах усалгаат тариалангийн талбайг 10 мян.га-аар нэмэгдүүлэх		мянган га	63.4	73.4
Ойн зурвас 20 сая мод тарина		км	3,557.0	10,000.0
Өвлийн хүлэмж байгуулна 50 га		га	39.1	89.0

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Бизнесийн орчныг үнэлдэг индексүүд нь улс орнуудын бизнес эрхлэх орчны чанарыг харьцуулж, сайжруулах шаардлагатай чиглэлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Манай улс Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхүй (Doing Business)-н индексээр 2020 онд 190 орноос 81 дүгээр байранд эрэмбэлэгдсэн. Тус индекс 2020 оноос хойш дахиж зарлагдаагүй явсаар мэдээлэл цуглуулах хүрээг өргөтгөн, судалгаан дахь чанарын үзүүлэлтүүдийг нэмэгдүүлж 2024 оноос Бизнес бэлэн (B-Ready буюу Business Ready) нэрээр дахин зарлаж эхэлсэн (манай улсыг 2026 оноос үнэлнэ) байдаг.

Бизнес эрхлэхүйн индексийн шалгуур үзүүлэлтүүдийг судалж үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1.5 Бизнесийн эрхлэхүйн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, шалгуур үзүүлэлтээр

	Оноо	Байр	Децил
Бизнес эхлүүлэх	86.9	#100	VI
Барилгын зөвшөөрөл	78.2	#29	II
Эрчим хүч холболт	54.9	#152	IX
Өмч бүртгүүлэх	74.1	#50	III
Зээл авах	80	#25	II
Жижиг хөрөнгө оруулагчдын	68.3	#25	II
Татвар төлөлт	77.3	#71	IV
Гадаад худалдаа	66.9	#143	VIII
Гэрээний хэрэгжилт	61.4	#75	IV
Төлбөрийн чадваргүй байдал	29.4	#150	VIII
Нэгдсэн индекс	67.7	#81	V

Тайлбар: Децил нь нийт индексийг тооцдог улс орнуудыг эрэмбэлэн, тэнцүү 10 бүлэгт хувааж харуулна.

Бизнес эхлүүлэх үзүүлэлтээр 190 орноос 100 дугаарт жагссан байна. Одоогийн байдлаар манай улсын хувьд шинэ бизнес бүртгүүлэхэд 7 үе шат дамжиж, 10 хоног зарцуулж байх бол 14 дүгээрт жагссан Эстони улс 3 үе шатаар 3.5 өдөрт бүртгүүлж байна.

Бизнес эхлүүлэхэд тулгардаг бэрхшээлийн нэг нь тусгай зөвшөөрөл авах үйл явц байдаг. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах ажил үргэлжлэн явагдаж тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем (www.license.mn)-д одоогоор 30 яам, агентлаг холбогдоод байгаа боловч зөвшөөрөл олгох хугацаа харилцан адилгүй байна. Тухайлбал, дунджаар Гаалийн ерөнхий газар 67 хоног, Эрүүл мэндийн яам 54 хоног, Боловсролын яам 49 хоног зарцуулж байна.

Эрчим хүчинд холбогдох үзүүлэлтээр Монгол Улс 190 орноос 152 дугаар байранд буюу IX децилд эрэмбэлэгдсэн нь манай улсын хувьд хамгийн сул үзүүлэлт болжээ. Бизнесүүд эрчим хүчинд холбогдох одоогоор 8 үе шат дамжиж, дунджаар 51 хоног зарцуулж байна. Үүнээс гадна цахилгаан хангамжийн найдвартай байдал, цахилгаан тасалдал нь бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж байна.

Өмч бүртгүүлэх үзүүлэлтээр 190 орноос 50 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Манай улсад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 5 үе шатаар дамжин хийгдэж, 11 өдөр зарцуулдаг бол энэхүү үзүүлэлтээр 1 дүгээрт жагссан Катар улсын хувьд ганц шаттай, ганц л өдөр зарцуулдаг байна. Түүнчлэн газар өмчлөлийн мэдээллийн ил тод бус байдал, бүртгэлийн системийн уялдаа сул, гомдол гаргах хараат бус механизм байхгүй зэрэг нь оноо алдах хүчин зүйлс болжээ.

Зээл авахтай холбоотой үзүүлэлтээр 190 орноос 25 дугаар байранд буюу харьцангуй сайн үнэлгээтэй боловч зээлийн хүү өндөр байгаа нь томоохон асуудал болж байна. Зээлийн хүү өндөр байгаа шалтгаан нь зах зээл дээр илүүдэл мөнгө ихтэй, инфляц өндөр байгаатай холбоотой. Төв банк бодлогын хүүг бууруулахад илүүдэл мөнгө зах зээлд орж, инфляцын эрсдэл нэмэгддэг. Иймд зах зээл дээрх мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах, төв банкны алдагдлыг бууруулах шаардлагатай байна.


Татварын орчны үзүүлэлтээр 190 орноос 71-т бичигдсэн. Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хамгийн сүүлд шинэчилж зарлагдсан хугацаа буюу 2022 оны байдлаар Вьетнам, Казакстан зэрэг улсад 20 хувьд хүрэхгүй байх бол манай улсад 25 хувь, 2024 оны байдлаар 34 хувьд хүрч өссөн үзүүлэлттэй байна. Мөн татаас, дэмжлэгийн үр ашиггүй байдал зах зээлийн гажуудал үүсгэж, бизнесийн орчныг хязгаарлаж байна. Жишээлбэл, 2007 оноос

хойш хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн 12 хөтөлбөрийн ихэнх нь анхны зорилгодоо хүрээгүй⁷ гэж дурджээ.

Бизнес эрхлэхүйн индексийн гадаад худалдааны хэсэгт манай улс 190 орноос 143 дугаар байранд жагссан нь голчлон экспорт хийхэд хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх хугацаа, баримт бичгийн шаардлага хангах хугацаа урт байгаа нь нөлөөлжээ. Экспортын бичиг баримт бүрдүүлэхэд 168 цаг, хил нэвтрэхэд 134 цаг, импортын бичиг баримт бүрдүүлэхэд 115 цаг зарцуулж байгаа талаар индексийн тайланд дурдсан байна.

Гэрээний хэрэгжилт үзүүлэлтээр 190 орноос 29 дүгээр байранд жагсаж байна. Уг хэсгийн шүүхийн процесстой холбоотой индекс хамгийн муугаар үнэлэгдсэн байна. Энэ нь тухайлбал, зөвхөн арилжааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн нэгжтэй эсэх, бага үнийн дүн бүхий нэхэмжлэлтэй хэргийг хялбараар шийдэх механизмтай эсэх, хэрэг шийдвэрлэх цахим арга хэрэгсэлтэй эсэх, шүүхийн автоматжуулалт зэрэг үзүүлэлтүүдтэй холбоотой байна. Иймд шүүхийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, хараат бус байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үзүүлэлтээр манай улс хойгуур буюу VIII децилд жагсжээ. Тус тайланд шүүхээр дамжин бизнесийн зээл, авлага барагдуулахад 4 жил зарцуулдаг, маргаан шийдвэрлэх хугацаанд нийт зээл, авлагын 15 хувийг шүүхийн зардалд зарцуулж, зээл, авлагын 18.2 хувийг эргүүлэн олж авдаг нь бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг байна.



Засгийн газрын хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл

Эдийн засаг, хөгжлийн яамнаас бизнесийн орчны үнэлгээг судалж Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулснаар дээр дурдсан зарим үзүүлэлтийг сайжруулах талаар тусгасан хуралдааны тэмдэглэл гарч холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгөгдөөд байна. Үүнд:

- Хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх бизнесийн төрлийг цөөлж оновчтой тогтоох;
- Цахилгаан эрчим хүчинд холбогдох зөвшөөрөл олгох, холболт хийх хугацааг 40 хоногт багтаах;

- Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, үйл ажиллагааг www.license.mn-д нэгтгэх, цахимаар шийдвэр гаргах хугацааг тогтоох, төрийг үйлчилгээний нэгдсэн системд холбох;
 - Төрөөс зах зээлд нөлөөлөх аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхийн өмнө үр дүн, зорилттой уялдуулж үе шаттай хэрэгжилтийг дүгнэж, зогсоох стратеги (exit strategy)-ийг боловсруулдаг байх;
 - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа татаас, дэмжлэгийн үр ашигт дүн шинжилгээ хийж, үе шаттайгаар багасгах, зогсоох талаар санал боловсруулах;
- ҮЦТХТ-өөс өмчлөх эрхийн тухайлсан бүртгэл, хадгаламжийн үйл ажиллагааг брокер, кастодианд шилжүүлэх боломжийг судлах.

⁷ “Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан”, НҮБХХ, 2023

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, эрчим хүчний хараат байдлыг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Төслүүдийн бэлэн байдлаар мега төслүүдийг ангилан авч үзвэл хэрэгжиж эхэлсэн 5 төсөл, бэлтгэл ажил хангагдсан 5 төсөл, нэмэлт судалгаа хийх шаардлагатай 4 төсөл байна. Хэрэгжиж эхэлсэн төслүүд амжилттай хэрэгжсэнээр экспортын орлогыг хоёр дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадлыг гурав дахин, импортыг орлох экспортын бүтээгдэхүүн хөгжүүлж олон улсын зах зээлд өрсөлдөх, шинээр бий болох ажлын байрны тоог нэмэгдүүлэх замаар бүс нутгийн хөгжилд ахиц дэвшил гарах томоохон бүтээн байгуулалтууд бий болох ба төслүүдийн харилцан хамаарал, эрчим хүч болон усны хэрэгцээ шаардлагыг хангах төслүүдийн үр дүнд эрчим хүчний эх үүсвэрийн хомсдолоос гарч эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт гарч, эерэг нөлөөг авчирна гэж тооцож байна.

Хэрэгжиж эхэлсэн төслүүд

1.1. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгууллаа. Тус төсөл хэрэгжсэнээр Экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал хэмжээг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэнэ.

2. Монгол-Францын хамтарсан ураны төсөл

Монгол Улсын Засгийн газар Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч, Бүгд Найрамдах Франц улсад бүртгэлтэй “Орано Майнинг” компанитай хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Тус төслийн хүрээнд Зөөвч-Овоо, Дулаан-Уул ураны ордуудыг газрын доор уусган олборлох технологиор ашиглах ба жилд 2,500 тонн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хугацааны турш улс, орон нутагт 5.2 тэрбум ам.долларын татвар төвлөрүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр Франц, Европын Холбооны стандартад нийцсэн уран олборлох шинэ техник технологийг нутагшуулж, шинэ төрлийн үйлдвэр баригдах, нарийн мэргэжлийн, өндөр үнэлэмжтэй 1,600 мэргэжилтэн бэлтгэж, Монгол иргэдээс чадварлаг хүний нөөц бүрдүүлнэ.

3. Газрын тос боловсруулах үйлдвэр

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн нэмэлт гэрээний зүйл заалт тус бүрээр хэлэлцээ хийж, 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Монгол улсын Сангийн яам, БНЭУ-ын Экспорт-Импортын банк хооронд үзэглэсэн. “Монгол Улсад Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн бүтээн байгуулалтыг дэд бүтцийн дараалал, барилга байгууламж тус бүрийн төвөгшил болон инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг тооцсоны үндсэн дээр нийт 4 багц хэсэгт хуваан 2028 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Тус төслийг хэрэгжүүлснээр импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

4. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц

Баруун бүсийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилготой Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийн хувьд өнгөрсөн хугацаанд ашиглалтын далангийн суурийн ажил, кемпийн байр, хүнд даацын автомашин өнгөрүүлэх гүүр, хоолой, кольц, техник засварын цехийн талбай болон байгаль орчин, археологи,

палеонтологийн хайгуул судалгаанууд хийгдэж дууссан. Энэ онд БНХАУ-ын Эксим банкны 79.9 сая ам.долларын санхүүжилтээр үндсэн зураг төсөл, барилга угсралтын ажлууд хийгдэхээр төлөвлөж байна.

5. Нүүрс-хими, кокс-химийн цогцолбор

Тус төсөл нь металлургийн үйлдвэрлэлийг эх орондоо хөгжүүлэх, улмаар гарган авсан коксыг өндөр үнэтэйгээр экспортлох боломж бий болгохоос гадна коксын үйлдвэрлэлийг дагалдан хөгжүүлэх шаардлагатай химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой. “Нүүрс-химийн цогцолбор” төслийн хүрээнд нийгэм, эдийн засагт өндөр ач холбогдолтой “Хөх нүүрсний үйлдвэр”-ийн эхний шатыг 2026 онд барьж ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Нийт 850 мянган тонн хөх нүүрс, 77 мянган тонн давирхай, 880 сая кВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн шаардагдах хөрөнгө оруулалт 190 сая ам.доллар байна.

Бэлтгэл ажил хангагдсан төслүүд

1.2. Шивээхүрэн-Сэхээ хил дамнасан төмөр зам

Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын суурь бүтцийг барьж байгуулснаар Нарийнсухайтын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн экспортод гаргах шинэ хилийн гарц нээгдэж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 10 сая тонноор нэмэгдэнэ. Монгол Улсын төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх, дотоодын төмөр замын сүлжээг нэмэгдүүлэх, хилийн боомтын шинэ гарц бий болгох, уул, уурхай бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын барилгын ажил төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр бүрэн дууссан.

1.3. Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр зам

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын А/299 дугаар тушаалаар байгуулагдсан Техникийн комисс 2023 оны 01-ны өдрийн 16-19-ний өдрийн хооронд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтцийн барилгын ажлын нийт гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үүрэг даалгавар өгсөн. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар 2023 оны эхнээс зүгшрүүлэх тээвэрлэлт эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Ханги-Мандал хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх юм. Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр замын төсөл хэрэгжсэнээр Тавантолгой-Ханги чиглэлд нүүрсний экспорт жилд 13-15 сая тонноор нэмэгдэж, нийтдээ уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ жилд 20-25 сая тоннд хүрэх боломжтой болно. Улаанбаатар төмөр замын Замын-Үүд-Эрээн боомтоор нэвтэрч буй ачаа тээврийн ачааллыг бууруулж, экспорт болон транзит тээврийн урсгалыг нэмэгдүүлнэ.

6. Зэс боловсруулах цогцолбор

Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ. Жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ.

7. Гангийн цогцолбор

Уг төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Эхний ээлжид 100.0 мянган тн хүчин чадалтай шууд ангижруулах төмрийн үйлдвэрийг барьснаар “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааг тогтвортой болгож, цаашлаад 1.2 сая тн ган хайлуулах үйлдвэрийг барьж байгуулна.

8. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц

Говийн бүсийн стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, тэдгээрийг дотоодын эрчим хүчний системээс хангаж, импортын эрчим хүчний хэрэглээг хязгаарлан

жилд 120-140 сая ам.долларын гадагш чиглэсэн валютын урсгалыг дотооддоо үлдээж, улс болон орон нутгийн төсөвт жилд 34.5 сая ам.долларын татвар, хураамжийг төвлөрүүлнэ.

“Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК нь төслийг эхлүүлэхэд шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл холбогдох судалгаа тооцоолол, зөвшөөрөл, техникийн нөхцөл, газар эзэмших эрх авах зэрэг бэлтгэл ажлуудыг бүрэн хангасан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 132 дугаар “Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тогтоолоор төслийг 300МВт+150МВт гэсэн 2 үе шатад хуваан, эхний ээлжид 300МВт-аар төслийн барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатган (EPC+F) хэлбэрээр зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

9. Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц

ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 46 дугаар хуралдаан Энэтхэг Улсад 2024 оны 07 дугаар сард зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанаас Монгол Улстай холбоотой “Сэлэнгэ мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт усан цахилгаан станц барих төслүүд: Монгол Улс саяхан усан цахилгаан станцын хоёр төслөө зогсоохоор шийдсэн бол гурав дахь төсөл болох Эгийн голын усан цахилгаан станцын төслийг үргэлжлүүлэхээр ажиллаж байна. Гишүүн Монгол Улсын Засгийн газар уг төслийн Сэлэнгэ мөрний ус хурах талбай болон өвийн хүрээнд багтаж буй түүний дельтад үзүүлэх нөлөөллийг үнэлэх зорилгоор олон улсын стандартын шаардлагад нийцсэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахаар зорьж байна.” гэсэн шийдвэрийн төсөл батлагдсан.

Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос-Монголын хамтарсан шинжээчдийн багийн дүгнэлтийг 2026 оны эхний хагаст гаргахаар төлөвлөж байна. Тус ажлын хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын Шинжлэх Ухааны Академиуд хамтран Сэлэнгэ мөрний экологийн урсцыг хангасан ашиглалтын горимын хувилбарыг санал боловсруулах зорилгоор “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажлыг Монгол-Оросын экспертийн ажлын хэсэг хамтран хийхээр тохирсон.

Уг төсөл хэрэгжсэнээр 5.7 тэрбум м³ хэмжээний цэвэр усны нөөц бүрдэж, жилд 606 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна.

10. Хэрлэн-тоонот, Орхон-онги ус дамжуулах хоолойг барих

Монгол орны агаарын дундаж хэм сүүлийн 80 жилд 2.25 хэмээр дулаарсан нь дэлхийн дунджаас даруй хоёр дахин өндөр байна. 2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Мөн сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрч байгаа нь цөлжилтийн үндсэн шалтгааны нэг болж байна. Дэлхийн дулаарлын нөлөөгөөр Монгол орны томоохон голуудын урсац эрс багасаж, жижиг гол, горхи, нуур цөөрөм ширгэж, голуудын эрэг татам дагуух экологийн тэнцвэрт байдал алдагдаж, хуурайшилт хүчтэй явагдаж байгаа тул экосистемийг тэтгэх үндсэн нөхцөл болох усны нөөцийг хуримтлуулж гадаргын усыг ашиглах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Уг төсөл хэрэгжсэнээр хүлэмжийн хийн ялгарлыг 30 мянган тонн оор бууруулж, 51.6 тэрбум м³/с цэвэр усыг хуримтлуулна. Говийн бүс нутаг дахь эдийн засгийн хөгжил, хуурайшилтыг багасгах, нэмэлт усны нөөц нь хот суурин газар руу чиглэх хүн амын төвлөрөлтийг багасгах, хүн ам, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг хангах, цөлжилтийг бууруулах, отор нүүдлийг багасгах олон талын ач холбогдолтой.

Нэмэлт судалгаа шаардлагатай төслүүд

11. Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам

“Чойбалсан - Бичигт” чиглэлийн төмөр замын төслийн Техник-Эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК болон “Ниппон коей” компаниудын 2013 оны 02 дугаар сард хийсэн “Монгол Улсын шинэ төмөр замын төслийн техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээ-зураг төслийн тайлан”-г орчуулж ТЭЗҮ-г

боловсруулахаар ажиллаж байна. Уг төсөл хэрэгжсэнээр Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр зам нь Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгаар дамжин өнгөрөх бөгөөд “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Эрээнцав - Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замтай холбогдоно.

12. Алт цэвэршүүлэх үйлдвэр

Алт цэвэршүүлэх үйлдвэрийг дотооддоо байгуулж ашиглалтад оруулснаар Монгол Улсын газрын хэвлий доорх алт, мөнгө, үнэт металлыг өөрсдөө боловсруулж, дэлхийн стандартад нийцсэн алтан болон мөнгөн гулдмай, бэлэг дурсгалын гулдмай, үрэл, ялтас зэрэг цэвэршүүлсэн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэж эхлэх юм.

Манай улс ОХУ, Их Британи, Япон зэрэг улсад алтаа цэвэршүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Швейцар улсад цэвэршүүлж байна. Ингэж цэвэршүүлж байгаа алтны боловсруулалт, тээвэр, даатгал, хамгаалалтын зардал өндөр байхаас гадна дотоодоо олборлон баяжуулж байгаа алт нь дунджаар 85.0 хувийн агуулгатай бөгөөд түүнийг олон улсын зах зээлд борлуулахын тулд 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай байгаа юм.

13. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр

“Нарны цахилгаан станцын төсөл”-ийн төслийг өрсөлдөөнт худалдан авалтын аргаар зохион байгуулахаар “Европын сэргээн босголтын банк”-тай хамтран ажиллаж нэгдсэн сүлжээнд холбох оновчтой байршлыг тогтоон, холбогдох ажлуудыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнд нарны цахилгаан станцыг тархмал байдлаар хэрэгжүүлэх боломжтой үр дүн гарсан. Нарны эх үүсвэрийг нийт бүс нутгийн хэмжээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд цахилгаан дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадвар, системийн шингээх боломжийн талаарх судалгааг “ДҮТ” ТӨХХК-тай хамтран боловсруулж байна. Тус тооцоо, судалгааны үр дүнд үндэслэн төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба төслийг сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Уг төсөл хэрэгжсэнээр нар, салхины эх үүсвэрээс 1.38 тэрбум кВт.ц эрчим хүч үйлдвэрлэнэ. Нар, салхины эх үүсвэрээс 1 кВт.ц-ын тариф 4-5 цент буюу хямд үнэ бүхий цэвэр эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах боломжтой. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 586,5 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг салхин станц 693.6 мянган тонн, нарны цахилгаан станц 244.8 мянган тонноор тус тус бууруулна.

14. Үндэсний хиймэл дагуул

Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулыг хөөргөснөөр Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан, орон зайн ялгаваргүй харилцаа холбооны бие даасан сүлжээ үүсгэж интернэт суурьтай бүх төрлийн харилцаа холбооны үйлчилгээг бүх иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх боломжийг нээж өгнө. Түүнчлэн зөвхөн шилэн кабелийн сүлжээнээс хамаарсан интернэтийн гарцын эрсдэлийг бууруулах, онцгой байдлын үед байнгын харилцаа холбоотой байх, гамшиг ослын эрсдэлийг бууруулах, хот хөдөөгийн иргэдийн тоон ялгааг арилгах, хөдөө, орон нутгийн иргэд, малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цахим сургалтад хамрагдах боломж олгоно үзэж байна.

1.3. Макро эдийн засгийн төлөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцсон арга зүй, тооцооны үндэслэл⁸

Макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг боловсруулах хүрээнд эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт талын нийцэл, бодит, төсөв, мөнгө, гадаад секторуудын үзүүлэлтүүдийн уялдааг хангахад ОУВС-гийн санхүүгийн програмчлал (financial programming)-ыг ашигласан болно. Түүнчлэн, уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүдийн богино, дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газраас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүдийн нөлөөг тооцоо, төсөөлөлд ашиглав. Мөн томоохон төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг салбар хоорондын тэнцэл болон хагас бүтцийн GAP шинжилгээгээр үнэллээ.

Мөн төсвийн секторын үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад бодит үйлчилж буй хувь хэмжээ (effective tax rate), татварын мэдрэмжийн аргачлалууд, эконометрик шинжилгээ, хугацаан цуваан эконометрик загваруудыг ашиглалаа.

Бодит үйлчилж буй хувь хэмжээний аргачлал нь хуульд заасан нэрлэсэн татварын хувь хэмжээ бус, харин тухайн аж ахуйн нэгж эсвэл өрхийн бодитоор төлсөн татварын хувь хэмжээг тооцдог, тодорхой орлого, ашигт ажиллагааны түвшинд ногдуулж буй татварын ачааллыг илүү бодитойгоор хэмжихэд чиглэсэн аргачлал юм. Энэхүү аргачлал нь бодитоор үйлчилж буй татварын ачаалал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нөлөө зэргийг илүү нарийвчлалтай тооцдог бөгөөд татварын бодлого, хувь хэмжээний өөрчлөлтийн нөлөөг үнэлэхэд өргөн ашиглагддаг. Харин татварын мэдрэмжийн аргачлал нь ДНБ, импорт, экспорт зэрэг макро үзүүлэлттэй уялдан татварын орлого хэрхэн өөрчлөгдөж байгааг хэмждэг. Уг үзүүлэлт нь татварын бодлого өөрчлөгдсөн болон өөрчлөгдөөгүй үед нийт татварын орлогын хариу үйлдлийг хэмждэг тул эдийн засгийн эрэлт, бүтцийн онцлог, татварын удирдлагын үр нөлөөг цогцоор нь илэрхийлдэг.

⁸ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "12.3.5.Макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл"

2. ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨСӨӨЛӨЛ⁹

2.1. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

2.1.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл

2023 оны гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 онд 23,294.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 5.9 хувиар буюу 1,297.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн гүйцэтгэлтэй гарлаа. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрсэн, Оюу толгойн далд уурхай ашиглалтад орсон, зэсийн баяжмалын экспорт сэргэсэн нь тус оны төсвийн орлогын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна. Мөн АМНАТ-ийг оновчтой бүрдүүлэх, олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оноос 2.7 их наяд төгрөгөөр буюу 51 хувиар, АМНАТ өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр буюу 43 хувиар, ААНОАТ 1.6 их наяд төгрөгөөр буюу 78 хувиар тус тус нэмэгдсэн нь төсвийн орлого бүрдүүлэлт өсөхөд нөлөөллөө. Мөн бүтээгдэхүүний цэвэр татварууд өмнөх оноос 971 тэрбум төгрөгөөр буюу 16 хувиар өссөн бөгөөд бүтцээр нь харвал дотоодын эдийн засаг идэвхжиж, уул уурхайн бүтээгдэхүүний гарц өндөр байсны нөлөөгөөр НӨАТ-ын орлого 22 хувиар, гадаад үйл ажиллагааны орлого 13 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин импортын дизель түлшний онцгой албан татварыг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл чөлөөлсөн¹⁰ шийдвэртэй холбоотойгоор онцгой албан татварын орлого 7 хувиар буурсан байна.

Хүснэгт 2.1 Нэгдсэн төсвийн 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2023 төл.	2023 гүйц.	2023 гүйц. хувь
Тэнцвэржүүлсэн орлого	21,997.9	23,294.9	105.9%
Татварын орлого	19,760.7	21,484.2	108.7%
Татварын бус орлого	2,237.2	1,810.7	80.9%

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 29,589.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6,294.4 тэрбум төгрөг буюу 27.0 хувиар өсөж, төлөвлөсөн хэмжээнээс 3.7 хувиар буюу 1,122.6 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Эдийн засгийн идэвхжил сайжирсан, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь ААНОАТ, НӨАТ-ын орлого өсөхөд голлон нөлөөллөө. Нэгдсэн

⁹ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.8.өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл, улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалтын талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд”

¹⁰ Засгийн газрын 2022 оны “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах арга хэмжээний тухай” 161 дүгээр тогтоол

төсвийн нийт орлого 2024 оны жилийн эцэст 31.4 их наяд төгрөгт хүрч өмнөх жилээс 7.0 их наяд төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн байна.

Өмнөх онтой харьцуулахад ААНОАТ 2.5 их наяд төгрөгөөр буюу 65.2 хувиар, НӨАТ 1.1 их наяд төгрөгөөр буюу 22.8 хувиар, ХХОАТ 757 тэрбум төгрөгөөр буюу 40.2 хувиар, онцгой албан татвар 300 тэрбум төгрөгөөр буюу 39.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөллөө. Орлогын өсөлтөд уул уурхайн салбарын идэвхжил хадгалагдаж, нүүрсний экспортын биет хэмжээ 2024 онд 83.8 сая тоннд хүрч өмнөх оноос 20.3 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 1 сая 695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11.2 хувиар өссөн нь тус салбараас төвлөрөх орлого өндөр хэвээр хадгалагдахад чухал нөлөө үзүүлсэн байна. Харин 2024 оны 4 дүгээр улиралд нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурсан нь төсвийн орлогод сөргөөр нөлөөллөө.

Хүснэгт 2.2 Нэгдсэн төсвийн 2024 оны төлөвлөгөө, урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024		2024
	төл.	урьд. гүйц.	гүйц. хувь
Тэнцвэржүүлсэн орлого	30,711.9	29,589.3	96.3%
Татварын орлого	27,912.1	27,377.5	98.1%
Татварын бус орлого	2,799.8	2,211.8	79.0%

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны төсөв: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн нийт орлогын жилд төвлөрүүлэх хэмжээг 36,435.6 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 33,470.0 тэрбум төгрөг байхаар баталсан. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний 3 сарын байдлаар 6,149.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,172.2 тэрбум төгрөг буюу 16.0 хувиар буурсан байна. Төсвийн орлого буурахад түүхий эдийн үнийн уналт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2.3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2023	2024	2025
	гүйц	урьд. гүйц	төл.
Тэнцвэржүүлсэн орлого	23,294.9	29,589.3	33,470.0
ДНБ-д эзлэх хувь	33.1%	37.0%	35.2%
Татварын орлого	21,484.2	27,377.5	31,557.3
Орлогын албан татвар	5,702.6	8,980.6	10,012.3
НӨАТ	4,777.0	5,864.3	7,431.0
Онцгой албан татвар	790.1	1,098.2	1,204.0
Бусад	10,214.5	11,434.4	12,909.9
Татварын бус орлого	1,810.7	2,211.8	1,912.7

Эх сурвалж: Сангийн яам

2.1.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт

2023 оны гүйцэтгэл: Төсвийн нийт зарлага 2023 онд 22,509.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 24.0 хувиар өссөн байна. Нийт зарлагын 17,091.4 тэрбум төгрөг буюу 15.8 нэгж хувийг урсгал зардал, 5,188.2 тэрбум төгрөг буюу 7.6 нэгж хувийг хөрөнгийн зардал бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталж, цалингийн суурь итгэлцүүрийг шинэчилж, тэтгэврийн зөрүүг арилгаж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, төрийн албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосон нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Тухайлбал, цалин хөлсний зардал 2023 онд 2,327.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 661.2 тэрбум төгрөгөөр буюу 39.7 хувиар, нийгмийн даатгалын болон халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 6,118.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2,217.6 тэрбум төгрөгөөр буюу 56.8 хувиар тус тус нэмэгдсэн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 2.4 Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2023 гүйц.	2024 урьд. гүйц.	2025 бат.
Төсвийн нийт зарлага	22,509.0	30,365.5	33,431.5
Өсөлтийн хувь	24.0%	34.9%	10.1%
ДНБ-д эзлэх хувь	32.0%	38.0%	35.2%

Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ-ны төсөөлөл

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 онд 33,573.1 тэрбум төгрөг батлагдсанаас урьдчилсан гүйцэтгэлээр 30,365.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 34.9 хувиар өсөж, 90.4 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Үүнээс урсгал зардал 22,066.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар өссөн бөгөөд төрөөс иргэдэд олгодог нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж 33.7 хувь, төрийн албан хаагчдад олгох цалин хөлс 24.3 хувь, төсөвт байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой урсгал зардал 18.5 хувь, хувийн болон төрийн байгууллагад олгосон татаас 4.3 хувь, гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 5.4 хувийг тус тус эзэлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлсэн иргэдийн бодит орлогыг хамгаалах бодлогын хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дунджаар 10 хувиар нэмэгдүүлснээр төсвийн цалин, урамшууллын зардал 5,363.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.3 дахин нэмэгдсэн нь урсгал зардлын өсөлтийн 17.8 нэгж хувийг, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 7,435.3 тэрбум төгрөгт хүрч 21.5 хувиар нэмэгдсэн нь нийт урсгал зардлын өсөлтийн 7.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2.5 Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Нийт зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал				Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл
		Цалин хөлс	БҮ-ний бусад	Зээлийн хүү	Татаас, шилж.		
Нэгдсэн төсөв	30,365.5	5,363.4	4,082.1	1,195.0	11,426.4	7,924.2	374.4
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>38.0%</i>	<i>6.7%</i>	<i>5.1%</i>	<i>1.5%</i>	<i>14.3%</i>	<i>9.9%</i>	<i>0.5%</i>
Улсын төсөв	21,161.0	4,734.6	2,988.7	1,124.9	7,017.9	5,035.6	259.2
Орон нутгийн төсөв	7,254.1	620.3	1,629.6	70.1	1,923.5	2,888.5	122.1
НДС	1,926.9	8.6	6.2	0.0	1,916.6	0.0	-4.4
ЭМДС	5,095.0	0.0	2.6	0.0	5,095.0	0.0	-2.5

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны төсөв: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнг 33,431.5 тэрбум төгрөг буюу анх батлагдсан дүнгээс 2,340.4 тэрбум төгрөгөөр бууруулсан.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2025 оны эхний 3 сарын байдлаар 6,502.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.2 хувиар, урсгал зардал 5,900.4 тэрбум төгрөгт хүрч 17.2 хувиар тус тус буурсан байна.

2.1.3. Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ

2023 оны гүйцэтгэл: Хөрөнгө оруулалтын чиглэлээр нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг 2023 онд нэн тэргүүнд санхүүжүүлэх, хэрэгжүүлж дуусгах, санхүүжилтийг бүрэн олгох бодлого баримталсан. Тус онд нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нийт 6,216.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 5,188.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 83.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс барилга байгууламж 3,727.3 тэрбум төгрөг, их засвар 172.3 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж 491.1 тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардалд 794.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Хөрөнгө оруулалтын зардлын 56 хувь нь улсын төсвөөс, 32 хувь нь гадаад зээлээс, 7 хувь нь гадаад тусламжаас, үлдсэн 7 хувь нь концессоос бүрдсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 7,917.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1143 төсөл, арга хэмжээнд 2,965.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, нийт гүйцэтгэл 2,857.4 тэрбум төгрөг буюу 96.4 хувьтай гарсан байна. Нийт санхүүжилтийн дүнгийн 17.8 хувь буюу 529.3 тэрбум төгрөг нь боловсролын салбарт, 13.8 хувь буюу 408.8 тэрбум төгрөг нь зам тээврийн салбарт, 11.6 хувь буюу 345.2 тэрбум төгрөг нь барилга хот байгуулалтын салбарт, 5.8 хувь буюу 172.1 тэрбум төгрөг нь эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн байна.

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Төсвийн хөрөнгө оруулалтын зардал 2024 онд нийт 10,386.3 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 7,924.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож, 76.3 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй байна. Үүнээс барилга байгууламж 5,383.5 тэрбум төгрөг 77.8 хувь, их засвар 304.1 тэрбум төгрөг 47.3 хувь, тоног төхөөрөмж 779.4 тэрбум төгрөг 83.2 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт (тодотгол) оруулснаар хөрөнгийн зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд энэ нь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, томоохон хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжихэд чиглэсэн.

Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын зардлын 67.9 хувийг барилга байгууламж, 18.3 хувийг бусад хөрөнгө, 9.8 хувийг тоног төхөөрөмж, 3.8 хувийг их засварт зарцуулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11,706.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,320 төсөл, арга хэмжээний 3,828.6 тэрбум төгрөгийг тус онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд урьдчилсан гүйцэтгэл 80.3 хувьтай буюу нийт 3,093.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

2025 оны төсөв: 2025 оны нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нийт 8,340.3 тэрбум төгрөг тусгасан ба нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэх зарчим баримталсан болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, гэрээ байгуулсан болон ажлыг эхлүүлсэн төслийг дуусгах зарчмыг баримталж, нийт 9,430.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 623 төсөл, арга хэмжээнд 3,231.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан. Нийт батлагдсан санхүүжүүлэлтийн 29.7 хувь буюу 959.2 тэрбум төгрөгийг зам тээврийн салбарт, 6.2 хувь буюу 198.9 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 11.0 хувь буюу 354.1 тэрбум төгрөгийг инженерийн дэд бүтцийн чиглэлээр, үлдсэн хөрөнгийг бусад салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2025 оны эхний улирлын байдлаар 113.5 тэрбум төгрөг буюу 3.5 хувьтай байна.

Хүснэгт 2.6 Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2023 гүйц.	2024 урьд. гүйц.	2025 бат.
Хөрөнгийн зардал	5,188.2	7,924.2	8,340.3
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	7.4%	9.9%	8.8%

Эх сурвалж: Сангийн яам

2.1.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд 785.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай, 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр -776.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д заасан зорилтот түвшний үзүүлэлтийг хангасан байна.

Хүснэгт 2.7 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-д эзлэх хувь)

Үзүүлэлт	2023 гүйц.	2024 урьд. гүйц.	2025 бат.
Хуулийн хязгаар	-3.6	-2.8	-2.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	1.1	-1.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны гүйцэтгэл: Монгол Улсын Засгийн газраас 2023 онд эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэх, уул уурхайн далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд төсвийн нийт орлого 24,387.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 31.7 хувиар өсөж, төсвийн нийт тэнцэл 1,878.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Цар тахал, геополитикийн тогтворгүй нөхцөл байдлын улмаас 2019-2022 онд алдагдалтай гарсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.


2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 оны жилийн эцэст 29.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.3 их наяд төгрөг буюу 27.0 хувиар өслөө. Зардал талаас нэгдсэн төсвийн нийт зарлага 30.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 34.9 хувиар өссөнөөр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр -776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2025 оны төсөв: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2025 оноос эхлэн тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасны дагуу тэнцвэржүүлсэн тэнцлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд 0.0 хувь буюу алдагдалгүй байхаар батлагдсан.

2.1.5. Улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалт

Улсын нийт гадаад өр: Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 37.1 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 25.5 тэрбум ам.долларыг аж ахуйн нэгжүүдийн гадаад өр, 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 1.8 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.7 тэрбум ам.долларыг арилжааны банкуудын өр тус тус эзэлж байна.

Зураг 2.1 Улсын нийт гадаад өрийн статистик (тэрбум ам.доллар)



* Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын өр: Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 30.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 43.7 хувийн гүйцэтгэлтэй, 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 33.4 их наяд төгрөг буюу өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 41.8 хувьтай тэнцэж нэрлэсэн үлдэгдлээр 1.2 их наяд төгрөгөөр буюу өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 13.8 хувиар буураад байна.

Хүснэгт 2.8 Засгийн газрын өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг)

Өрийн хэрэгсэл	2023	2024*
I. Засгийн газрын дотоод өр	234.1	400.5
1.1 Үнэт цаас	234.1	400.5
II. Засгийн газрын гадаад өр	30,274.6	30,247.8
2.1 Үнэт цаас	9,371.7	8,655.0
2.2 Зээл	20,902.9	21,592.7
III. Засгийн газрын бусад өр	264.8	2,736.4
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	29.5	178.0
3.2 Орон нутгийн зээллэг	4.5	2,588.4
3.3 “Барих-шилжүүлэх” төрлийн концесс	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I, II, III)	30,773.5	33,384.6

*Эх сурвалж: Сангийн яам * Урьдчилсан гүйцэтгэл*

Засгийн газрын өр 2024 онд өссөн голлох шалтгаан нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас дотоодын болон олон улсын зах зээлд 2.6 их наяд төгрөгийн үнэт цаас гаргасантай холбоотой байна.

Засгийн газрын гадаад зээл: Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны хооронд нийт 9,465.5 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчээс 346 төсөл хөтөлбөрт зарцуулсан байдаг. Үүнээс 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6,313.2 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

Гадаад зээлийн 1991 оноос хойш авч ашигласан хөрөнгийг төслийн зээлийн хүрээнд нийт 6,806.1 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,659.4 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг авч ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 51.3 хувийг дэд бүтцэд, 23.0 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 25.7 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 58.3 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 41.7 хувийг уул уурхай, эрчим хүч, орон сууц нийтийн аж ахуйн салбарууд тус тус эзэлж байна.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 2024 оны байдлаар 12.6 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэхүү ашиглагдаагүй үлдэгдэлд жил бүр хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр төлдөг бөгөөд гэрээ байгуулсан төслүүдэд нийт 50 орчим тэрбум төгрөгийг төлөхөөр байна. Түүнчлэн, хэлэлцээрт байгаа төслүүдийг авч ашигласнаар улсын төсвийн зарлагад эзлэх гадаад зээлийн ашиглалтын хэмжээний хязгаартай байдлаас шалтгаалж төслийн хэрэгжилт удаашрах эрсдэл өндөр байна.

Засгийн газрын үнэт цаас: Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 8,655.0 тэрбум төгрөг буюу 2,530.5 сая ам.доллартой тэнцэж байна.

Хүснэгт 2.9 Гадаад үнэт цаас, 2024.12.31-ний өдрийн байдлаар (тэрбум төгрөг)

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл сая \$	Үлдэгдэл тэрбум ₮
1	Номад	5.125%	5.5 жил	572.7	1,958.7
2	Сенчири-1 2027	3.500%	6 жил	420.1	1,436.8
3	Сенчири-2	8.650%	5 жил	510.7	2,309.2
4	Сенчири-3	7.875%	5.5 жил	675.1	1,203.6
5	Сенчири-1 2031	4.450%	10 жил	351.9	1,746.7
НИЙТ				2,530.5	8,655.0

Эх сурвалж: Сангийн яам


Засгийн газар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2026 онд төлөгдөх нөхцөлтэй “Номад” бондын төлбөрөөс 391.7 сая ам.долларын төлбөрийг, 2028 онд төлөгдөх нөхцөлтэй “Сенчири-2” бондын төлбөрөөс 108.3 сая ам.долларын төлбөрийг тус тус “Сенчири-4” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд шийдвэрлэсэн болно.

Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хүрээнд гадаад үнэт цаасны төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулж байна. Тухайлбал, 2024 оны 03 дугаар сард “Гэрэгэ” бондын 82 сая ам.доллартой тэнцэх хэсгийг, 2024 оны 03 дугаар сард “Хуралдай” бондын 53 сая ам.доллартой тэнцэх хэсгийг тус тус төлж, гадаад үнэт цаасны үлдэгдлийг бууруулсан. Түүнчлэн, 2024 оны 10-12 сард анх гаргасан үнээс бага үнэлгээтэй байсан “Номад” болон “Сенчири-1” бондуудын 98.9 сая ам.долларын төлбөрийг хугацаанаас нь өмнө төлж барагдуулсан болно.

Засгийн газар нь дунд хугацаанд өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын байр сууриас шалтгаалан шинээр хийх өрийн зохицуулалтын арга хэмжээний хугацаа, зардлын түвшин тодорхойлогдоно.

Олон улсын зах зээлд гаргасан манай улсын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх өгөөжийг доорх зурагт харуулав.

Зураг 2.2 Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж



Эх сурвалж: Блүүмберг терминал

АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трампын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хийсэн тарифын мэдэгдлээс шалтгаалж олон улсын санхүүгийн зах зээлд томоохон шок гарсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасны хоёрдогч зах зээл дэх өртгийн хэмжээ дунджаар 2.3 хувиар өссөн бөгөөд Монгол Улстай ижил зээлжих зэрэглэлтэй улсуудын үнэт цаасны өгөөж дунджаар 2.0 орчим хувиар өссөн байна.

Дээрх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2026 онд хүртэлх гадаад төлбөрийн дарамтыг бүрэн шийдвэрлэж байгаа бөгөөд 2026 онд Номад бондын 174.3 сая ам.доллар, 2027 онд “Сенчири” бондын 412.1 сая ам.доллар, 2028 онд “Сенчири-2” бондын 541.7 сая ам.долларын төлбөр тус тус хүлээгдэж байна. Тус төлбөрүүдийг Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн зорилтыг үргэлжлүүлж өрийн зохицуулалт хийх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэлтэй уялдуулан төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулах хэмжээг ихэсгэх төлөвлөгөөтэй байна.

Засгийн газрын дотоод үнэт цаас: Сангийн яамны зүгээс Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сараас эхлэн Монголбанкаар дамжуулан, 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тус тус нээлттэй хэлбэрээр арилжаалж эхэлсэн.

Засгийн газар 2012-2017 онд нийт 15.9 их наяд төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан бөгөөд Монголбанкны үнэт цаас 70 хувь буюу 11.1 их наяд төгрөг, Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаас 10 хувь буюу 1.6 их наяд төгрөгт, хаалттай хэлбэрээр арилжаалсан үнэт цаас 20 хувь буюу 3.2 их наяд төгрөгийг тус тус бүрдүүлж байна. Түүнчлэн 2013 онд арилжаалсан үнэт цаасны дундаж хүү 9.6 хувьтай тэнцэж байсан бол үнэт цаас гаргалтын хэмжээ, Төв банкны бодлогын хүү зэргээс хамаарч 2016 онд 16.9 хувь, 2017 онд 13.3 хувьд хүрч өссөн байна.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 400.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хүрээнд дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, арилжааг тогтмолжуулах, жишиг хүүг тогтоох зорилт тавьсны дагуу Сангийн сайдын 2025 оны 51 дүгээр тушаалыг баталж Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааны хуваарийг баталж, 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхэлж дотоодын хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна.

Орон нутгийн нийт өр төлбөр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад зориулж гаргаад байна.

2.1.6. Засгийн газрын болзошгүй өр төлбөр¹¹

Засгийн газрын болзошгүй өр төлбөр: “Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна.

Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг “Эрдэнэс Монгол” ХХК нь Засгийн газрын өрийн баталгаатай зээлийн төлбөрийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шинээр Засгийн газрын өрийн баталгаа гаргаад байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын өрийн баталгаатай зээлийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан. Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 8.6 сая ам.доллартой тэнцэж байсан бөгөөд 2024 оны 10 дугаар сард буюу эргэн төлөгдөх хугацаанаас өмнө төлж барагдуулсан болно.

Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна. Улсын Их Хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас 420.0 сая юаньтай тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай зээлийг Засгийн газрын өрийн баталгаатайгаар Хятадын хөгжлийн банкнаас авч ашигласан. Энэхүү зээлийг 2019 онд авч ашиглаж эхэлсэн боловч 2023 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдээс шалтгаалж Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах шаардлагатай болсон тул 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гаргуулсан болно. Уг зээлийн хугацаа 2031 онд дуусах бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкнаас хуваарьт үндсэн болон хүүгийн төлбөрийг тухай бүр бүрэн төлж барагдуулж байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар тус зээлийн үлдэгдэл төлбөр 178.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргасан Засгийн газрын баталгаа 2027 онд төлөгдөх хуваарьтай байна. Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 500 сая ам.долларын хэмжээтэй, 2.75 жилийн хугацаатай, 7.75 хувийн хүүтэй бондыг олон улсын зах зээлд Засгийн газрын өрийн баталгаатайгаар арилжаалсан. Тус үнэт цаас нь 2027 оны 8 дугаар сард төлөгдөж дуусах бөгөөд эхний хүүгийн төлбөр 2025 оны 8 дугаар сард төлөгдөхөөр байна. Энэхүү үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.7 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

¹¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.7.төсвийн болзошгүй өр төлбөр, түүний талаарх шинжилгээ”

2.1.7. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал¹²

2023 оны гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2023 оны гүйцэтгэлээр 23,294.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,509.0 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нийт зарлага болон эргэж төлөгдөх зээлд урсгал зардал 17,091.4 тэрбум төгрөг (75.9%), хөрөнгийн зардал 5,188.2 тэрбум төгрөг (23.0%), эргэж төлөгдөх цэвэр зээл 229.4 тэрбум төгрөг (1.0%)-ийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нэгдсэн төсвийн 2023 оны тэнцвэржүүлсэн орлогын төвлөрүүлэлт 105.8 хувийн, нийт зарлага 93.0 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 1,878.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Татварын орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 8.7 хувиар буюу 1,723.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол татварын бус орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 19.1 хувиар буюу 426.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

2024 оны урьдчилсан гүйцэтгэл: Нэгдсэн төсвийн 2024 оны тэнцвэржүүлсэн орлогын бүрдүүлэлт урьдчилсан гүйцэтгэлээр 96.6 хувийн, нийт зарлага 90.3 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Татварын орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 1.9 хувиар буюу 534.7 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн, татварын бус орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 21.0 хувийн буюу 587.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 29,589.3 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,365.5 тэрбум төгрөгт хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл -776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Нийт зарлага болон эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнд урсгал зардал 22,066.9 тэрбум төгрөг (72.7%), хөрөнгийн зардал 7,924.4 тэрбум төгрөг (26.1%), эргэж төлөгдөх цэвэр зээл 374.4 тэрбум төгрөг (1.2%)-ийн урьдчилсан гүйцэтгэлтэй байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2025 онд 33,469.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33,431.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 2.10 Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд, түүний гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2023 төл	2023 гүйц	2024 төл	2024 урь.гүйц	2025 бат
Төсвийн нийт орлого	23,039.6	24,387.1	32,478.9	31,375.1	36,435.6
Тэнцвэржүүлсэн нийт орлого	21,997.9	23,294.9	30,711.9	29,589.3	33,469.9
Төсвийн нийт зарлага	24,211.0	22,509.0	33,573.1	30,365.5	33,431.5
Урсгал зарлага	18,057.6	17,091.4	23,077.0	22,066.9	25,304.6
Хөрөнгийн зардал	6,216.8	5,188.2	10,386.3	7,924.2	8,340.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-63.4	229.4	109.9	374.4	-213.4

¹² Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "12.3.6.төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал"

Үзүүлэлт	2023 төл	2023 гүйц	2024 төл	2024 урь.гүйц	2025 бат
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,213.1	785.9	-2,861.2	-776.2	38.3
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>-2.6</i>	<i>1.1</i>	<i>-2.0</i>	<i>-1.0</i>	<i>0.0</i>

2.2. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны төсөөлөл

2.2.1. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2026-2028 оны төсөөлөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын¹³ дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 онд 33,479.5 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 2.11 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 Төсөөлөл
Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	33,479.5	35,628.6	39,086.0
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>31.7</i>	<i>30.4</i>	<i>29.6</i>

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг ОУВС-гийн бодит үйлчилж буй хувь хэмжээ (effective tax rate)-ний аргачлал болон бусад эконометрик тооцооллууд, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээний төсөөлөлд үндэслэн тооцлоо. Ирэх онуудад экспортын биет хэмжээ нэмэгдэхээс гадна нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсэнд эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөхийн зэрэгцээ Оюу Толгойн экспортын зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэхээр байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого өсөхөд эерэг нөлөө үзүүлэх бол нүүрсний үнийн чиг хандлага сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хувь хүний орлогын албан татвар: Ирэх онуудад ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдэх болон нэрлэсэн дундаж цалин дунджаар 14 орчим хувиар өсөх төсөөлөлтэй байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх бодлого нь тус татварын орлого тогтвортой өсөхөд эерэг нөлөө үзүүлнэ. Улмаар, хувь хүний орлогын албан татварын орлого 2026-2028 онд дунджаар 12.9 хувиар өсөхөөр тооцлоо.

Нэмэгдсэн өртгийн албан татвар: Тус татвар нь эдийн засгийн дотоод идэвхжил, иргэдийн худалдан авах чадварын ерөнхий байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. 2026-2028 онд НӨАТ-ын орлого эдийн засгийн дотоод эрэлтийн ерөнхий хандлагыг дагах суурь таамаглалыг дэвшүүлсэн. НӨАТ-ын нийт орлогын 60 орчим хувийг импортын албан татвар бүрдүүлдэг бөгөөд иргэдийн хэрэглээний өсөлт, хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэх нь тус орлогод чухал нөлөө үзүүлдэг. Ирэх онуудад Засгийн газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ болон хувийн секторын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өсөх хүлээлттэй байгаа нь гадаад НӨАТ-ын орлогод эергээр нөлөөлөх төсөөлөлтэй байна.

Онцгой албан татварын орлого: Ирэх онуудад боловсруулах салбар нэрлэсэн дүнгээр дунджаар 15 хувиар, ундаа, усны үйлдвэрлэл 10.0 орчим хувиар өсөх, түүнчлэн

¹³ 6 дугаар зүйл. Төсвийн тусгай шаардлага: 6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

суудлын автомашины импорт нэмэгдэх нөлөөгөөр онцгой албан татварын орлого 2026-2028 онд дунджаар 11.3 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр: Зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агууламж нэмэгдэхтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын орлогоос төсөвт төвлөрөх орлого нэмэгдэх хүлээлттэй байгаа бол нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурах хандлагатай байгаа нь орлогын өсөлтийг сааруулах тооцоололтой байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а заалтад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлнэ гэж заасан.

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдан, 2017 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, улсын төсөвт хуваарилах болсон. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв санд хуваарилсан сүүлийн 3 жилийн хувь хэмжээг харвал, 2023 онд хуваарилалт хийгдээгүй, 2024 онд 20 хувиар хуваарилсан бол 2025 оны төсвийн тухай хуульд 40 хувиар хуваарилалт хийхээр батлагдсан байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөлд Ирээдүйн өв сангийн орлогыг хуульд заасан 65 хувиар төвлөрнө гэж тооцлоо. Улмаар улсын төсөвт төвлөрөх АМНАТ 2026 онд 2025 оны батлагдсан төсвөөс 38.4 хувиар буурах хүлээлттэй байгаа бол удаах онуудад дунджаар 8.0 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

2.2.2. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2026 онд 33,479.5 тэрбум төгрөг болж, нэрлэсэн дүнгээр 2025 оны батлагдсан төлөвлөгөөний хэмжээнд байхаар тооцооллоо¹⁴. ДНБ-д эзлэх хувь 31.7 хувьд хүрч, 2025 оны батлагдсан дүнгээс 3.5 нэгж хувиар бага байхаар тооцов.

Хүснэгт 2.12 Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Нийт зарлагын дээд хэмжээ	33,479.5	35,628.6	39,086.0
ДНБ-д эзлэх хувь	31.7	30.4	29.6
Урсгал зардал	25,320.0	26,983.6	29,084.0
Өсөлтийн хувь	0.1	6.6	7.8
ДНБ-д эзлэх хувь	24.0	23.0	22.0

Урсгал зардал: Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24.0 хувь буюу 2025 оны батлагдсан түвшнээс 2.6 нэгж хувиар бууруулж тооцлоо. ОУВС-ийн судалгааны тайланд хөгжиж буй орнуудад төсвийн алдагдал, өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор төсвийн урсгал зардлын хэмжээг ДНБ-ий 20-25 орчим хувьтай тэнцүү байхаар төсөвлөхийг зөвлөдөг¹⁵. Дунд хугацаанд төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулж, 2028 онд 22.0 хувьд хүрэхээр төсөөллөө.

¹⁴ Тус өсөлтийн хэмжээ нь 2026 оны эрдэс баялгийн бус нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хүлээлт 11.8 хувь, өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж 12.7 хувь тус бүрээс доогуур байна.

¹⁵ IMF -Public Expenditure and Inclusive Growth - A Survey, 2021

Цалин, тэтгэвэр, тэтгэмж: “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг хуваарилах бодлого баримтлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс, зээлийн үйлчилгээний төлбөр зэрэг өсөн нэмэгдэх зардлуудыг үргэлжлүүлэн олгохоор тооцоолов.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зардлын төсөөлөлд иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зардал, тэтгэвэр авагчдын дундаж өсөлтийг тус тус тусган тооцоолсон болно. Төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог бууруулж, халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглүүлэх, мөн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг зохистой түвшинд олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан.

Хүснэгт 2.13 Нийгмийн халамжийн сангийн зардлын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Нийт НХС-ийн зардал	2,664.3	2,774.1	2,909.4

Хүүхдийн мөнгө: Нийгмийн халамжийн нийт зардлын 60 гаруй хувийг 0-18 насны хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид зарцуулж байгаа ба төрөлтийн түвшин буурч буйтай холбоотойгоор цаашид энэхүү тэтгэмжийн зардлын өсөлт саарах хандлагатай байна. Нэг хүүхдэд олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100 мянган төгрөг (сард)-ийг үргэлжлүүлэн олгохоор тооцоолов.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг зорилтот бүлэгт чиглүүлж, инфляцын түвшинтэй уялдуулан зохистой түвшинд олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан.

Эх, алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмж: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 255 дугаар тогтоолоор “Эхийн алдар” нэгдүгээр одонтой эхэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 400,000 төгрөгөөр, хоёрдугаар одонтой эхэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200,000 төгрөгөөр тус тус 2 дахин нэмэгдүүлэн тогтоосон бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусламж: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, тусламжийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон “Ахмад настны тухай хууль”, “Насны хишгийн журам”-д заасны дагуу зорилтот бүлэгт олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан.

Үндэсний хэмжээний хөтөлбөрүүд: “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо” зэрэг хөтөлбөр, аяныг хэрэгжүүлснээр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаснаар нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт буурч, иргэдийн бодит орлого нэмэгдэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой.

2.2.3. Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ

Нэгдсэн төсвийн суурь зарлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд “нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ”-ний үзүүлэлтийг тусгахаар заасан. Нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон нэгдсэн төсвийн суурь зарлагын хэмжээ 2026 онд 30,314.5 тэрбум төгрөгт байхаар байна.

Хүснэгт 2.14 Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2026 төсөөлөл	2027 төсөөлөл	2028 төсөөлөл
Суурь зарлагын дээд хэмжээ	30,314.5	33,282.2	36,442.0
ДНБ-д эзлэх хувь	28.7	28.4	27.6

2.2.4. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-2028 онд алдагдалгүй байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх хуулийн шаардлагыг хангаж байна.

Шигтгээ 2.1

Хөгжиж буй орнуудын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, түүний харьцуулалт

ОУВС-гийн тодорхойлсноор төсвийн тогтвортой байдал гэж Засгийн газар одоогийн бодлогын хүрээнд, ирээдүйд төлөх өр төлбөр, хүүгийн төлбөрөө орлого, зарлагынхаа харьцааг алдагдалгүйгээр санхүүжүүлэх чадвартай байх явдал гэж үздэг.

Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2010-2024 онд ойролцоо эдийн засагтай, хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад өндөр хэлбэлзэлтэй байсан. Тухайлбал, төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2010 онд 32.0 хувь байсан бол 2024 онд 39.2 хувь болж өсжээ. Харин нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь 2016 онд 39.7 хувь болж, сүүлийн 15 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн бол 2018 онд хамгийн бага түвшинд буюу ДНБ-ий 28.6 хувьд хүрсэн хэдий ч сүүлийн жилүүдэд буцан нэмэгдэж, 2024 онд огцом өсөж 38.0 хувьд хүрчээ.

Төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэлбэлзэл их байгаа нь гадаад шокийн төсөвт үзүүлэх нөлөө өндөр, голлох түүхий эдийн үнийн савлагаа их байгааг харуулж байна.

Зураг 2.3 Улс орнуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ



Зураг 2.4 Улс орнуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ



Эх сурвалж: ОУВС, World Economic Outlook Database, 2025.04 сар

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг 10 байр ахиулах зорилтыг тусгасан.

Өв уламжлалын сангаас жил бүр тооцдог Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2025 онд 63 оноо авч, өмнөх оноос 2 байр ахиж 184 орноос 74 дугаарт жагссан байна. Тус индексийг тооцохдоо нийт 12 бүлэг¹⁶ үзүүлэлтийг ижил жингээр үнэлж тооцдог. Эдгээр бүлэг үзүүлэлтийн зарим нь зөвхөн ганц тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол зарим нь чанарын олон үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд дахин өөр индексүүдийг дотроо агуулсан байх нь ч бий.


Иймд хамгийн цөөн дэд үзүүлэлт бүхий бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлэхээр байна. Энэ дагуу дэд үзүүлэлтүүдийг шүүж үзвэл засгийн газрын зарлага, төсвийн алдагдал, инфляцын түвшин гэсэн 3 үзүүлэлт индексийн үнэлгээний 20 гаруй хувийг бүрдүүлж байна. Тиймээс эдгээр үзүүлэлтийг сайжруулснаар Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой юм.

Засгийн газрын зарлага: Уг үзүүлэлт нь ДНБ-д эзлэх засгийн газрын зарлагын сүүлийн гурван жилийн дунджаар хэмжигддэг бөгөөд бага байх тусам өндөр үнэлгээ авдаг. Монгол Улсын хувьд 2021-2023 онд энэ үзүүлэлт буурсан нь 2025 оны индексийн үнэлгээ ахих гол хүчин зүйл болсон. Цаашид уг үзүүлэлтийг тогтвортой бууруулж, ДНБ-ий 30 хувьд хүргэснээр бусад үзүүлэлтүүд болон бусад улсуудын урагшлах хандлага ижил түвшинд хадгалагдана гэж үзвэл зөвхөн засгийн газрын зарлагын үзүүлэлтээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс дэх манай улсын эрэмбийг 1-2 байраар урагшлуулах боломжтой (Зураг 2.5).

Төсвийн алдагдал: Төсвийн сахилга бат бүлгийг ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээ болон засгийн газрын өрийн хэмжээгээр 80 болон 20 хувийн жин өгч дундажлан тооцдог. Төсвийн тэнцэл ДНБ-д эзлэх хэмжээгээрээ ашигтай байх тусам энэхүү үзүүлэлт өндөр үнэлгээ авдаг. Монгол Улсын хувьд 2021-2023 оны хугацаанд уг үзүүлэлт сайжирсан нь 2025 оны индексийн үнэлгээ нэмэгдэхэд эергээр нөлөөлсөн. Цаашид ч төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах бодлого баримталж байна (Зураг 2.6).


Инфляцын түвшин: Индекс дэх Мөнгөний эрх чөлөөний бүлгийг тооцохдоо инфляцын сүүлийн гурван жилийн дунжийг ашиглан тооцдог. Манай улсын хувьд 2021-2023 онд инфляцын дундаж түвшин 11 хувьд хүрсэн нь тус бүлэг үзүүлэлтээр хойгуур жагсахад хүргэсэн байдаг. Харин энэ үзүүлэлтээр дундуур байр эзэлж буй улс орнуудын инфляцын түвшин 4 хувь орчимд хэлбэлзэж байна. Иймд инфляцын дундаж түвшнийг бууруулж 4-5 хувьд хүргэснээр Мөнгөний эрх чөлөөний үзүүлэлтийг сайжруулах боломжтой байна (Зураг 2.7).

Зураг 2.5 Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яам

Зураг 2.6 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яам

Зураг 2.7 Инфляцын түвшин, 3 жилийн дундаж



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

¹⁶ Өмчийн эрх, Шүүхийн үр ашиг, Төрийн зарчимт байдал, Татварын дарамт, Засгийн газрын зарлага, Төсвийн сахилга бат, Бизнесийн эрх чөлөө, Хөдөлмөрлөх эрх чөлөө, Мөнгөний эрх чөлөө, Худалдааны эрх чөлөө, Хөрөнгө оруулагчдад эзлтэй байдал, Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал гэсэн бүлэг үзүүлэлтүүдтэй ба 0-100 онооны хооронд үнэлэн оноог дунджилж нийт индексийг тооцдог.

2.3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн тоог ашиглаагүй бол үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлсон тайлбар

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дах хэсэгт Засгийн газар “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дах хэсэгт заасны дагуу макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалыг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн болно.

Хүснэгт 2.15 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийн таамаглал

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ашигласан төсөөлөл			Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн таамаглал		
	2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.5	6.5	5.4	5.5	5.7
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.4	6.0	8.2	7.2	6.8
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	33,479.5 31.7	35,628.6 30.4	39,086.0 29.6	34,770.6 35.77	37,717.3 35.69	40,806.9 35.73
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	33,479.5 31.7	35,628.6 30.4	39,086.0 29.6	35,742.6 36.77	39,830.9 37.69	43,091.1 37.73
5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	0.0 0.0	0.0 0.0	0.0 0.0	-972.1 -1.0	-2,113.6 -2.0	-2,284.2 -2.0
6 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	30,314.5 28.7	33,282.2 28.4	36,442.0 27.6	-	-	-
7 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	3,165.0 3.0	2,346.4 2.0	2,644.0 2.0	-	-	-
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	52,750.0 50.0	52,794.0 45.0	59,490.0 45.0	36,452.2 37.5	38,890.3 36.8	41,457.9 36.3
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	2,664.3 2.5	2,774.1 2.4	2,909.4 2.2	-	-	-

Төсвийн зарлага: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 2026 онд 35.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 36.77 хувь, 2027 онд 39.8 их наяд төгрөг буюу 37.69 хувь, 2028 онд 43.1 их наяд төгрөг буюу 37.73 хувь байхаар таамагласан байна.

Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалын хязгаарт багтааж тооцсон ба Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах, төсвийн зардлын тэлэлт, гадаад өрийн хэмжээг бууруулах, урсгал зардлын өсөлтөд зайлшгүй шаардлагатай нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, үр ашиггүй төсвийн зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг сахих бодлогыг баримтлан төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хэмжээг 2026 онд 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь байхаар төсөөллөө.

Төсвийн зарлагын 2026-2028 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 2.2.2. дахь хэсгээс харах боломжтой.

Төсвийн орлого: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэгдсэн төсвийн орлогын хэмжээг 2026 онд 34.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.77 хувь, 2027 онд 37.7 их наяд төгрөг буюу 35.69 хувь, 2028 онд 40.8 их наяд төгрөг буюу 35.73 хувь байх таамаглалыг ирүүлсэн.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалын хязгаарт багтаж байгаа бөгөөд 2026 оны төсөөллөөс 4.0 нэгж хувиар бага буюу 31.7 хувь, 2027 онд 5.3 нэгж хувиар бага буюу 30.4 хувь, 2028 онд 6.2 нэгж хувиар бага буюу 29.6 хувьд хүрэхээр тооцсон.

Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2011-2020 онд дунджаар 29 хувь байсан бол 2021-2024 онд 35.2 хувьд хүрч өссөн байна. Цар тахлын дараах эдийн засгийн идэвхжил, 2022-2023 оны түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарсан төсвийн орлогын огцом өсөлтийн хурд цаашид саарах төлөвтэй байна.

Тухайлбал, гадаад орчин талаас дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал, худалдааны дайн болон нүүрсний дэлхийн зах зээлийн үнийн уналт төсвийн орлогод сөргөөр нөлөөлөхөөр байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас доогуур төсөөллөө.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2026-2028 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 2.2.1. дэх хэсгээс харах боломжтой.

Засгийн газрын өр: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийг 2026 онд 37.5 хувь, 2027 онд 36.8 хувь, 2028 онд 36.3 хувьд хүрч буурах таамаглалыг ирүүлсэн.

Дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудтай уялдуулан гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй хөгжлийн томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний зээлийн ашиглалтын дүнг нэмэгдүүлэх, төслүүдийн санхүүжилтийн орон зайг өрийн зохистой түвшинд багтаан олгох, гүйцэтгэлийг сайжруулах, шилжих төслүүдийг хугацаанд нь дуусгах бодлогыг

баримтлан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд Засгийн газрын өрийн хязгаарыг 2026 онд 50 хувь, 2027-2028 онд тус тус 45 хувь байхаар тооцсон.

Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.

ДНБ-ий бодит өсөлт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ДНБ-ий бодит өсөлтийг 2026 онд 5.4 хувь, 2027 онд 5.5 хувь, 2028 онд 5.7 хувь байх таамаглалыг ирүүлсэн.

Тус зөвлөлөөс эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны таамаглалыг боловсруулахад DIGNAR-19 болон FPP-CAEM загваруудыг ашигласан байна. DIGNAR-19 загварын хувьд экспорт, засгийн газрын хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтүүдийн төсөөллийг 1 хувьсагчийн хугацаан цуваан загваруудаар тооцсон бөгөөд тус загвараар ДНБ-ий өсөлт 2026 онд 5.0 хувь, 2027 онд 5.77 хувь, 2028 онд 6.22 хувь байх төсөөллийг боловсруулжээ. Харин FPP-CAEM загварын хувьд 2026-2028 онд эдийн засгийн өсөлт 6 хувь орчим байхаар тооцоолсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6.0 хувь, 2027-2028 онд тус тус 6.5 хувь байхаар тооцож, тусгалаа.¹⁷

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ашигласан эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахдаа томоохон аж ахуйн нэгжүүдийн бизнес төлөвлөгөө болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөг харгалзан үйлдвэрлэлийн хэмжээг салбар тус бүрээр тооцон боловсруулсан болно. Тухайлбал, уул уурхайн салбарын төсөөлөлд Оюу толгойн гүний уурхайн үйлдвэрлэлтэй холбоотойгоор зэсийн баяжмал дахь эрдсийн агуулгын өөрчлөлтийг тусгасан бол хөгжлийн томоохон төслүүдийн хэрэгжилтийн нөлөөг барилга, боловсруулах, эрчим хүч зэрэг салбаруудын төсөөллийг боловсруулахад ашигласан. Улмаар эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт талын нийцэл, бодит, төсөв, мөнгө, гадаад секторуудын уялдааг ханган эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулсан болно. Түүнчлэн, макро эдийн засгийн хагас бүтцийн GAP шинжилгээний аргад тулгуурлан худалдааны томоохон түнш орны эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх шинжээчдийн дүгнэлттэй уялдуулан тооцсон эдийн засгийн потенциал өсөлт болон бизнесийн мөчлөгийн нөлөөг тусгасан болно.

¹⁷ Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллийн хувьд ОУВС 2026 онд 5.9 хувь, 2027-2028 онд тус тус 5.5 хувь байх төсөөллийг 2025 оны 4 дүгээр сард зарлаад байна. Харин Дэлхийн банк Монгол Улсын эдийн засаг 2026 онд 6.1 хувиар өсөх төсөөллийг 2025 оны 1 дүгээр сард зарласан бол Азийн хөгжлийн банк 2026 оны өсөлт 5.9 хувьд байх төсөөллийг 2025 оны 4 дүгээр сард зарласан. Монголбанкны хувьд эдийн засгийн өсөлт 2026 онд 6.0 хувь, 2027 онд 5.9 хувь байна гэж төсөөлж байна.

Эдийн засгийн өсөлтийн 2026-2028 оны төсөөллийн талаар дэлгэрэнгүйг энэ танилцуулгын 1.2.3. дахь хэсгээс харах боломжтой.

Экспортын биет хэмжээ: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалд нүүрс болон төмрийн хүдрийн экспортын биет хэмжээний төсөөллийг 1 хувьсагчийн ARIMA загварын үр дүнгээр, харин алт болон зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний төсөөллийг 1 болон олон хувьсагчийн загваруудын дундаж утгаар авсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нүүрсний экспортын биет хэмжээг 2026 онд 91 сая тонн, 2027 онд 95 сая тонн, 2028 онд 100 сая тонн байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 2 сая тонноор бага байгаа бол 2027-2028 оны хувьд нийцтэй байна.

Зэсийн баяжмалын хувьд экспортын биет хэмжээг 2026 онд 2,262 мянган тонн, 2027 онд 2,402 мянган тонн, 2028 онд 2,538 мянган тонн байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 252 мянган тонн, 2027 оны хувьд 302 мянган тонн, 2028 онд 328 мянган тонноор тус тус их байна.

Харин алтны экспортын биет хэмжээг 2026 онд 12.8 тонн, 2027 онд 13.5 тонн, 2028 онд 13.2 тонн байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 7 тонн, 2027-2028 оны хувьд 11 тонноор тус тус бага байна.

Мөн төмрийн хүдрийн экспортын биет хэмжээг 2026 онд 8,553 мянган тонн, 2027 онд 8,952 мянган тонн, 2028 онд 9,351 мянган тонн байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 822 мянган тонн, 2027 оны хувьд 628 мянган тонн, 2028 онд 284 мянган тонноор тус тус бага байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулах хүрээнд экспортын таамаглалыг уул уурхайн салбарын бодит үйл ажиллагааны төлөвлөгөө, идэвхжилийн төлөвт үндэслэн боловсруулах нь илүү оновчтой гэж үзсэн тул томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, Засгийн газраас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн нөлөө, хилийн боомтуудын хүчин чадалд үндэслэн боловсруулсан экспортын төсөөллийг ашигласан болно.

Тухайлбал, нүүрсний экспортын төсөөллийг Монгол Улсын нийт нүүрсний экспортын 80 хувийг бүрдүүлдэг том 9 аж ахуй нэгжийн борлуулалтын төлөвлөгөө, бусад жижиг аж ахуй нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан. Мөн хил холболтын төслүүд зэрэг ирэх онуудад хэрэгжих экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөг тооцсон болно.

Экспортын 2026-2028 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 1.2.6. дахь хэсгээс харах боломжтой.

Экспортын үнэ: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалд голлох бүтээгдэхүүнүүдийн экспортын үнийн төсөөллийг 1 хувьсагчийн ARIMA загварын үр дүнгээр авсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нүүрсний экспортын үнийг тонн тутамд 2026 онд 88 ам.доллар, 2027 онд 92 ам.доллар, 2028 онд 96 ам.доллар байх төсөөллийг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 8 ам.доллараар, 2027 онд 15 ам.доллараар, 2028 онд 19 ам.доллараар тус тус өндөр байна.

Мөн тус зөвлөлөөс зэсийн баяжмалын үнийг тонн тутамд 2026 онд 2,028 ам.доллар, 2027 онд 2,098 ам.доллар, 2028 онд 2,160 ам.доллар байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 671 ам.доллараар, 2027 онд 539 ам.доллараар, 2028 онд 553 ам.доллараар тус тус бага байна.

Алтны үнийг унц тутамд 2026 онд 2,198 ам.доллар, 2027 онд 2,078 ам.доллар, 2028 онд 1,965 ам.доллар байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 402 ам.доллараар, 2027 онд 222 ам.доллараар, 2028 онд 35 ам.доллараар тус тус бага байна.

Төмрийн хүдрийн үнийг тонн тутамд 2026 онд 64 ам.доллар, 2027 онд 62 ам.доллар, 2028 онд 61 ам.доллар байх таамаглалыг ирүүлсэн. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад ашигласан төсөөлөлтэй харьцуулахад 2026 оны хувьд 5 ам.доллараар, 2027 онд 4 ам.доллараар, 2028 онд 2 ам.доллараар тус тус бага байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулах хүрээнд экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг тусгаж, олон улсын байгууллагуудын төсөөллүүдийг харгалзан үзэж боловсруулах нь оновчтой гэж үзсэн тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн дээрх таамаглалыг ашиглаагүй болно.

Тухайлбал, нүүрсний хувьд Олон улсын эрчим хүчний агентлагийн 2024 оны 12 дугаар сард нийтэлсэн нүүрсний төлөв байдлын тайланд дэлхийн чулуун нүүрсний хэрэглээ 2027 он гэхэд 2024 оны түвшнээс 5 хувиар буурахаар тооцоолсон байна. Түүнчлэн, худалдааны дайнтай холбоотойгоор тодорхой бус байдал нэмэгдэж буй энэ үед олон улсын шинжээчид нүүрсний үнийг дунд хугацаанд буурахаар төсөөлж байна. Улмаар олон улсын шинжээчдийн таамаглалын дагуу нүүрсний үнэ дунд хугацаанд буурах хандлагатай гэж үзсэн тул нүүрсний үнэ дунд хугацаанд өснө гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалыг ашиглаагүй болно. Мөн зэсийн баяжмалын экспортын үнийн төсөөллийг боловсруулахдаа баяжмал дахь цэвэр зэсийн агуулгын нөлөөг авч үзсэн болно.

Дэлхийн эдийн засгийн төлөв, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлагын талаар энэ танилцуулгын 1.2.1. болон 1.2.2. дахь хэсгээс харах боломжтой.

Инфляц: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс инфляц 2026 онд 8.2 хувь, 2027 онд 7.2 хувь, 2028 онд 6.8 хувь байх төсөөллийг ирүүлсэн. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд инфляц дунджаар 2026 онд 7.0 хувь, 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6.0 хувь байхаар тусгасан.

Дунд хугацаанд “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дотоодын хүнсний үнийн өсөлт саарч, инфляцын дарамт буурахаар тооцоолж байна. Мөн төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд төв банк 2027 оноос инфляцын зорилтот түвшнийг 5 хувь болгон бууруулахаар заасны дагуу дунд хугацаанд инфляцыг 5 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжихээр байна.

Инфляцын 2026-2028 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 1.2.4. дэх хэсгээс харах боломжтой.

3. ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

3.1. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, стратегийн зорилт¹⁸

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн удирдлагын зарчимд нийцүүлэн макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах, төсвийн тусгай шаардлагыг хангах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн дунд хугацааны төсвийн бодлого, стратегийн зорилтыг боловсрууллаа.

Түүнчлэн төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэх, хэрэгжихүйц, бодитой байх зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан болно.

Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ. Иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг хязгаарлахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг ханган, төсвийн зардлын үр ашгийг сайжруулж, бодлогын орон зайг нэмэгдүүлнэ.

Хоёр. Төсвийн орлого, зарлагын чиглэлээр дараах төсвийн бодлого, стратеги зорилтыг хэрэгжүүлнэ.

Татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчмыг баримтлан, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт болон боловсруулах үйлдвэрлэлийг татварын багц бодлогоор дэмжинэ.

Мөн дунд хугацаанд уул уурхайн салбар дахь татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримталж, уул уурхайн бус салбарт татварын илүү таатай орчныг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ.

Төсвийн сахилга батыг сайжруулан, урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, төрийн албан хаагчдын цалинг ажлын үр дүн, гүйцэтгэл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, салбаруудыг татааснаас чөлөөлөх бодлого баримтална.

¹⁸ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн

- 12.3.1. төсвийн бодлого, зорилтыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн удирдлагын зарчим, 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлж дунд хугацаагаар тодорхойлсон байдал

- 12.3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн тусгай шаардлагад нийцүүлж тусгасан төсвийн бодлогын зорилтыг хангах арга хэмжээ

Эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор дэд бүтцийн төслүүдийг гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр үр ашигтай санхүүжүүлж, урт хугацаанд эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Гурав. Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн чиглэлээр дараах төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Засгийн газрын өрийн оновчтой багцыг бүрдүүлж, гадаад зээлийн эрсдэлийг бууруулах, гадаад өрийн үр ашгийг нэмэгдүүлж, өрийн статистикийг олон улсын жишигт нийцүүлэн Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээг бууруулах бодлогыг баримтална. Үүнд:

- *Засгийн газрын өрийн оновчтой багцыг бүрдүүлэх зорилгоор өрийн зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;*
- *Засгийн газрын нийт өрд эзлэх дотоод өрийн хэмжээг бууруулахгүй байх бодлогыг баримтална;*
- *Засгийн газрын гадаад үнэт цаасны дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах бодлого баримтална;*
- *Шинээр авч ашиглах гадаад зээлийн үр ашгийг нэмэгдүүлнэ;*
- *Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг зохих түвшинд хадгална;*
- *Улсын секторын өрийн статистикийг олон улсын жишгийн дагуу хамрах хүрээг өргөтгөнө.*

3.2. Төсвийн тусгай шаардлага хангасан байдал¹⁹

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцлоо (Шигтгээ 3.1).

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байхаар заасан. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026 онд 3.0 хувь, 2026 онд 2.0 хувь, 2027 онд 2.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.1 Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2026	2027	2028
Хуулийн хязгаар	2.0%	2.0%	2.0%
Төсөөлөл	3.0%	2.0%	2.0%

Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 2026 онд 24.0 хувь, 2027 онд 23.0 хувь, 2028 онд 22.0 хувь байхаар тус тус төсөөлсөн нь төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээний тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.2 Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2026	2027	2028
Хуулийн хязгаар	30.0%	30.0%	30.0%
Төсөөлөл	24.0%	23.0%	22.0%

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2026-2028 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 3.3 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2026	2027	2028
Хуулийн хязгаар	60.0%	60.0%	60.0%
Төсөөлөл	50.0%	45.0%	45.0%

¹⁹ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.9.төсвийн төлөвлөлтийн төсвийн тусгай шаардлагад нийцсэн байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тавигдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдал”

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “Тухайн төсвийн жилийн дараах жилийн төсвийн төсөлд баримтлах, түүний дараагийн хоёр, гурав дахь жилийн төсвийн төсөөлөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг **Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт** тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг **олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас** тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох” гэж заасан. Мөн тус хуулийн 4.1.3-т “**гол нэр төрлийн эрдэс баялаг**” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг хэлнэ хэмээн тодорхойлсон бөгөөд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэс болон нүүрс дээрх шаардлагыг хангаж байна.

1. Олон улсын валютын сангийн түүхий эдийн үнийн статистик

ОУВС-гаас түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн мэдээллийг Голлох Түүхий Эдийн Үнийн Систем (PCPS²¹)-ээр дамжуулан мэдээлдэг. Тус өгөгдлийн сангаас Австрали, Өмнөд Африкийн нүүрсний үнийг хамруулсан Нүүрсний Үнийн Индекс (2016=100)-ийн дунжийг ашигласан.

2. Эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсын байгууллага

Тэнцвэржүүлсэн үнийн тооцоололд ашиглагдах гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн төсөөллийг “Bloomberg Terminal”-д бүртгэлтэй Citigroup, Bank of America Merrill Lynch, Morgan Stanley, JP Morgan Chase & Co болон бусад санхүүгийн байгууллагуудаас 2025 оны 3 дугаар сард анх зарласан өдрийн төсөөллийг авч ашиглалаа. Нүүрсний үнийн төсөөллийн хувьд Bank of America Merrill Lynch тус оны 3 дугаар сарын 3-ны өдөр хамгийн эхэнд зарласан бол зэсийн үнийн төсөөллийг тус өдөр Morgan Stanley байгууллага зарласан байна. Дээрх байгууллагуудын төсөөлөл 2025 он болон ирэх онуудад нүүрсний хувьд дунджаар 115.5 ам.доллар байгаа бол зэсийн хувьд 9,722.2 ам.доллар байна.

Хүснэгт 3.4 Гол нэр төрлийн эрдэс баялгийн татварын орлогын нийт төсвийн орлогод эзлэх хувь

	Орлого (тэрбум төгрөг)	Эзлэх хувь
Төсвийн орлого	31,375.10	100%
Зэс	2,311.50	7.40%
Нүүрс	6,749.40	21.50%
Алт	375.41	1.20%
Жонш	53.1	0.20%
Төмөр	158.9	0.50%
Цайр	96.5	0.30%
Бусад	316.4	1.00%

Эх сурвалж: Татварын ерөнхий газар²⁰

Хүснэгт 3.5 Тэнцвэржүүлсэн үнийн тооцоолол

	Өмнөх жилүүдийн дундаж		
	18 жил	19 жил	20 жил
Нүүрс	160.5	156.1	151.9
Зэс	7,155.3	7,134.1	6,961.2
	Ирээдүйн үнийн төсөөлөл		
	2026	2027	2028
Нүүрс	112.0	111.8	113.2
<i>Дундаж</i>	115.5		
Зэс	9,501.9	9,744.4	9,810.6
<i>Дундаж</i>	9,722.2		
	Тэнцвэржүүлсэн үнэ		
	2026	2027	2028
Нүүрс	133.7	135.8	138.0
Зэс	8,341.8	8,428.2	8,438.8

Эх сурвалж: ОУВС, Блүүмберг, ЭЗХЯ-ны тооцоолол

²⁰ Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын мэдээ


²¹ Өгөгдлийн сантай дараах холбоосоор танилцана уу: <https://legacydata.imf.org/?sk=471ddd8-d8a7-499a-81ba-5b332c01f8b9>

3.3. Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ²²

Төсвийн бодлого нь эдийн засгийн агшилтын үед тэлж, халалтын үед хумих замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэх шаардлагатай. Төсвийн бодлого эдийн засгийг тогтворжуулах чиглэлд хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх хүрээнд төсвийн тэнцэл дэх төсвийн бодлогын нөлөөг салгаж харах шаардлагатай. Учир нь төсвийн тэнцэл нь зөвхөн төсвийн бодлого төдийгүй эдийн засгийн өөрийн бизнесийн мөчлөг болон эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран төлөх үүрэг хүлээсэн хүүгийн төлбөрөөс хамаардаг.

Тухайлбал, эдийн засаг идэвхжихийн хэрээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрчимжсэнээр төсвийн бодлогоос үл хамааран төсвийн орлого нэмэгддэг бол эсрэгээрээ эдийн засгийн уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг төсвийн зардал өсөж, төсвийн тэнцэл төсвийн бодлогоос үл хамааран буурдаг. Ийнхүү эдийн засгийн мөчлөгийн нөлөөгөөр төсвийн тэнцэл автоматаар өөрчлөгдөж байгааг “автомат тогтворжуулагч” гэх үзүүлэлтээр хэмжинэ. Мөн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогын төлөвөөс үл хамааран хуваарийн дагуу төлөх үүрэг хүлээсэн өрийн үйлчилгээний төлбөрүүд төсвийн тэнцэлд нөлөөлнө. Иймд төсвийн бодлогын төлөвийг тооцоолоход төсвийн тэнцлийн дүнгээс бизнесийн мөчлөг болон хүүгийн төлбөрийн нөлөөг ялган харах шаардлагатай. Зураг 3.1-т төсвийн тэнцэлд үзүүлж буй төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар, өрийн үйлчилгээний төлбөрийн нөлөөг хүүгийн зардлаар салган харуулав.

Зураг 3.1 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл



Зураг 3.2 Төсвийн төлөв, үйлдвэрлэлийн зөрүү



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Сүүлийн 15 жилд манай улсын эдийн засаг 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал, 2016 оны түүхий эдийн үнийн уналт, 2020 оны цар тахал зэрэг 3 удаагийн томоохон хямралд өртсөн. Хамгийн сүүлд тохиосон цар тахлын хямралын үед буюу 2020-2021 онд эдийн засгийн үйлдвэрлэл боломжит түвшнээсээ хамгийн ихдээ -6.9 хувиар бага байсан байна. Энэхүү уналтын үед төсвийн төлөв дунджаар потенциал ДНБ-ий -5.9 хувьд хүрсэн нь макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн мөчлөг сөрсөн төсвийн тэлэх бодлого хэрэгжсэнийг харуулж байна (Зураг 3.2). Түүнчлэн төсвийн тэнцэлд үзүүлэх өрийн үйлчилгээний төлбөрийн дарамт өндөр байгааг харж болно.

²² Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.3. Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ”

3.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл

Хүснэгт 3.6 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2026	2027	2028
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.5	6.5
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.4	6.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	33,479.5	35,628.6	39,086.0
ДНБ-д эзлэх хувь	31.7	30.4	29.6
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	33,479.5	35,628.6	39,086.0
ДНБ-д эзлэх хувь	31.7	30.4	29.6
5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	0.0	0.0	0.0
ДНБ-д эзлэх хувь	0.0	0.0	0.0
6 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	30,314.5	33,282.2	36,442.0
ДНБ-д эзлэх хувь	28.7	28.4	27.6
7 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	3,165.0	2,346.4	2,644.0
ДНБ-д эзлэх хувь	3.0	2.0	2.0
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	52,750.0	52,794.0	59,490.0
ДНБ-д эзлэх хувь	50.0	45.0	45.0
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,664.3	2,774.1	2,909.4
ДНБ-д эзлэх хувь	2.5	2.4	2.2

4. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Нэг. Худалдааны дайн: АНУ-ын худалдааны бодлогын шийдвэрүүдтэй холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. АНУ-ын зүгээс худалдааны алдагдлыг бууруулах бодлогын хүрээнд бусад орнуудад тогтоосон тарифын хэмжээг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зарим бараа бүтээгдэхүүнд онцгойлон өндөр тариф тогтоох зэрэг шийдвэрүүдийг гаргаад байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр өргөжиж байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн идэвхилийг хязгаарлах, инфляцыг өдөөх, бодлогын хүү удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

Хоёр. БНХАУ-ын эдийн засаг: БНХАУ-ын эдийн засагт үл хөдлөх салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлт сул хэвээр байна. БНХАУ-ын засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч худалдааны дайны хүрээнд АНУ-ын зүгээс БНХАУ-аас импортолж буй бүтээгдэхүүнд өндөр тариф тогтоосноор хоёр улс хоорондын худалдааны дайн хурцдаж, цаашид улам бүр тэлэх эрсдэлтэй байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт төсөөллөөс доогуур байх нь манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

Гурав. ОХУ-Украины дайн: ОХУ-Украины дайнтай холбоотойгоор газрын тосны үнэ 2022 онд огцом өссөнөөр импортын зардал нэмэгдэж, дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимтэй явагдсан. Цаашид дайны нөхцөл байдал хурцдах нь нефтийн бүтээгдэхүүний үнийг өсгөж, инфляцын дарамтыг нэмэгдүүлж болзошгүй эрсдэл хэвээр байна. Мөн ОХУ-ын эсрэг Европын холбоо, Их Британи болон АНУ зэрэг улсуудын авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ нэмэгдэх нь манай улсын гадаад төлбөр тооцоо саатах эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

Дөрөв. Уур амьсгалын өөрчлөлт: Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар сүүлийн 2 жил дараалан агшаад байна. Цаг агаарын таагүй нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган тохиолдох, малын халдварт өвчин тархах эрсдэл өндөр байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, дотоодын хүнсний инфляц нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

Дөрөв. Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал: Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй, 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. Түүнчлэн Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл өссөн нэмэгдэж буй хэрэглээг хангаж чадахгүй байгаагийн зэрэгцээ станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний тасалдал нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

Тав. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга

хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

5. ХАВСРАЛТ

5.1. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн²³

Монгол Улсын "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн төслийг боловсруулахтай холбогдуулан төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, иргэдийн санал, санаачилгыг төсөвт тусгах боломжийг бүрдүүлэх үүднээс олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Түүнчлэн цахим орчинд нээлттэй санал, асуулга явуулж нийт 600 гаруй хариулт, 54 задгай санал хүлээн авсан.

Нэг. Хэлэлцүүлэх арга хэмжээнд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс ирүүлсэн задгай саналын товьёг

Хүснэгт 5.1 Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс ирүүлсэн задгай санал

№	Санал ирүүлсэн байгууллага, иргэн	Ирүүлсэн санал	Тайлбар
Давхардсан санал			
1	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн	Төсвийн шинжтэй хөрөнгө оруулалтын бодлого хөтөлбөрийн нөлөөг төсвийн тооцоололд тусгах /Хүнсний хувьсгал, шинэ хоршоо, атрын аян, цагаан алт гэх мэт/	Дунд хугацаанд инфляцын түвшнийг үе шаттайгаар бууруулах хүрээнд "Хүнсний хувьсгал" хөдөлгөөн, "Атар-4" аяны нөлөөгөөр хүнсний нийлүүлэлт нэмэгдэж, дотоодын хүнсний үнийн өсөлт буурахаар тооцож ДХТХМ-д тусгасан болно.
		Бодлогын хүүг бууруулах	Төв банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монголбанк хүүгийн нэгдсэн бодлогоор дамжуулан төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр заасан. Бодлогын хүүгийн түвшнийг бууруулахад инфляцын түвшнийг бууруулах шаардлагатай. Энэ хүрээнд ДХТХМ-д инфляцыг 2026 онд 7.0 хувь, 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6.0 хувь байхаар тооцож, тусгасан. Дунд хугацаанд "Хүнсний хувьсгал" хөдөлгөөн, "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян" зэрэг эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дотоодын хүнсний үнийн өсөлт саарч, инфляцын дарамт буурахаар тооцоолж байна. Мөн төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу төв банк 2027 оноос инфляцыг 5 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэхээр байна.
2	Их сургуулийн төлөөлөл	Мега төслүүдийн төсөв, санхүүжилтийн стратеги болон бусад мэдээллийг тодорхой болгох, төсөөлөлдөө оруулах	Дунд хугацаанд хэрэгжих томоохон төслүүдийн нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүний барилга, боловсруулах, эрчим хүч болон бусад салбарууд, гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөлөлд

²³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "12.3.10. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан талаарх мэдээлэл"

№	Санал ирүүлсэн байгууллага, иргэн	Ирүүлсэн санал	Тайлбар
			тусгаж, төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг салбар хоорондын тэнцэл болон хагас бүтцийн GAP шинжилгээгээр тооцоолон төсөөлөлд тусгасан болно.
3	Хувийн хэвшил	Түүхий эдийн зах зээлийн үнийг хэт өөдрөгөөр төсөөлөхөөс зайлсхийж илүү зөв, бодит, оновчтой тооцооллыг хийх	Экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно.
4	Хувийн хэвшил	Төсвийн зардлыг дахин нягталж, үргүй зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг холбогдох бүх түвшинд сахих	Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримтална. Уг саналыг ДХТХМ-д тусгасан болно.
5	Хувийн хэвшил	Төрийн өмчийн алдагдалтай ажиллаж байгаа компаниудыг ангилж, засаглалыг ил тод болгож, хувьчлах	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан. Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримтална. Уг саналыг ДХТХМ-д тусгасан болно.
6	Хувийн хэвшил	Дотоодын үйлдвэрлэлүүдийг дэмжиж, экспортын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, ган, зэс, газрын ховор элементийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан.
Давхардаагүй санал			
1	Эрдэм шинжилгээний байгууллага	Сценарио төсөөлөл хийх	Саналыг хүлээн авсан.
		Төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 30 хувьд хүргэх шаардлагатай	Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримтална. Уг саналыг ДХТХМ-д тусгасан болно.
		Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувийг 33 хувиар тогтоох	Саналыг хүлээн авч, ДХТХМ-д тусгасан болно.
		Гадаадын ажиллах хүч авах журмыг өөрчлөх	Саналыг хүлээн авсан.
		Урт хугацаанд бүтээмжээ дээшлүүлэх, эдийн засгаа тэлэх бодлогыг төсөвт тусгахад анхаарах	Саналыг хүлээн авч, ДХТХМ-д тусгасан болно.
2	Их сургуулийн төлөөлөл	Эдийн засгийн мөчлөгийн нөлөө, инфляцын өсөлт зэрэг үзүүлэлтүүдийг төсөөлөлдөө тусгах	Эдийн засгийн мөчлөгийн нөлөө, инфляц зэрэг үзүүлэлтүүдийг төсөөлөлд тусгасан болно. Эдийн засгийн өсөлтийн 2026-2028 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 1.2.3. дахь хэсгээс, инфляцын 2026-2028 оны төсөөллийн талаар 1.2.4. дэх хэсгээс харах боломжтой.
3		Хувийн сектор дахь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүдийн талаар тооцоолол, мэдээллийг төсөөлөлд оруулах	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төсөл, арга хэмжээнүүдийн тооцоо, мэдээллийг үндэслэн салбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөг төсөөлөлд тусган тооцоолсон болно.

№	Санал ирүүлсэн байгууллага, иргэн	Ирүүлсэн санал	Тайлбар
4	Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	Геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа үед төсвийн зардлын хэт тэлэлт, төсвийн орлого дутахаас сэргийлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс төсвийг алдагдалгүй байхаар тооцоондоо тусгах нь зүйтэй байна.	Саналыг хүлээн авч, ДХТХМ-д тусгасан болно.
		Төсвийн хэт тэлсэн зардлаа бууруулах	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2026 онд 31.7, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь байхаар бууруулж, ДХТХМ-д тусгасан болно.
5	Хувийн хэвшил	Төсвийн орлого, бүрдүүлэгч татварын орлогод одоогийн татварын хуулийн шинэчлэл хэрхэн нөлөөлөхийг авч үзэх энэ тал дээр Сангийн яамтай хамтран ажиллах	Татварын хуулийн багц шинэчлэл төсвийн орлогод хэрхэн нөлөөлөх, холбогдох тооцоолол судалгааг ирүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж хамтран ажиллаж байна.
		Төсвөөс цалинждаг байгууллагууд болон төрийн захиргааны байгууллагуудын орон тоог багасгах, цахимд шилжүүлэх	Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримталж байна.
		Түгжрэлийг бууруулахын тулд ерөнхий боловсролын сургуулиудын чадавхыг сайжруулж, хувийн сургуулиудыг хаах	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан.
6	Олон улсын байгууллага	Өрийн бүтцийг оновчтой удирдах, хөрөнгө оруулалтын зардлыг дунд хугацаанд эх үүсвэрийн ялгаатай байдлаар удирдах	Дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудтай уялдуулан гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй хөгжлийн томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний зээлийн ашиглалтын дүнг нэмэгдүүлэх, төслүүдийн санхүүжилтийн орон зайг өрийн зохистой түвшинд багтаан олгох, гүйцэтгэлийг сайжруулах, шилжих төслүүдийг хугацаанд нь дуусгах бодлогыг баримтлан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд Засгийн газрын өрийн хязгаарыг 2026 онд 50 хувь, 2027-2028 онд 45 хувь байхаар тооцсон.

№	Санал ирүүлсэн байгууллага, иргэн	Ирүүлсэн санал	Тайлбар
		Төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулах	Саналыг хүлээн авч, ДХТХМ-д тусгасан болно.
7	Хэвлэл мэдээллийн байгууллага	Хөрөнгө оруулалтыг эрэмбэлж, хийж хэрэгжүүлэх ажлуудын тооцооллыг нарийн хийх, зарим төслийг хойшлуулах зардал нэмэгдүүлэхгүй байх, орлого бүрдүүлэх	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан.
8	Иргэн	Төсвийн сахилга батыг сайжруулах	Саналыг хүлээн авч, ДХТХМ-д тусгасан болно.
		Татвар, нийгмийн даатгалын реформ, нөлөөг арилгах	Саналыг хүлээн авсан.

Хоёр. Төрийн байгууллагын төлөөллөөс ирүүлсэн задгай саналын товьёг

Хүснэгт 5.2 Төрийн байгууллагын төлөөллөөс ирүүлсэн задгай санал

№	Санал ирүүлсэн	Ирүүлсэн санал	Тайлбар
Давхардсан санал			
1	Төрийн байгууллага	Түүхий эдийн экспортын биет хэмжээ, үнийн төсөөллийг хийхдээ загвараас гадна түүхий эдийн зах зээлд одоо болон ирээдүйд нөлөөлөх гадаад, дотоод нөхцөл байдлын нөлөөллийг тусгах	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахдаа экспортын төсөөллийг уул уурхайн салбарын бодит үйл ажиллагааны төлөвлөгөө, идэвхжилийн төлөвт үндэслэн боловсруулах нь илүү оновчтой гэж үзсэн тул томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, Засгийн газраас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн нөлөө, хилийн боомтуудын хүчин чадалд үндэслэн боловсруулсан экспортын төсөөллийг ашигласан болно. Экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно.
		Төсвийн зарлагыг бууруулах	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2026 онд 31.7, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь байхаар бууруулж, ДХТХМ-д тусгасан болно.
		Алдагдалгүй төсөв батлах	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-2028 онд алдагдалгүй байхаар тооцож, саналыг тусгасан болно.
Давхардаагүй санал			
2	Монголбанк	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд орлогыг нарийн тооцож, улмаар түүнд суурилсан зарлагыг тохируулах нь зүйтэй.	Төсвийн тусгай шаардлагын дагуу Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-2028 онд алдагдалгүй байхаар тус тус тооцоолж, саналыг тусгасан болно.
		Орлогыг тооцохдоо Австрали, Африкийн нүүрсний үнийг ашиглахаас илүүтэй БНХАУ-ын зах зээл, тэр дундаа Өвөрмонгол, Бугат хот зэрэг Монгол улстай ойр зах зээлийн нүүрсний үнийг судлах, өөр арга замуудын талаар судлах.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад тус зарчмыг баримталдаг. Тухайлбал, экспортын үнийн төсөөллийг БНХАУ-ын болон дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзэж, олон улсын байгууллагуудын төсөөллийг нэг үндэслэл болгон боловсруулсан болно. Түүнчлэн, үнийн төлөв байдлыг тодорхойлоход Өвөрмонгол, Бугатаас гадна БНХАУ-д нүүрсний олборлолтоор тэргүүлдэг мужууд, Ганцмод

№	Санал ирүүлсэн	Ирүүлсэн санал	Тайлбар
		ТХМ-д авч үзэх экспортын голлох бүтээгдэхүүн (нүүрс, зэс)-ийн үнийн таамаглалын илүү бодитойгоор авч үзэх, МУ-ын эдийн засгийн өсөлт гадаад орноос их хамааралтай тул гадаад эдийн засгийн орчин, Хятадын өсөлт, геополитикийн эрсдэлийг харгалзаж үзэх	<p>боомтоос гадна Тианжин, Жинтан зэрэг бусад боомтуудын үнэ, БНХАУ-ын зах зээлийн нүүрсний үнийн индексүүдийг ашигладаг болно.</p> <p>Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад тус зарчмыг баримталдаг болно. Тухайлбал, экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно.</p>
3	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	ДХТХМ-ийг 2024 онд боловсруулахад ТТБЗ-ийн санал зөвлөмжийг тусгаагүй байснаас дараагийн сорилт, хүндрэл бий болсныг харгалзан үзэх	<p>ТТБЗ-өөс ирүүлсэн таамаглалтай нийцтэй болон нийцгүй байдлын талаар тайлбар, үндэслэлийг энэ танилцуулгын 2.3 дахь хэсгээс харах боломжтой.</p> <p>Тус зөвлөлийн 2024 онд боловсруулсан таамаглалд ашигласан загваруудад 2024 онд нүүрсний экспортын биет хэмжээ 58 сая тонн, нүүрсний үнэ 104-122 ам.доллар байх, эдийн засгийн бодит өсөлт 7.1 хувь байна гэж тооцож байсан. Мөн 2025 оны нүүрсний экспортын биет хэмжээг 51 сая тонн, үнийг 107-132 ам.доллар байх төсөөллийг ирүүлж байсан.</p>
4	Үндэсний аудитын газар	<p>Төсвийн зарлагыг төлөвлөхдөө гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бууруулах</p> <p>Уул уурхайн гол эрдэс баялгийн орлогын биет хэмжээг хэт өндрөөр төсөөлөхгүй байх</p>	<p>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд үр ашиггүй урсгал зардлыг бууруулах, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжих дэд бүтцийн томоохон төслүүдийг дэмжих бодлогыг баримтлан тусгасан.</p> <p>Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахдаа экспортын төсөөллийг уул уурхайн салбарын бодит үйл ажиллагааны төлөвлөгөө, идэвхжилийн төлөвт үндэслэн боловсруулах нь илүү оновчтой гэж үзсэн тул томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, Засгийн газраас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн нөлөө, хилийн боомтуудын хүчин чадалд үндэслэн боловсруулсан экспортын төсөөллийг ашигласан болно.</p> <p>Тухайлбал, нүүрсний экспортын биет хэмжээний төсөөллийг Монгол Улсын нийт нүүрсний экспортын 80 хувийг бүрдүүлдэг том аж ахуй нэгжүүдийн борлуулалтын төлөвлөгөө, бусад жижиг аж ахуй нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан. Мөн хил холболтын төслүүд зэрэг ирэх онуудад хэрэгжих экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөг тооцсон болно.</p>

№	Санал ирүүлсэн	Ирүүлсэн санал	Тайлбар
		Хөнгөлөлт, чөлөөлөлт, татаас урамшууллыг олгосноор гарах үр дүнг нь тодорхойлох	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав. Тухайлбал, "Хүнсний хувьсгал", "Цагаан алт", "Атар-4" зэрэг хөтөлбөр, аяны хэрэгжилтийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүдийн үр дүнг тооцоолж, эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөлд тусгасан болно.
		Үр дүнгүй, эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй зардалд татаас, урамшууллыг хасах	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
5	Төрийн байгууллага	Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг хэрхэн тусгасан талаар тайлагнадаг байх	Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолын дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг тайлагнадаг болно.
		Нүүрсний үнийн бууралт, мега төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөг сайтар судалж төсөөлөлдөө тусгах	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад экспортын үнийн төсөөллийг түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага, эрчимтэй өрнөж буй гадаад зах зээлийн өөрчлөлтүүдийг харгалзан үзэж, олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно. Нүүрсний хувьд үнийг дунд хугацаанд буурахаар тооцсон болно. Дунд хугацаанд хэрэгжих томоохон төслүүдийн нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүний барилга, боловсруулах, эрчим хүч болон бусад салбарууд, гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөлөлд тусгаж, төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг салбар хоорондын тэнцэл болон хагас бүтцийн GAP шинжилгээгээр тооцоолон төсөөлөлд тусгасан болно.
		Төсвийн зардлыг ДНБ 35%-аас ихгүй байхаар тооцох	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд орлого зарлагын тооцоог сайжруулах; Мега төслүүдийн нарийн тооцоог оруулж тооцох	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана. Дунд хугацаанд хэрэгжих мега төслүүдийн нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүний барилга, боловсруулах, эрчим хүч болон бусад салбарууд, гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөлөлд тусгаж, төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг салбар хоорондын тэнцэл болон хагас бүтцийн GAP шинжилгээгээр тооцоолон төсөөлөлд тусгасан болно.
		ТТБЗ-ийн төсөөлөл, таамаглалд үндэслэж, төсөвт учирч болох эрсдэлээс сэргийлж төсвийн дунд хугацааны төлөвлөлтийг хийх	ТТБЗ-өөс ирүүлсэн таамаглалын нийцтэй болон нийцгүй байдлын талаар тайлбар, үндэслэлийг энэ танилцуулгын 2.3 дахь хэсгээс харах боломжтой.

№	Санал ирүүлсэн	Ирүүлсэн санал	Тайлбар
		Мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, Төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.

5.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2020	2021	2022	2023	2024
БОДИТ СЕКТОР					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,453	43,555	53,852	70,442	79,956
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	-4.4	1.6	5.0	7.2	5.0
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-12.6	17.6	11.4	5.4	21.4
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-2.7	-7.5	13.9	18.0	0.5
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	11.0	-8.5	-20.3	-16.2	-16.8
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)					
Эцсийн хэрэглээ	3.6	-2.3	6.5	7.0	12.1
Өрхийн хэрэглээ	1.3	-4.0	5.1	6.3	8.6
Төрийн байгууллагын хэрэглээ	2.2	1.7	1.4	0.7	3.6
Хөрөнгийн нийт хуримтлал	-16.2	19.9	4.9	-1.6	9.3
Цэвэр экспорт	8.2	-16.0	-6.4	1.8	-16.4
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, жилийн дундаж, хувиар)	3.7	7.3	15.2	10.4	6.8
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,178	9,315	8,815	8,479	9,145
Алтны үнэ* (\$/трой. унци)	2,267	3,008	3,490	2,647	2,779
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	51	59	77	76	76
ДНБ дефлятор (хувиар)	3.7	14.4	17.7	21.8	8.2
(тэрбум төгрөгөөр)					
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Нийт орлого ба тусламжийн дүн	10,444	14,306	18,522	24,387	31,375
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,464	12,711	17,127	23,295	29,589
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904	15,630	18,160	22,509	30,365
Нийт тэнцэл	-3,460	-1,324	362	1,878	1,010
Нийт үндсэн тэнцэл	-2,521	-488	1,160	3,028	2,205
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,440	-2,919	-1,033	786	-776
МӨНГӨНИЙ СЕКТОР					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.2	13.8	6.5	26.8	15.2
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	-12.7	6.5	39.9	7.4	51.9
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.5	1.6	1.8	1.9	1.8
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.4	5.8	4.4	5.2	3.9
Зээлийн өсөлт** (хувиар)	-4.0	18.5	7.5	22.7	31.0
(сая ам.доллаароор)					
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ					
Төлбөрийн тэнцэл	787	-222	-727	1,457	622
Урсгал дансны тэнцэл	-675	-2,108	-2,304	121	-2,190
ГВУН	4,534	4,366	3,400	4,921	5,510
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	7.4	5.7	3.4	4.4	4.0
Гадаад валютын ханш					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,390
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,420
Нэрлэсэн үйлчилг буй ханшийн индекс (дунджаар)	43.0	41.3	38.8	37.6	39.6
Бодит үйлчилг буй ханшийн индекс (дунджаар)	102.9	102.8	105.7	111.1	120.2

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,453	43,555	53,852	70,442	79,956
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	26,655	27,092	28,455	30,567	32,054
	(өсөлт, хувиар)				
Бодит ДНБ-ий өсөлт	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Уул уурхайн	-9.9	0.8	-15.3	23.4	10.8
Уул уурхайн бус	-3.7	1.8	8.2	5.4	4.0
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	-8.9	-28.7
Уул уурхай	-9.9	0.8	-15.3	23.4	10.8
Боловсруулах аж үйлдвэр	3.4	-0.9	6.1	5.1	-1.2
Цахилгаан дулаан	1.8	9.4	3.3	5.0	4.8
Барилга	-3.2	-22.8	8.2	3.1	10.4
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	5.8	10.1	6.8	6.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-18.2	-7.3	9.2	39.6	23.1
Мэдээлэл, холбоо	5.2	20.7	6.6	17.0	15.5
Бусад үйл ажиллагаа	-2.6	3.8	5.4	5.8	7.8
Цэвэр татвар	-9.4	12.2	11.5	6.6	16.1
Дефлятор	3.7	14.4	17.7	21.8	8.2
	(нэгж хувиар)				
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо					
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-3.6
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах аж үйлдвэр	0.3	-0.1	0.5	0.4	-0.1
Цахилгаан дулаан	0.0	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.3
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.2	0.5	0.5
Бусад үйл ажиллагаа	-0.7	1.1	1.6	1.7	2.2
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.0
	(тэрбум төгрөгөөр)				
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,883	44,703	54,878	71,202	80,049
Анхдагч орлого	-3,526	-6,359	-5,072	-7,738	-8,588
Үндэсний нийт орлого	34,357	38,344	49,806	63,463	71,460
Хоёрдогч орлого	769	1,223	1,363	1,378	1,536
Үндэсний нийт цэвэр орлого	35,126	39,566	51,169	64,842	72,997
Нийт дотоод эрэлт	36,953	45,574	58,219	64,404	80,540
Үндэсний хадгаламж	6,556	9,985	15,747	24,317	20,156
Хөрөнгийн нийт хуримтлал	8,383	15,993	22,796	23,880	27,700

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
	(тэрбум төгрөгөөр)				
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444	14,306	18,522	24,387	31,375
Ирээдүйн өв сан	914	967	0	416	841
Тогтворжуулалтын сан	66	628	1,395	676	444
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,464	12,711	17,127	23,295	29,589
Татварын орлого	8,512	11,300	15,459	21,484	27,377
Орлогын албан татвар	2,227	3,326	3,827	5,703	8,981
Нийгмийн даатгалын орлого	1,586	2,286	3,038	3,951	4,700
Хөрөнгийн албан татвар	155	201	238	395	460
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,209	2,838	3,946	4,777	5,864
Онцгой албан татвар	777	827	848	790	1,098
Тусгай зориулалтын орлого	17	17	19	22	26
Гаалийн албан татвар	741	939	1,256	1,465	1,792
Бусад татвар, төлбөр, хураамж	800	866	2,288	4,382	4,455
Татварын бус орлого	952	1,412	1,668	1,811	2,212
Нийтлэг татварын бус орлого	785	1,250	1,364	1,452	1,770
Хөрөнгийн орлого	1	2	4	8	7
Тусламжийн орлого	166	160	300	351	435
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904	15,630	18,160	22,509	30,365
Урсгал зарлага	10,829	12,804	14,229	17,091	22,067
Цалин, хөлс	2,649	2,532	1,666	2,327	5,363
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,202	2,170	2,140	2,758	4,082
Татаас	375	454	537	580	955
Урсгал шилжүүлэг	4,663	6,813	9,088	10,276	10,472
Зээлийн үйлчилгээний төлбөр	939	836	798	1,150	1,195
Гадаад	776	681	694	1,054	1,146
Дотоод	163	155	104	96	49
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,075	2,826	3,930	5,418	8,299
Хөрөнгийн зардал	3,034	2,982	3,803	5,188	7,924
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41	-156	127	229	374
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,460	-1,324	362	1,878	1,010
ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-2,521	-488	1,160	3,028	2,205
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-4,440	-2,919	-1,033	786	-776

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
	(сая ам.доллараар)				
I. УРСГАЛ ДАНС	-675	-2,108	-2,304	121	-2,190
Бараа	1,756	1,370	1,233	4,549	2,947
Экспорт Ф.О.Б (кредит)	6,991	8,136	9,854	13,914	14,750
Импорт Ф.О.Б (дебит)	5,235	6,766	8,622	9,366	11,803
Үйлчилгээ	-1,450	-1,675	-2,355	-2,592	-3,057
Кредит	655	814	1,135	1,587	1,566
Дебит	2,105	2,490	3,490	4,179	4,623
Анхдагч орлого	-1,253	-2,232	-1,615	-2,233	-2,533
Кредит	341	292	344	455	573
Дебит	1,595	2,524	1,959	2,687	3,107
Хоёрдогч орлого	273	429	434	398	453
II. ХӨРӨНГИЙН ДАНС	103	114	154	135	171
Кредит	105	116	166	149	183
Дебит	2	2	12	14	12
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэгч/зээллэгч)	-1,504	-1,982	-1,644	-1,477	-3,158
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-1,693	-2,060	-2,428	-2,172	-2,515
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	563	25	445	818	-1,165
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	-6	-8	-11	-2	-13
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-369	60	351	-121	535
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	278	245	298	354	947
Зээл	-803	-501	67	-529	-585
Худалдааны зээл	156	413	-15	54	173
IV. Алдаа болон орхигдуулга	-146	-209	-222	-276	-517
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	787	-222	-727	1,457	622
V. Нөөц хөрөнгө	787	-222	-727	1,457	622
ГВУН	787	-225	-751	1,398	540
ОУВС-гийн зээл	0	-3	-24	-59	-82
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325	23,585
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921	5,510
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4	4.0
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,390
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,420

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
	(тэрбум төгрөгөөр)				
Гадаад цэвэр актив	5,816	3,806	2,492	8,959	8,535
Дотоод цэвэр актив	18,664	24,057	27,173	28,665	34,799
Дотоодын цэвэр зээл	19,136	24,298	25,648	29,106	35,343
Бусад цэвэр зүйлс	-472	-241	1,525	-441	-545
M2 мөнгө	24,481	27,863	29,665	37,624	43,334
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	753	847	831	906	978
Харилцах болон хадгаламж	23,728	27,016	28,834	36,719	42,356
	(өсөлт, хувиар)				
Жилийн өсөлт					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	15.2
Гадаад цэвэр актив	80.9	-34.6	-34.5	259.6	-4.7
Дотоод цэвэр актив	4.6	28.9	13.0	5.5	21.4
Дотоодын цэвэр зээл	2.3	27.0	5.6	13.5	21.4
ЗГ-аас авах авлага	-29.6	-49.8	107.6	91.3	64.2
Бусад салбараас авах авлага	-2.2	19.2	9.9	19.8	27.0
Улсын байгууллагаас авах авлага	1,492.6	25.0	-5.0	-16.7	13.1
Хувийн сектороос авах авлага	-7.2	18.8	10.8	21.7	27.5
	(нэгж хувиар)				
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	15.2
Гадаад цэвэр актив	12.4	-8.2	-4.7	21.8	-1.1
Дотоод цэвэр актив	3.9	22.0	11.2	5.0	16.3
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Мөнгөний эргэлтийн хурд	1.5	1.6	1.8	1.9	1.8
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	-1.0	16.3	23.6	30.8	13.5
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	9.0

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөрУлаанбаатар
хотМОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2026 он	2027 он	2028 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.4	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	33,479.5	35,628.6	39,086.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.7	30.4	29.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	33,479.5	35,628.6	39,086.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.7	30.4	29.6
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	0.0	0.0	0.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.0	0.0	0.0
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	30,314.5	33,282.2	36,442.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.7	28.4	27.6
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	3,165.0	2,346.4	2,644.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	52,750.0	52,794.0	59,490.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	45.0	45.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,664.3	2,774.1	2,909.4
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	2.4	2.2

Гарын үсэг

“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы хуралдаанаар Өрийн удирдлагын тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 14.2 дахь хэсэгт Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабрын дагуу батлуулахаар заасан.

Үүний дагуу Улсын Их Хурлын зүгээс 2015 онд “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг”, 2019 онд “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”, 2022 онд “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг тус тус баталсан. Засгийн газрын зүгээс дээрх стратегийн баримт бичгийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг өрийн удирдлагын үйл ажиллагааны үндсэн чиглэл болгон хэрэгжүүлж ирсэн бөгөөд стратегийн баримт бичгийн хүрээнд шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, гадаад, дотоод төлбөрүүдийг хугацаанд нь төлж барагдуулах, олон улсын зах зээлийн таатай үеийг ашиглан өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өрийн дарамтыг багасгаж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтийг тухай бүр Улсын Их Хуралд тайлагнаж ирсэн.

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг баталж, хэрэгжүүлснээр 2016 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 93.1 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 41.8 хувьд, 2017 онд төсвийн нийт зардлын 12.8 хувьтай тэнцэж байсан Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.8 хувьд тус тус хүрээд байна. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эс энд Пи, Фитч, Мүүдиз зэрэг агентлагууд Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2024 онд нэмэгдүүлж, В+, В2 түвшинд хүргэсний нэг шалтгаан нь Засгийн газрын өрийн оновчтой удирдлага, өрийн дарамт буурч байгаатай холбоотой болохыг онцолсон.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаа 2025 оноор дуусгавар болж байгаа бөгөөд Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу Сангийн яамны зүгээс тус стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлангийн хамт “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийн төслийг боловсруулаад байна.

Дунд хугацааны Засгийн газрын санхүүжилтийн боломжит эх үүсвэр, Засгийн газрын гадаад зээлийн тухайд Монгол Улсын хувьд 2011 онд Дэлхийн банкны аргачлалаар дунджаас доогуур орлоготой, 2024 онд дунджаас дээгүүр орлоготой орны ангилалд орсноор олон улсын санхүүгийн байгууллагууд, хөгжлийн түнш орнуудын олгох зээлийн нөхцөл хөнгөлөлттэй нөхцөлөөс арилжааны нөхцөл рүү шилжиж, гадаад зээлийн өртөг нэмэгдэж байна.

Засгийн газрын гадаад үнэт цаасны хувьд олон улсын зах зээлд эрэлт өндөр байгааг өмнө нь гаргасан Сенчири-3, Сенчири-4 бондуудын захиалгын хэмжээнээс харж болохоор байна. Ийнхүү эрэлт өндөр байгаа боловч АНУ-ын хэрэгжүүлж буй тарифын бодлогоос шалтгаалж гадаад бондын суурь хүүгийн түвшин өсөж 3-4 хувийн түвшинд

хэлбэлзэж, гадаад үнэт цаас босгох зардал харьцангуй өндөр байх хүлээлттэй байна. Харин Монгол Улсын Засгийн газрын хувьд эдийн засаг тогтмол өссөн болон олон улсын зах зээлд хөрөнгө оруулагчдад тогтмол мэдээлэл өгч, өрийн зохицуулалтын арга хэмжээний зориулалтаар бонд гаргаж ажилласны үр дүнд Мазаалай бондын эрсдэлийн нэмэгдэл 2016 онд 9.6 хувьтай тэнцэж байсан бол Сенчири-4 бондын хувьд 2025 онд 2.3 хувь болж буурсан.

Засгийн газрын дотоод үнэт цаас хувьд дотоодын хөрөнгийн зах зээлийн хэмжээ болон Төв банкны үнэт цаасны хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж эрэлт өндөр байна. Түүнчлэн, Засгийн газрын дотоод үнэт цаас гаргаснаар зах зээлд эрсдэлгүй хөрөнгийн өгөөжийн муруйг тогтоох бөгөөд улмаар хөрөнгийн зах зээлд гадаад хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэж, бусад оролцогчдын гаргах бондын хүү буурах ач холбогдолтой.

Дэлхийн банкнаас боловсруулсан MTDS загварыг ашиглан Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг гадаад, дотоод эх үүсвэрээс хэрхэн санхүүжүүлэхээс хамаарч Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн харьцаа тодорхойлогдож байгаа бөгөөд дунд хугацаанд Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээлээр томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр хүлээгдэж байна. Иймд стратегийн хүрээнд гадаад валютын нөөц болон төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр гадаад төлбөрийг төлөх, гадаад зээлийн хөрөнгөөр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх, үнэт цаасны арилжааг тогтмолжуулж дотоод болон гадаад үнэт цаасны зах зээлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мөн болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлахаар зорилт, арга хэмжээг боловсруулсан болно.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт дараах 4 зорилтыг тусгасан. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх бодлогыг баримтална.
- Засгийн газрын өрийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлж, дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлах;
- Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан зах зээлийн суурь хүүг тогтоох замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлэх зэрэг болно.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн багцын эрсдэлийн үзүүлэлтүүд сайжирч, дотоодын санхүүгийн зах зээл идэвхжин, Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны
стратегийн баримт бичиг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

Гарын үсэг

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

Нэг.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, стратеги нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд оршино. Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Сангийн яам нь стратегийн баримт бичгийг гурван жилд нэг удаа төсвийн хүрээний мэдэгдлийн хамт батлуулахаар заасан.

Хоёр.УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР¹, ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР²-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. Монгол Улсын эдийн засаг 2021-2024 онуудад жилд дунджаар 4.7 хувь өссөн нь улсын нийт гадаад өрийн эдийн засагт үзүүлэх ачааллыг бууруулав. Цар тахлын дараа эдийн засаг сэргэж, Монгол Улсын экспортын гол түүхий эдийн үнэ болон хэмжээ нэмэгдсэн. Улмаар улсын нийт гадаад өрийн хэмжээ 2021 оноос 2024 оны хооронд нийт 9.8 хувиар өсөж 37.1 тэрбум ам.долларт хүрсэн ч дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-д эзлэх хэмжээгээрээ 224 хувиас 157 хувьд хүрч буурсан байна.

Хүснэгт № 1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2019-2024 он, сая ам.доллар

Салбарын ангилал	2019	2020	2021	2022	2023	2024*
Засгийн газар	7,806.2	8,653.8	8,454.2	8,012.5	8,105.1	7,887.6
Төв банк	1,984.7	2,221.0	2,610.0	2,179.0	1,784.8	1,086.3
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,138.0	1,650.9	1,626.5	1,532.6	1,733.2	2,657.0
Бусад салбарууд	8,407.2	8,430.2	8,842.5	8,436.0	7,865.8	8,235.1
Компани хоорондын зээллэг, шууд хөрөнгө оруулалт	10,366.2	11,405.9	12,272.2	13,184.8	15,080.6	17,254.3
Нийт гадаад өр	30,702.3	32,361.8	33,805.5	33,344.8	34,569.5	37,117.3
ДНБ-д эзлэх хувь	216%	243%	224%	219%	170%	157%

*-Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Монголбанк

2.2. Дотоодын аж ахуйн нэгжүүд олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилт босгох нь нэмэгдэж байна. Эдийн засгийн хэтийн төлөв эерэг, зээлжих зэрэглэл өссөн зэрэг үзүүлэлтүүдээс шалтгаалж Монгол Улсын хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын олон улсын зах зээлд гаргаж буй бондын хэмжээ ихэссэн. Тухайлбал, 2024 онд Голомт банкнаас олон улсын зах зээлд 400 сая ам.долларын бондыг 11.0 хувийн хүүтэйгээр гаргасан, Худалдаа хөгжлийн банкнаас нийт 350 сая ам.долларын бондыг 8.5-9.5 хувийн хүүтэйгээр гаргасан бөгөөд үүнээс 50 сая ам.долларын бонд нь зорилтот буюу ногоон болон нийгмийн бонд байсан. Түүнчлэн, төрийн байгууллагуудын хувьд 2024 онд Монголын ипотекийн корпорацаас 202.7 сая ам.долларын бондыг 11.5 хувийн хүүтэйгээр гаргасан, мөн тус хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын

¹ Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.4-т “улсын нийт гадаад өр гэж Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн харьяат бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүргийг” гэж заасан.

² Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д “Засгийн газрын өр гэж а/ өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийг үүргийг; б/ хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж заасан.

газар /цаашид “НЗДТГ” гэх/-аас 500 сая ам.долларын бондыг 7.75 хувийн хүүтэйгээр тус тус гаргаад байна.

2.3. Засгийн газрын өрийн харьцаа хуулийн хязгаарыг³ хангахын зэрэгцээ жил бүр буурсаар байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2019 онд 64.9 хувьтай тэнцэж байсан бөгөөд 2020 онд цар тахлын нөлөөллөөс шалтгаалан өсөж 75.5 хувь болсон. Үүнээс хойш жил бүр буурч 2024 оны жилийн эцсийн байдлаар 41.8 хувь буюу 33.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 2. Засгийн газрын өр, 2019-2024 он, тэрбум төгрөг

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2019	2020	2021	2022	2023	2024*
1. Засгийн газрын дотоод өр	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1	400.5
1.1. Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1	400.5
2. Засгийн газрын гадаад өр	20,728.1	24,851.4	24,693.3	29,641.6	30,274.6	30,247.8
2.1. Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7	8,655.0
2.2. Зээл	12,800.9	16,497.4	16,517.7	20,281.8	20,902.9	21,592.7
3. Бусад өр төлбөр	2,072.1	1,910.6	1,567.6	1,287.7	264.8	2,736.4
3.1. Засгийн газрын өрийн баталгаа ⁴	1,076.3	1,060.4	876.5	811.8	29.5	178.0
3.2. Орон нутгийн өр	-	-	17.2	12.3	4.5	2,558.4
3.3. Концесс (“барих-шилжүүлэх”)**	995.7	850.2	673.9	463.5	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (1+2+3)	24,199.7	27,898.6	26,918.1	31,964.8	30,773.5	33,384.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ***)	20,525.6	23,024.3	21,837.3	27,690.6	26,582.9	
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар****	75.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	65.0% (ӨҮЦ)	60.0% (Нэрлэсэн)
Засгийн газрын өр / ДНБ	64.9%	75.5%	62.6%	60.5%	43.7%	41.8%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	55.1%	62.3%	50.8%	52.4%	37.7%	

Эх сурвалж: Сангийн яам

* Урьдчилсан гүйцэтгэл

** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дахь хэсэг хүчингүй болсон.

*** Өнөөгийн үнэ цэн

**** УИХ-аас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг байсныг нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл болгож өөрчилсөн.


2.4. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл Засгийн газрын өрийн 1.2 хувьтай тэнцэж байна. Засгийн газраас 2012-2017 оны хооронд нийт 15.9 их наяд төгрөгийн Засгийн газрын дотоод үнэт цаас /цаашид “ЗГДҮЦ” гэх/ арилжаалсан. Улмаар 2016 оны жилийн эцэст 3 сарын хугацаатай ЗГДҮЦ-ны хүүгийн түвшин 17 хувьд хүрч, төсвийн нийт зардалд эзлэх нийт хүүгийн зардлын хэмжээ 12.8 хувь болж төсөвт учруулах төлбөрийн дарамт нэмэгдсэн тул 2017 оны 10 дугаар сард ЗГДҮЦ-ны арилжааг тодорхойгүй хугацаагаар зогсоож, өндөр хүүтэй үнэт цаасыг дотоодын зах зээлээс хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах арга хэмжээг авч

³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан.

⁴ Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.7-д “Засгийн газрын өрийн баталгаа гэж баталгаа гаргуулагч нь гэрээнд заасан төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийн баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүргийг” гэж заасан.

хэрэгжүүлсэн. Үүний дагуу ЗГДУЦ-ны үлдэгдэл 2017 оноос тогтмол буурч 2024 оны эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

График № 1. Дотоод үнэт цаас, 2017-2024 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

2.5. Засгийн газраас олон улсын зах зээлийн таатай үед өрийн зохицуулалтын арга хэмжээг⁵ авч хэрэгжүүлсээр байна. Засгийн газар 2017 оноос эхлэн өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд гадаад үнэт цаасны томоохон төлбөрүүдийг шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, 2017-2023 оны хооронд нийт 6 удаагийн өрийн зохицуулалтын хүрээнд 3.0 тэрбум ам.долларын эргэн төлөлтийг төлж барагдуулсан. Засгийн газрын хувьд 2021-2024 онд нийт 2.9 тэрбум ам.долларын гадаад бондын өр төлбөр хүлээгдэж байсан бөгөөд үүнийг Сенчири-1, Сенчири-2, Сенчири-3 бондын хүрээнд төлсөн. Сенчири-1 бондын хувьд түүхэн хамгийн бага хүүтэйгээр гарсан, Сенчири-2 бондыг цар тахлын дараах олон улсын санхүүгийн хямралын үед амжилттай гаргасан бол Сенчири-3 бондыг хамгийн бага эрсдэлийн нэмэгдэлтэйгээр гаргасан.

Хүснэгт № 3. Гадаад үнэт цаас, тэрбум төгрөг, 2024.12.31-ний байдлаар

№	Гадаад үнэт цаас	Купон	Хугацаа	Эргэн төлөх огноо	Үлдэгдэл /сая ам.доллар/	Үлдэгдэл /тэрбум төгрөг/
1	Номад	5.125%	5.5 жил	2026.04.07	572.7	1,958.7
2	Сенчири-1 2027 ¹	3.500%	6 жил	2027.07.07	420.1	1,436.8
3	Сенчири-1 2031 ¹	4.450%	10 жил	2031.07.07	510.7	1,746.7
4	Сенчири-2	8.650%	5 жил	2028.01.19	675.1	2,309.2
5	Сенчири-3	7.875%	5.5 жил	2029.06.05	351.9	1,203.6
	НИЙТ				2,530.5	8,655.0

Эх сурвалж: Сангийн яам

Түүнчлэн, Засгийн газраас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Сенчири-4 бондыг олон улсын зах зээлд 6.625 хувийн хүүтэйгээр гаргаж 2026 болон 2028 онд төлөгдөх нийт 500 сая ам.долларын үнэт цаасыг буцаан худалдан авсан. Тус бондын хүү Америкийн Нэгдсэн Улс /цаашид “АНУ” гэх/-ын үнэт цаасны хүүнээс 2.3 хувиар өндөр буюу эрсдэлийн нэмэгдэл өмнөх үнэт цааснуудаас хамгийн бага тогтсон. Энэ нь Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байгааг харуулж байгаа бол нөгөө талаар зах зээлийн тохиромжтой үед буюу АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалж санхүүгийн зах зээлд тогтворгүй нөхцөл байдал үүсэхээс өмнө арилжаалж чадсантай холбоотой байна.

⁵ Өрийн удирдлагын тухай хуулийн 20.1-д өрийн зохицуулалтын арга хэмжээг валютын болон хүүгийн своп /солилцоо/ хийх, валютын форвард хэлцэлд орох, өрийг дахин санхүүжүүлэх, шилжүүлэх болон худалдах, өрийг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах гэж тодорхойлсон.

2.6. Гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр гэрээ байгуулсан төслүүдийн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын Засгийн газар 1991 оноос Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банк /цаашид “АХБ” гэх/-ны гишүүнээр элсэн орж, олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс зээл авч ашиглаж ирсэн бөгөөд нийт гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6,313.2 сая ам.доллар буюу 21,592.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 102 төсөлд 3,255.9 тэрбум төгрөг буюу 964.7 сая ам.долларын зээлийн хөрөнгийг авч ашигласан болно. Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 2023-2024 онд гадаад зээлийн төлбөрт нийт 3,206.6 тэрбум төгрөгийг төлж, үүнээс үндсэн төлбөрт 2,192.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1,013.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

Засгийн газрын гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 12.6 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа боловч гадаад зээлийн ашиглалтын хэмжээ 2019-2025 онд жилд 1.1-2.2 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг түргэсгэж, ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлага үүсээд буйг харуулж байна.

2.7. Аймаг, нийслэл үнэт цаас⁶ гаргах эрхтэй болж, санхүүгийн шинэ хэрэгсэл ашиглаж эхэлсэн. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль 2021 онд батлагдсанаар⁷ аймаг, нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд, Өрийн удирдлагын тухай хуульд 2024 онд өөрчлөлт орсноор⁸ нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрхтэй болсон.

Үүний дагуу НЗДТГ-аас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл”-д зориулж гаргаад байна. Ингэснээр орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,558.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс 2.2 их наяд төгрөгийн өр төлбөрийг 2025-2027 оны хооронд төлөхөөр байгаа нь нийслэлийн өрийн удирдлага болон эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх шаардлагыг үүсгэж байна.

Хүснэгт № 4. Орон нутгийн өр, 2024.12.31-ний байдлаар

№	Үнэт цаас гаргагч	Зориулалт	Гаргасан огноо	Эргэн төлөх огноо	Нэрлэсэн үлдэгдэл
					Тэрбум төгрөг
1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2025.06.25	106.2
2		Зам засвар, арчилгаа	2024.06.25	2026.06.25	106.8
3		Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станц барих	2024.06.25	2027.06.25	321.9
4		Батарей хуримтлуурын станц барих	2024.12.26	2029.12.26	298.4
5		Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах	2024.11.29	2027.08.29	1,725.1
	НИЙТ				2,558.4

Эх сурвалж: Сангийн яам

⁶ Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.24-т “аймаг, нийслэлийн үнэт цаас гэж аймаг, нийслэлээс тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор тогтоосон ноцол, журмын дагуу олон нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах өрийн бичгийг.” гэж заасан.

⁷ Хуулийн 13.1-т “Нийслэл хуульд заасан ноцол, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.” гэж заасан

⁸ Хуулийн 28¹.1-т “Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгатаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.” гэж нэмсэн

Гурав.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хийх зээллэгийн зардлыг бууруулах, хөрөнгө оруулагчийн идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 11 удаа Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сард батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад баталгаа гаргуулагч болон төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага⁹ хуульчлагдаж, өрийн баталгаа гаргуулах хүсэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх, төсөл, арга хэмжээнд хяналт тавих зэрэг эрх зүйн орчин бүрдсэн. Тус хууль батлагдахаас өмнө Засгийн газрын зүгээс Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид “МУХБ” гэх/-ны дунд хугацааны евро бонд, Самурай бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид “БНХАУ” гэх/-ын Хөгжлийн банкнаас авсан зээл, “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн санхүүжилт зэрэг нийтдээ 2.7 их наяд төгрөгтэй тэнцэх зээллэгүүдэд Засгийн газрын өрийн баталгааг гаргасан байдаг.

Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаас хойш МУХБ-ны Оросын Холбооны Улс /цаашид “ОХУ” гэх/-ын ВТБ банкнаас авсан зээл, Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаас, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн АХБ-аас авсан зээл, шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн арилжааны банкнаас авч ашигласан зээл, МУХБ-ны БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл болон НЗДТГ-аас олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.

Хүснэгт № 5. Засгийн газрын өрийн баталгаа

№	Баталгаа гаргуулагч	Баталгаа гаргасан огноо	Дүн /сая нэгж/	Валют	Хүү	Хугацаа	Тайлбар
1	МУХБ	2012.03.21	580.0	ам.доллар	5.75%	5 жил	Төлөгдсөн
2	МИАТ	2013.12.24	77.5	ам.доллар	2.52%	10 жил	Төлөгдсөн
	МИАТ	2013.12.24	24.0	ам.доллар	5.3%+LIBOR	7 жил	Төлөгдсөн
	МИАТ	2013.12.24	20.0	ам.доллар	9.38%+LIBOR	5 жил	Төлөгдсөн
3	МУХБ	2014.01.06	30,000.0	иен	1.52%	10 жил	Төлөгдсөн
4	МУХБ	2014.09.03	162.0	ам.доллар	6.00%	8 жил	Төлөгдсөн
5	МУХБ	2014.09.05	300.0	ам.доллар	4.25%+LIBOR	5 жил	Төлөгдсөн
6	МУХБ	2015.05.19	500.0	ам.доллар	9.375%	5 жил	Төлөгдсөн
7	МУХБ	2016.04.19	65.4	ам.доллар	5.75%+LIBOR	3 жил	Төлөгдсөн
8	Эрдэнэс Монгол	2016.04.01	35.0	ам.доллар	0.5%+LIBOR	15 жил	Төлөгдсөн
9	Шатахуун импортлогч 8 аж ахуйн нэгж	2022.04.20	236,444.1	төгрөг	12%	3 сар	Төлөгдсөн
10	МУХБ	2024.05.01	420.0	юань	5.1%	10 жил	2031 онд төлөгдөж дуусна
11	НЗДТГ	2024.11.29	500.0	ам.доллар	7.75%	2.75 жил	2027 онд төлөгдөж дуусна
Нийт			2,543.9 сая ам.доллар				

Эх сурвалж: Сангийн яам

3.2. Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд – МУХБ-ны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 580.0 сая ам.долларын, жилийн 5.75 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай,

⁹ Хуулийн 33 дугаар зүйлд Засгийн газрын өрийн баталгаа, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлсон

Засгийн газрын баталгаатай үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр олон улсын зах зээлд арилжаалсан. Тус үнэт цаасыг өрийн зохицуулалтын хүрээнд 2017 оны 03 дугаар сард “Хуралдай” бондыг гаргаж дахин санхүүжүүлсэн болно.

3.3. Боинг нисэх онгоц худалдан авах зээл – АНУ-ын ЭКСИМ банк, ING CAPITAL LLC болон “МИАТ” ТӨХК-ийн хоорондын 121.4 сая ам.доллартой тэнцэх зээлд 2013 онд Засгийн газраас гаргасан бөгөөд Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авах зориулалттай зээл нь дараах 3 дэд зээлд хуваагддаг. Үүнд:

- АНУ-ын Экспорт-Импорт банканд 77.4 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь жилийн тогтмол 2.52 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай зээл;
- ING CAPITAL LLC банканд 23.9 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь хөвөгч хүү болох 3 сарын хугацаатай LIBOR¹⁰ дээр 5.3 хувийн нэмэгдэлтэй, 7 жилийн хугацаатай зээл;
- ING CAPITAL LLC банканд 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын, хүү нь хөвөгч хүү болох 3 сарын хугацаатай LIBOR дээр 9.38 хувийн нэмэгдэлтэй зээлд тус тус Засгийн газрын баталгаа гаргасан.

Тус зээлийн эх үүсвэрийн сүүлийн эргэн төлөлтийг 2023 онд хийх хуваарьтай байсан бол баталгаа гаргуулагч “МИАТ” ТӨХК-аас 2022 оны 06 дугаар сард хугацаанаас өмнө бүрэн төлж барагдуулсан.

3.4. Самурай бонд – МУХБ-ны 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай “Самурай” үнэт цаасыг 2013 онд Япон Улсын зах зээлд Японы хамтын ажиллагааны банкны баталгаатайгаар (JBIC¹¹) жилийн 1.52 хувийн хүүтэйгээр арилжаалсан. МУХБ-аас тус бондын төлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр банкны өөрийн мөнгөн хөрөнгийг ашиглаж бүрэн төлж барагдуулсан болно.

3.5. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл – МУХБ болон БНХАУ-ын Хөгжлийн банк хоорондын 162.0 сая ам.доллартой тэнцэх зээлд Монгол Улсын Засгийн газрын зүгээс 2014 онд баталгаа гаргасан. Тус зээлийн хугацаа нь 8 жил, зээлийн хүү нь жилийн тогтмол 6 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байсан. МУХБ-ны зүгээс хуваарийн дагуу тус зээлийн эх үүсвэрийг 2023 онд төлж дуусгах хуваарьтай байсан бол 2022 оны 09 дүгээр сард буюу хуваарьт хугацаанаас өмнө зээлийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан байна.

3.6. Кредит Свисс банкны зээл – МУХБ-ны 300.0 сая ам.доллартой тэнцэх зээлд 2014 онд Засгийн газар баталгаа гаргасан. Энэхүү зээл нь 7 жилийн хугацаатай ба эхний 2 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байсан. Зээлийн хүү хөвөгч хүү болох 6 сарын хугацаатай LIBOR дээр 4.375 хувийн нэмэгдэлтэй байсан. Тус зээлийн төлбөрийг 2021 онд бүрэн төлж барагдуулсан болно.

3.7. Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бонд - Худалдаа хөгжлийн банкны Глобал үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын бондод Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т¹² заасны дагуу 1.0 их наяд төгрөгийн нэрлэсэн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг барьцаалах замаар Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан болно. Худалдаа хөгжлийн банкны зүгээс үнэт цаасны төлбөрийг 2020 оны 05 дугаар сард бүрэн төлж барагдуулсан.

¹⁰ London interbank offer rate

¹¹ Japan Bank for International Cooperation

¹² Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т “Баталгаа гаргуулагч нь хийх гадаад зээллэгтэйгээ тэнцүү хэмжээгээр өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан тохиолдолд тухайн зээллэгийн нийт дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч этгээд хариуцахаар баталгааны гэрээнд тусгана.” гэж заасан.

3.8. ОХУ-аас авах газрын тосны бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх худалдааны зээлийн шугам - Засгийн газрын 2015 оны 93 дугаар тогтоолын дагуу ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортлоход шаардагдах гадаад валютын урсгалыг тэнцвэржүүлэх зорилгоор МУХБ нь ОХУ-ын ВТБ банктай 300.0 сая ам.долларын 36 сарын хугацаатай зээлийн гэрээг Засгийн газрын өрийн баталгаатайгаар 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан. Уг зээлийн гэрээний дагуу зээлийн шугамын эхний хэсэгчилсэн санхүүжилтийн хүү нь LIBOR хүүгийн 3 сарын дундаж хэмжээн дээр 5,75 хувийн нэмэгдэлтэй, 65.4 сая ам.долларыг МУХБ авсан бөгөөд зээлийн төлбөрийг 2016 оны 12 сарын 01-ний өдөр бүрэн төлж барагдуулсан.

3.9. АХБ-наас олгосон техник туслалцааны зээл – АХБ болон “Эрдэнэс Монгол” ХХК хоорондын 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.доллартой тэнцэх, хөвөгч хүү болох 6 сарын хугацаатай LIBOR дээр 0.6 хувийн нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлд Засгийн газар өрийн баталгаа гаргасан. Зээлийг “Эрдэнэс Монгол” ХХК 2024 оны 10 дугаар сард хугацаанаас нь өмнө буцаан төлж барагдуулсан.

3.10. Шатахууны импортын урьдчилгаа төлбөрт гаргасан Засгийн газрын өрийн баталгаа – Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т¹³ заасны дагуу Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдийн ОХУ-ын “Роснефть НХН”-ээс АИ-92 авто бензин худалдан авах зориулалтаар ондоо эргэн төлөгдөх нөхцөлтэй арилжааны банкнуудаас авах зээлийн эргэн төлөлтөд “Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай” Засгийн газрын 160 дугаар тогтоол 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан. “Роснефть” НХН-тэй худалдан авах гэрээ байгуулсан шатахуун импортлогч 8 компанийн зээлд нийт 236.4 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр бүх зээл төлөгдөж, гэрээний үүрэг дуусгавар болсон.

3.11. МУХБ-ны БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авч ашигласан зээл 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна - Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд зориулж МУХБ-д 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээл 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна.

3.12. Засгийн газраас 2024 онд өрийн баталгаа гаргасан Нийслэлийн гадаад үнэт цаасны хугацаа 2027 онд дуусгавар болно- Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолын дагуу “Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл”-ийн бүтээн байгуулалтыг Нийслэлийн гадаад үнэт цаас гарган санхүүжүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Энэхүү үнэт цаас нь 500 сая ам.долларын хэмжээтэй, 2.75 жилийн хугацаатай, 7.75 хувийн хүүтэй бөгөөд 2027 оны 08 дугаар сард төлөгдөх хуваарьтай байна.

Дөрөв. САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭР

4.1. Олон талт болон хоёр талт хөгжлийн түншүүдээс авах хөнгөлөлттэй гадаад зээл нь Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг нөхөх гол хэрэгсэл байсаар ирсэн. Монгол Улс 1991 онд Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын байгууллагуудын гишүүн орноор элсэн орж, улмаар

¹³ Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6.1.3-т “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарын хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах” гэж заасан.

эдгээр байгууллагуудаас нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авч төсөл, хөтөлбөр санхүүжүүлж эхэлсэн.

4.2. Монгол Улс Дэлхийн банкны ангиллаар дунджаас дээгүүр орлоготой орон болсноор гадаад зээлийн өртөг нэмэгдэж байна. Монгол Улс Дэлхийн банкны орлогын ангиллаар 2011 онд дунджаас доогуур орлоготой (lower middle income) орны ангилалд орсон бол 2024 онд дунджаас дээгүүр орлоготой (upper middle income) орны ангилалд шилжсэн. Үүний үр дүнд олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас Монгол Улсад олгох зээлийн нөхцөл өөрчлөгдөж, нэн хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлттэй эх үүсвэр холимог буюу энгийн нөхцөлтэй зээлийн эх үүсвэр рүү шилжиж байна. Тухайлбал, Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын байгууллагуудын зүгээс олгодог байсан 2 хувийн хүүтэй, 30 хүртэлх жилийн хугацаатай зээлийн эх үүсвэр одоо хувьсах хүүтэй буюу SOFR¹⁴ дээр 0.6-1.3 хүртэлх хувийн нэмэгдэлтэй, 25 жил хүртэл хугацаатай болж өөрчлөгдсөн. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн орнуудын (Япон, Өмнөд Солонгос, Австри гэх мэт) олгодог гадаад зээлийн өртөг нэн хөнгөлөлттэй нөхцөлөөс хөнгөлөлттэй нөхцөл рүү шилжихээр байна.


4.3. Засгийн газраас олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасны эрэлт өндөр байна. Монгол Улсын Засгийн газраас олон улсын зах зээлд хамгийн сүүлд буюу 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр гаргасан 500 сая ам.долларын хэмжээтэй “Сенчири-4” бондын хөрөнгө оруулагчдын захиалга 3.8 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь нийт зарласан бондын хэмжээнээс 7.6 дахин их үзүүлэлт болно. Хөрөнгө оруулагчдын бүтцийг харвал 41 хувийг Азийн хөрөнгө оруулагчид, 39 хувийг Европ, Ойрх дорнодын хөрөнгө оруулагчид, 20 хувийг Америкийн хөрөнгө оруулагчид эзэлж байсан.

4.4. Засгийн газрын гадаад бондын эрсдэлийн нэмэгдэл¹⁵ бага түвшинд байна. Засгийн газрын хувьд тогтмол олон улсын зах зээлд бонд гаргаснаар эрсдэлийн нэмэгдлийн хэмжээ жил ирэх тусам буурч байна. Тухайлбал, эрсдэлийн нэмэгдэл 2016 оны Мазаалай бондын хувьд 9.6 хувь байсан бол зээлжих зэрэглэл нэмэгдсэн, эдийн засаг тогтмол өссөн, олон улсын зах зээлд хөрөнгө оруулагчдад тогтмол мэдээлэл өгч, зах зээлд тогтмол өрийн зохицуулалтын арга хэмжээний зориулалтаар бонд гаргаж ажилласны үр дүнд хамгийн сүүлд арилжаалсан Сенчири-4 бондын хувьд 2025 онд 2.3 хувьтай тэнцэж байна.

График № 2. Засгийн газрын гадаад бондын эрсдэлийн нэмэгдэл, хувиар

¹⁴ Secured Overnight Financing Rate

¹⁵ АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж, Монгол Улсын Засгийн газрын бондын өгөөжийн зөрүү




Эх сурвалж: Bloomberg terminal

4.5. Олон улсын зах зээлд ам.долларын бондын суурь хүү 2022 оноос нэмэгдсэн бөгөөд дунд хугацаанд өндөр түвшинд хадгалагдах магадлалтай байна. Доорх графикт АНУ-ын 5 жилийн хугацаатай бондын өгөөж 2025 оны 02 дугаар сард 4.4 хувьтай тэнцэж байсан болно.

АНУ-ын төрийн сангаас гаргасан бондын өгөөжийн муруй 2025 оны 4 дүгээр сарын байдлаар дараах байдалтай байна. Энэхүү графикаас харахад АНУ-ын үнэт цаасны өгөөж 2023 оноос хойш тогтмол 3.5-5 хувийн хооронд хэлбэлзэж байна.

График № 3. Засгийн газрын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн өртөг, хувь



Эх сурвалж: Bloomberg

Тус улсын шинээр томилогдсон ерөнхийлөгчийн¹⁶ барих тарифын бодлогоос шалтгаалсан тодорхой бус байдал нь инфляцын бууралтыг удаашруулах нөлөөтэй байх бөгөөд 2025 онд бодлогын хүүг бууруулахаар төсөөлж байсан хэмжээг удаашруулах нөхцөл болсон талаар томоохон мэдээллийн эх сурвалж болох “Ройтерс” (Reuters), “Эй Би Си ньюс” (ABC news) зэрэг байгууллагуудаас үзэж байна.

¹⁶ АНУ-ын ерөнхийлөгч 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр томилогдсон

4.6. Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг нөхөх зорилгоор ЗГДҮЦ арилжаалах шаардлага бага байгаа ч дотоодын зах зээлд ЗГДҮЦ-ны эрэлт өндөр байна. Тухайлбал, 2022-2024 онуудад төсвийн гүйцэтгэлээр алдагдал төлөвлөсөн хэмжээнээс бага гарсан бөгөөд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу нэгдсэн төсвийн тэнцлийг тэнцвэржүүлсэн алдагдалгүй байхаар баталсан.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд зах зээлийн нийт үнэлгээ 2017 онд 1.3 их наяд төгрөг байсан бол 2024 онд 13.0 их наяд төгрөг болж өссөн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд оролцох идэвх хурдтай нэмэгдэж байгааг харуулж байна. Монголын хөрөнгийн биржээр 2024 онд нийтдээ 1.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний компанийн бонд болон хувьцааны арилжаа хийгдсэн байна.

График № 4. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, 2017-2024 он, тэрбум төгрөг





График №5. Төв банкны үнэт цаасны хэмжээ, 2017-2025 он, тэрбум төгрөг



Түүнчлэн, ЗГДҮЦ-ны арилжааг зогсоосонтой холбоотойгоор Төв банкны үнэт цаасны хэмжээ өссөн. Тухайлбал, 2017 онд 589 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан үнэт цаасны хэмжээ 2020 онд 5,050 тэрбум төгрөг, 2023 онд 6,256 тэрбум төгрөг, 2025 оны 03 дугаар сарын байдлаар 9,131 тэрбум төгрөг хүрч өсөөд байна.

4.7. ЗГДҮЦ-ны зах зээлийн хөгжлийг дэмжих нь өндөр ач холбогдолтой. ЗГДҮЦ нь Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг хурдан хугацаанд нөхөж Засгийн газрын өрийн багцын эрсдэлийг бууруулахаас гадна хөрөнгийн зах зээлийн суурь хүү буюу өгөөжийн муруйг тогтоодог хөрөнгийн зах зээлийн хамгийн чухал бүтээгдэхүүний нэгд тооцогддог байна.

4.8. ЗГДҮЦ-ны арилжааг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна. Иймд цаашид Монгол Улсын өрийн багц дахь гадаад зах зээлийн эрсдэлийг бууруулах, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд ЗГДҮЦ-ны үнэт цаас гаргах хэмжээг тусгасан¹⁷ тул 2025 оны 04 дүгээр сараас эхлэн тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.

Тав.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦ ДАХЬ ЗАРДАЛ, ЭРСДЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

5.1. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүдийг Дэлхийн банк болон Олон улсын валютын сангаас хамтран боловсруулсан өрийн удирдлагын дунд

¹⁷ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 11.1-д Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.3-г заасан зориулалтаар хийх дотоод зээллэгийн дээд хэмжээ 300,000.0 сая төгрөг хүртэл гэж заасан.

хугацааны стратегийн (MTDS¹⁸) загварыг ашиглан тооцсоноор 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд, 2024 он


Эрсдэлийн үзүүлэлт		ЗГ-ын өр Баталгаа ороогүй	ЗГ-ын өр Баталгаа орсон
Өрийн багцын зардал	Хүүгийн зардлын ДНБ-д эзлэх хувь	1.6	1.6
	Жигнэсэн дундаж хүү (хувь)	4.3	4.6
Дахин санхүүжилтийн эрсдэл	АТМ ¹⁹ (жил)- эргэн төлөгдөх дундаж хугацаа	7.5	7.2
Хүүгийн түвшний эрсдэл	АТР ²⁰ (жил)- хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа	6.5	6.3
Ханшийн эрсдэл	Гадаад валютаарх өр (нийт өрд эзлэх хувь)	96.1	96.3

Эх сурвалж: Сангийн яам

5.2. Засгийн газрын өрийн хүүгийн дундаж түвшин олон улсын зах зээлээс шалтгаалж өсөж байгаа ч дотоод үнэт цаасны үлдэгдэл буурснаар хүүгийн зардлын төсөвт үзүүлэх дарамт буурсан байна. Засгийн газрын өрийн хүүгийн зардлыг ДНБ-д харьцуулсан харьцаа 2017 онд 4.3 хувьтай тэнцэж байсан бол 2024 онд 2.7 нэгж хувиар буурч, ДНБ-ний 1.6 хувьтай тэнцэж байна. Үүнээс Засгийн газрын гадаад өрийн зардал ДНБ-ний 1.6 хувь, дотоод өрийн зардал ДНБ-ний 0.1 хувь байна.

Түүнчлэн, жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2017 онд 4.8 хувь байсан бол ЗГДҮЦ-ны үлдэгдэл буурсантай холбоотойгоор 2022 он хүртэл тогтмол буурч 2.9 хувьд хүрээд байсан бол 2022 оноос SOFR түвшин 5 хувиар өссөнтэй холбоотойгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар жигнэсэн дундаж хүү 4.2 хувьд хүрч, 1.3 хувиар өссөн байна.

График № 6. Засгийн газрын жигнэсэн дундаж хүүгийн түвшин, 2017-2024 он, хувь



Эх сурвалж: Сангийн яам

5.3. Засгийн газрын хугацаа тулсан томоохон өр төлбөрийн дарамт бага байна. Засгийн газрын өрийн багцын дахин санхүүжилтийн эрсдэлийн хувьд өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2024 оны жилийн эцсийн байдлаар 7.5 жилтэй тэнцэж байгаа нь 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулахад 1 жилээр бага байна. Энэ нь гадаад үнэт цаасны эргэн төлөгдөх дундаж хугацаа 0.7 жилээр буурсан, гадаад зээлийн шинээр авч ашиглаж буй зээлийн хугацаа 30-40 жил байсан бол 15-25 жил болж буурсантай холбоотой байна.


¹⁸ Medium Term Debt Strategy

¹⁹ Average time to Maturity

²⁰ Average time to Re-fixing

Засгийн газрын өрийн дахин санхүүжилтийн эрсдэлийн хувьд гадаад үнэт цаасны төлбөр 2026 оныг хүртэл байхгүй бөгөөд Номад бондын төлбөр 2026 оны 04 дүгээр сард 174.3 сая ам.доллар төлөгдөх хуваарьтай байна. Засгийн газрын гадаад үнэт цаасны хуваарьт төлбөрийн дарамт буурсан нь өрийн зохицуулалтын үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлсний үр дүн бөгөөд хамгийн сүүлд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр олон улсын зах зээлд 500 сая ам.долларын “Сенчири-4” үнэт цаасыг 6.625 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар гаргаж хугацаа тулсан “Номад” бондын 391.7 сая ам.доллар болон “Сенчири-2” бондын 108.3 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлсэн.

График № 7. Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа, 2017-2024, жил




Эх сурвалж: Сангийн яам

5.4. Олон улсад жишиг хөвөгч хүүгийн түвшний буурах төсөөлөл удааширсан бөгөөд гадаад зээлийн нөхцөл хөвөгч хүүд шилжиж байна. Засгийн газрын өрийн багц дахь хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /ATR/ 6.5 жилтэй тэнцэж байна. Хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа нь тухайн өрийн хэрэгслийн хүү дунджаар хэдэн жилийн дотор бүрэн шинэчлэгдэхийг тооцоолдог үзүүлэлт ба үүнд хувьсах хүүтэй өрийн хүү хагас жил хүртэлх хугацаанд бүрэн шинэчлэгддэг бол тогтмол хүүтэй өрийн хувьд тус өр төлөгдөж дуусахад түүнийг дахин санхүүжүүлэх эх үүсвэрийн хүү тогтдог.

АНУ-д инфляц 2022 оны 3 дугаар сард сүүлийн 40 жилийн хамгийн дээд түвшиндээ хүрсний улмаас тус улсын бодлогын хүүгийн түвшин өсөж 2023 онд дээд түвшиндээ хүрсэн. Харин 2024 оноос эхлэн тус хүүг 1 хувиар бууруулсан хэдий ч 2025 онд шинээр томилогдсон ерөнхийлөгчийн тарифын бодлогоос шалтгаалж инфляцын төсөөлөлд өөрчлөлт орсноор бодлогын хүүгийн бууралт удааших төлөвтэй байна.

График № 8. Засгийн газрын өрийн хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа, 2017-2024 он, жил




Эх сурвалж: Монголбанк

5.5. Засгийн газрын өрийн 96.1 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр эзэлж байна.

Засгийн газрын гадаад өрийн багцыг валютын бүтцээр харвал 67.8 хувийг ам.доллар, 15.1 хувийг зээлжих тусгай эрх, 9.6 хувийг иен, 4.3 хувийг евро, үлдсэн 3.2 хувийг бусад валют эзэлж байна.

График № 9. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр, валютын бүтцээр, 2024.12.31



Эх сурвалж: Сангийн яам

5.6. MTDS загвараар Засгийн газрын оновчтой стратегийг тодорхойлоход дараах үр дүнтэй байна. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн шинжилгээг Дэлхийн банкнаас боловсруулсан дунд хугацааны өрийн стратегийн загварын хүрээнд гаргаж байна. Ингэхдээ доорх 4 стратегийн хүрээнд шинжилгээг хийсэн.

Энэхүү стратеги нь Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ буюу төсвийн алдагдал болон үндсэн төлбөрийг хэрхэн санхүүжүүлэхийг сонгож буй хувилбарууд бөгөөд дараах стратегиар нийт санхүүжилтийн хэрэгцээг гадаад, дотоод эх үүсвэрээр хэрхэн санхүүжүүлэх боломжийг харуулсан болно.

Стратеги 1 (S1):

Засгийн газрын гадаад үнэт цаасыг дотоод үнэт цаасаар санхүүжүүлнэ, гадаад зээлийн ашиглалтын хэмжээг багасгана;

Стратеги 2 (S2):

Засгийн газраас 2026-2028 онд төлөгдөх нөхцөлтэй үнэт цаасны бага хэмжээнд өрийн зохицуулалт хийх, гадаад төслийн зээлийн ашиглалтын ДНБ-д эзлэх хэмжээ 3-4 хувь;

Стратеги 3 (S3):

Засгийн газраас 2026-2028 онд төлөгдөх нөхцөлтэй үнэт цаасны хувьд дийлэнх хэмжээнд өрийн зохицуулалт хийх, гадаад төслийн зээлийн ашиглалтын ДНБ-д эзлэх хэмжээ 3-4 хувь;

Стратеги 4 (S4):

Засгийн газраас 2026-2028 онд төлөгдөх нөхцөлтэй үнэт цаасны хувьд бүх хэсгийн хүрээнд өрийн зохицуулалт хийх, гадаад төслийн зээлийн ашиглалтын ДНБ-д эзлэх хэмжээ 3-4 хувь, дотоод үнэт цаас гаргахгүйгээр гадаад хөтөлбөрийн зээлийн хүрээнд үндсэн төлбөр төлж барагдуулах;


Улсын төсөв ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед дээрх стратегиудыг авч хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд дараах байдлаар гарах төсөөлөлтэй байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

Эрсдэлийн индикатор	2024	2028			
	Суурь	S1	S2	S3	S4

Дахин санхүүжилтийн эрсдэл	Богино хугацаанд төлөгдөх өр /Нийт өрд эзлэх хувь/	3.8	21.0	15.9	13.9	9.2
	Богино хугацаанд төлөгдөх өр /ДНБ-д эзлэх хувь/	2.0	6.1	4.6	4.0	2.6
	Гадаад өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	7.4	7.8	7.7	7.6	7.8
	Дотоод өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	2.8	1.4	1.4	1.4	2.5
	Нийт өрийн багцын эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	7.5	6.7	7.1	7.1	7.8
Хүүгийн түвшний эрсдэл	Хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	6.5	5.3	5.6	5.6	5.8
	1 жилд тогтмолжуулах өр /нийт өрд эзлэх хувь/	19.9	35.6	31.6	29.6	28.7
	Тогтмол хүүтэй зээл ба бонд /нийт өрд эзлэх хувь/	82.9	83.6	82.5	82.5	78.7
Ханшийн эрсдэл	Гадаад валютаар илэрхийлэгдсэн /нийт өрд эзлэх хувь/	96.1	79.1	88.0	91.3	99.7

График № 10. Стратегийн хувилбаруудын тооцоолол



5.7. Засгийн газрын өрийн багцын хүүгийн зардал сүүлийн жилүүдэд тогтмол буурч байгаа боловч өрийн багцын эрсдэлийн хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, Засгийн газрын өрийн хүүгийн зардал нийт төсвийн зарлагын 12.8 хувьтай тэнцэж байсан үзүүлэлт 3.8 хувь болж буурсан. Нөгөөтгээгүүр дотоод үнэт цаасны нийт өрд эзлэх хэмжээ 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд хувьсагч хүүтэй гадаад зээлийн нийт гадаад зээлд эзлэх хэмжээ 25 хувьтай тэнцэж байна.

5.8. Дунд хугацаанд гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр гадаад үнэт цаасны төлбөрийг төлж барагдуулах, дотоод үнэт цаасны гаргалтыг тогтмолжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийн хэмжээг зохистой түвшинд хязгаарлах нь чухал байна. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хүрээнд 2026, 2028 онд төлөгдөх гадаад бондын төлбөрөөс тодорхой хэсгийг дахин санхүүжүүлсэн болно. Гэсэн хэдий ч 2026-2027 онд нийслэлийн гадаад үнэт цаас, аж ахуй нэгжүүдээс гаргасан гадаад бондын төлбөрт нийт 1.7 тэрбум ам.долларыг төлөх хуваарьтай байна. Иймд энэхүү төлбөрийг төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд дарамт учруулахгүй төлж барагдуулахын тулд Засгийн газраас дахин санхүүжилтийн арга хэмжээг олон улсын зах зээлд бонд гаргах замаар авч хэрэгжүүлж аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж өгөх нь чухал байна.

Түүнчлэн, дунд хугацааны санхүүжилтийн боломжит эх үүсвэрийн хувьд түлхүү гадаад зээлийн хөрөнгөөр томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хүлээгдэж байгаа болно. Харин дотоодын зах зээлд үнэт цаас гаргах нь Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтийг сайжруулахаас гадна дотоодын аж ахуйн нэгжүүдээс гаргах үнэт цаасны суурь хүүг тогтоох, хөрөнгө оруулагчдыг идэвхжүүлэх чухал ач холбогдолтой байна.

Орон нутгийн өр төлбөр болон Засгийн газрын өрийн баталгааны хувьд улсын төсөвт дарамт учруулахаас сэргийлэх зорилгоор хязгаар тогтоож болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлах шаардлагатай байна.


Зургаа.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ

6.1. Нэрлэсэн ДНБ-ний өсөлт өндөр, төсвийн алдагдал бага байснаас шалтгаалж Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2021-2024 онд буурсан байна. Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаанд эдийн засаг болон төсвийн үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлж байгааг Өрийн тогтвортой байдлын шинжилгээ (Debt Sustainability Analysis)-нд үндэслэн тооцож график 11-т харуулав.

Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцааны өөрчлөлтийг 2017-2024 онд авч үзэхэд 2020 онд өсөж, бусад онуудад буурсан байна. Цар тахлын үед эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр 2020 онд төсвийн алдагдал ихэсч, бодит ДНБ агшсанаар Засгийн газрын өрийн харьцаа нэмэгдсэн бол бусад онуудад өрийн баталгааны үлдэгдлийн бууралт, төсвийн тэнцэл, бодит ДНБ-ий өсөлт болон бодит хүү зэрэг үзүүлэлт өрийн харьцааг буурахад нөлөөлж байв.

Мөн 2021-2024 онуудад ДНБ-ий дефляторын өсөлт өндөр байснаас шалтгаалж нэрлэсэн ДНБ-ий өсөлт нэмэгдсэн, жилийн эцсийн гүйцэтгэлээр төсвийн алдагдлын хэмжээ бага гарснаас шалтгаалан Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа буурсан байна. Засгийн газрын өрд эзлэх гадаад өр нэмэгдэж байгаатай холбоотойгоор валютын ханшийн сулрал нь 2022 онд тус харьцааны бууралтыг сааруулсан байна.

График № 11. Засгийн газрын өрийн харьцаанд эдийн засаг, төсвийн үзүүлэлтийн нөлөөлөх нөлөө, 2017-2028 он



Цаашид Засгийн газрын өрийн харьцааны төсөөллийг өсгөхөд нөлөөлөх гол хүчин зүйл нь 2025-2028 онд Засгийн газрын өрийн баталгаа болон орон нутгийн өрийн өөрчлөлт байх хүлээлттэй байгаа бол бууруулахад нөлөөлөх гол хүчин зүйл нь бодит дотоодын нийт

бүтээгдэхүүний өсөлт болон хүүгийн төлбөрийг цэвэрлэсэн төсвийн тэнцлийн үзүүлэлт байх төсөөлөлтэй байна.

6.2. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026-2028 оны хооронд 42 хувь орчимд тогтвортой хадгалагдах төсөөлөлтэй байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд ДНБ-ний бодит өсөлт 2026 онд 6.0 хувь, 2027 онд 6.5 хувь, 2028 онд 6.5 хувьтай тус тус тэнцэхээр, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026-2028 онд 0.0 хувьтай тус тус тэнцэхээр төсөөлсөн байх бөгөөд Засгийн газрын өрийн хэмжээг 2026 онд 50 хувь, 2027-2028 онд 45 хувьтай тэнцэхээр тусгасан. Энэхүү төсөөллийн хүрээнд Засгийн газрын өрийн хэмжээг тооцоолоход Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026 онд 40.7 хувь, 2027 онд 40.2 хувь, 2028 онд 40.4 хувьтай тэнцэхээр байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэлд туссан дүнтэй нийцэж байна.

Хүснэгт № 8. Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн төсөөлөл, 2026-2028 он

	2025 он	2026 он	2027 он	2028 он
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар	60.0%	60.0%	60.0%	60.0%
Төсвийн хүрээний мэдэгдэл				
Засгийн газрын өрийн нийт хэмжээ / ДНБ	55.0%	50.0%	45.0%	45.0%
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл / ДНБ	0.0%	0.0%	0.0%	0.0%
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт	7.5%	6.0%	6.5%	6.5%
Засгийн газрын өр / ДНБ	42.1%	40.7%	40.2%	40.4%

Шигтгээ. Өрийн тогтвортой байдлын шинжилгээ

Засгийн газрын өрийн тогтвортой байдал гэдэг нь Засгийн газар зээлдэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, санхүүгийн хямралд өртөхгүйгээр урт хугацаанд өрийн эдийн засагт үзүүлэх нөлөөг зохистой түвшинд байлгах чадварыг хэлнэ. Тогтвортой байдлыг үнэлэхийн тулд төсвийн тэнцэл, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв, төсвийн бодлого зэргээс шалтгаалан одоогийн болон төсөөлж буй өрийн хэмжээг зохицуулах боломжтой эсэхийг үнэлэх нь хамгийн оновчтой байдаг.

Олон улсын валютын сан /цаашид “ОУВС” гэх/-аас Засгийн газрын өрийн тогтвортой байдлын шинжилгээг үндсэн 2 загварчлалаар боловсруулдаг байна. Үүнд:

1. Бага орлоготой орнуудын өрийн тогтвортой байдлыг үнэлэх загвар (LICDSF²¹)
2. Улсын эрсдэл, өрийн тогтвортой байдлын шинжилгээний загвар (SRDSF²²)

Монгол Улсын хувьд 2011 оноос бага орлоготой орон гэх ангиллаас гарсан бөгөөд 2023 оноос хойш SRDSF загварыг ашиглан Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг үнэлж ирсэн.

Богино хугацаа


²¹ Debt Sustainability Framework for Low-Income Countries

²² Sovereign Risk, Debt Sustainability Framework

Засгийн газрын өрийн эрсдэлийг богино хугацаанд тогтоохоос өмнө стрессийн ойлголтыг тайлбарлах нь зүйтэй. Улсад тохиох стресс гэдэг нь тухайн улсад шокийн нөлөө орох буюу олон улсын зах зээлд нэвтрэх боломжгүй болох, дефолт болох, зээлжих зэрэглэл муудах зэрэг нөлөөллийг хэлнэ.

ОУВС-аас Засгийн газрын өрийн эрсдэл, өрийн тогтвортой байдлын шинжилгээнд 30 орчим жилийн хугацаанд 200 гаруй улсын өгөгдөлд үндэслэн Ложит загварыг үнэлсэн бөгөөд улсын стрессийн магадлалд хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоож коэффициентыг тооцоолсон байна.

График №12. Богино хугацааны загварын үр дүн



Ийнхүү тооцоолоход их эрсдэлийн түвшин нь стресс тохиох магадлал 19.5 хувиас их байхад, бага эрсдэлийн түвшин нь стресс тохиох магадлал 6.3 хувиас бага байхад гарсан. Тус загварт Монгол Улсын өгөгдлийг оруулж тооцоход 2024 онд стресс тохиох магадлал 13.8 хувь буюу хэвийн эрсдэлтэй гэж үнэлэгдэж байна.

Хүснэгт №9. Богино хугацааны загварын өөрчлөлтийн шалтгаан

Огноо	2021	2022	2023	2024
<i>Стресс таамаглах</i>	<i>2021-22</i>	<i>2022-23</i>	<i>2022-23</i>	<i>2023-24</i>
Ложит стрессийн магадлал	0.138	0.328	0.055	0.138
Магадлалын өөрчлөлт	-0.408	0.190	-0.273	0.083
Үүнээс:				
Институцын чанар	0.025	0.000	0.000	0.000
Стрессийн түүх	-0.011	-0.008	-0.005	-0.003
Мөчлөг	0.044	-0.007	-0.042	0.027
Өрийн дарамт	-0.244	0.076	-0.150	0.044
Олон улсын нөхцөл байдал	-0.243	0.130	-0.066	0.013

Тус стресс тохиох магадлал өссөн гол шалтгаан нь 2024 онд Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хэмжээ өндөр байсан бөгөөд олон улсын нөхцөл байдал²³ муудсантай холбоотой байна.

Дунд хугацаа

Засгийн газрын өрийн дунд хугацааны эрсдэлийг өрийн Фэнчарт буюу Өрийн төсөөллийн тархалт, Санхүүжилтийн хэрэгцээний түвшнээс тооцдог.

²³ Загварт олон улсын нөхцөл байдлыг VIX индексээр тооцсон

Өрийн Фэнчартын хувьд сүүлийн 20 жилийн өгөгдлөөс 10,000 симуляцыг боловсруулж тооцох бөгөөд Фэнчартын өргөн буюу сүүлийн 20 жилд өрд нөлөөлөгч хүчин зүйлс хэрхэн хэлбэлзсэн үзүүлэлт, өр тогтворгүй байх буюу симуляцын хэдэн хувь нь өрийг өсгөсөн байгаа, мөн инцидентийн түвшин хэр байгаагаас шалтгаалж гаргадаг. Шинжилгээнээс гарсан үр дүнд тус загвар хэвийн эрсдэлтэй гарсан байгаа бөгөөд хамгийн том нөлөө нь Фэнчартын өргөн эзэлж байна. Энэ нь сүүлийн 20 жилийн Засгийн газрын өрийн мэдээллээс ирээдүйн 5 жилд өрийн хэлбэлзлийн эрсдэлийн түвшин хэвийн түвшинд байгааг илтгэж байна.

Хүснэгт № 10. Дунд хугацааны загварын үр дүн

Загвар	Үзүүлэлт	Хэмжээ	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн сэрэмжлүүлэг
Өрийн Фэнчарт	Фэнчартын өргөн	108.4	1.6	...
	Өр тогтворгүй байх магадлал	2.6	0.0	...
	Өрийн түвшин х Институтын индекс	21.0	0.5	...
	Өрийн Фэнчартын индекс	...	2.1	Хэвийн
Санхүүжилтийн хэрэгцээ	Санхүүжилтийн хэрэгцээний дундаж хэмжээ	2.8	1.0	...
	Нийт хөрөнгөд эзлэх Банкны ЗГ-аас авах авлага	3.9	1.3	...
	Стрессийн үед Банкны ЗГ-аас авах авлагын өөрчлөлт	2.6	0.9	...
	Санхүүжилтийн хэрэгцээний индекс	...	3.1	Бага

График № 13. Өрийн Фэнчарт





График № 14. Санхүүжилтийн хэрэгцээ



Харин Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний эрсдэлийг тооцохдоо дараагийн 5 жилд санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшин, арилжааны банкуудын Засгийн газраас авах авлагын хэмжээ болон стрессийн үед Засгийн газраас авах авлагын хэмжээ хэрхэн өсөх төсөөллийг тооцдог бөгөөд шинжилгээгээр бага эрсдэлтэй гарсан байна. Энэ нь 2026 он хүртэл томоохон өр төлбөрийг төлж барагдуулснаар санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшнийг бууруулсантай холбоотой байна.

График №15. Дунд хугацааны эрсдэл



Ингэснээр доор харуулж буй хүснэгтээр тус 2 эрсдэлийн үзүүлэлтийг индексжүүлж авч үзэхэд дунд хугацаанд Засгийн газрын өрийн эрсдэл хэвийн түвшинтэй байна.

Хүснэгт №11. Дунд хугацааны эрсдэлийн индекс

	Бага эрсдэлийн жишиг	Өндөр эрсдэлийн жишиг	Нийтэд эзлэх жин	Индексжүүлсэн хэмжээ
Өрийн Фэнчарт	1.1	2.1	0.5	0.5
Санхүүжилтийн хэрэгцээ	7.6	17.9	0.5	0.1
Дунд хугацааны индекс	0.3	0.4	...	0.3, Хэвийн

Дүгнэлт

Ингэснээр Засгийн газрын өрийн эрсдэл богино хугацаанд хэвийн, дунд хугацаанд хэвийн түвшинд байхаар дүгнэлт гарч байна. Харин 2022 онд ОУВС-аас Улсын секторын өрийн хүрээнд хийсэн тус шинжилгээгээр өндөр эрсдэлтэй гэж гарч байсан. Энэ нь МУХБ-ны бондууд төлөгдөх, Монголбанкны своп төлөгдөх, Засгийн газраас Хуралдай бонд, Гэрэгэ бондыг төлөхөөр хүлээж байсантай холбоотой.

Хүснэгт №12. Засгийн газрын өрийн эрсдэлийн түвшин

Хугацаа	Механик дохио
Богино хугацаа	Хэвийн
Дунд хугацаа	Хэвийн
Фэнчарт	Хэвийн
Санхүүжилтийн хэрэгцээ	Бага

Дээрх өрийн эргэн төлөлтүүдийг хуваарийн дагуу 2023 онд бүрэн төлж барагдуулсан бөгөөд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 60.5 хувьтай тэнцэж байснаас 41.8 хувь болж 18.7 хувиар буурсан, эдийн засгийн өсөлт 5-7 хувьтай тэнцэж, гадаад валютын албан нөөцийн хэмжээ 3.4 тэрбум ам.доллараас 5.5 тэрбум ам.доллар болж өссөн зэрэг эдийн засгийн эерэг үзүүлэлтүүдтэй холбоотойгоор эрсдэлийн түвшин буурсан байна.

Долоо.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН ДУНД ХУГАЦААНД ДЭВШҮҮЛЖ БУЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1: Шинээр авах гадаад төслийн зээлийн санхүүжилтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон инженерийн дэд бүтцийн төсөлд чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 2: Тэргүүлэх ач холбогдол бүхий томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэхэд Засгийн газрын өрийн баталгаа болон олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаад улс орноос санал болгож буй баталгааны хэрэгслүүдийг ашиглана.

Зорилт 2. Засгийн газрын өрийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлж, дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1: Байгалийн гамшиг, санхүүгийн хямрал зэрэг гэнэтийн нөхцөл байдал үүсэхэд ашиглах, мөн шаардлагатай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор авч ашиглах боломжтой нөхцөлт санхүүжилтийн бүтээгдэхүүн, бодлогод суурилсан зээл болон төсвийн дэмжлэгийн зээл зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас санал болгож буй хэрэгслүүдийг ашиглана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 2: Шаардлагатай тохиолдолд өрийг хугацаанаас өмнө төлөх, валютын своп, форвард хэлцэл, хүүгийн своп зэрэг өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зорилт 3. Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах чиглэлийг баримтлах бөгөөд эрсдэлийг зохистой түвшинд байлгах зорилгоор үлдэгдлийг хязгаарлаж, жил бүр эрсдэлийн үнэлгээ хийнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 2: Аймаг, нийслэлийн үнэт цаасны үлдэгдлийг зохистой түвшинд тогтоох бөгөөд аймаг, нийслэлээс төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргах тохиолдолд сүүлийн 2 жил улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй, өөрийн орлогоор үнэт цаасны эргэн төлөлтийг хийх чадвартай байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 3: Улсын төсвөөс төлөгдөх нөхцөлтэй өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй.

Зорилт 4. Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан зах зээлийн суурь хүүг тогтоох замаар аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1: Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэн, арилжааг тогтмол зохион байгуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 2: Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, боломжит хэмжээг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд төсөл, хөтөлбөр, төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор арилжаалахгүй.

Найм. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ЗОРИЛТОТ БҮТЭЦ

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь 2024	Төсөөлөл 2025	Түвшин	Зорилтог түвшин		
						2026	2027	2028
ЗОРИЛТ 1.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон инженерийн дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан гадаад зээлийн гэрээний дүнг тухайн жилд байгуулсан гадаад төслийн зээлийн нийт хэмжээнд харьцуулсан харьцаа	хувь	42.5	56.9	доод	70.0	70.0	70.0
ЗОРИЛТ 2.	Зорилтын хүрээнд гэрээ байгуулсан санхүүгийн бүтээгдэхүүн болон хэрэгжүүлсэн өрийн зохицуулалтын арга хэмжээний* тоо	нэгж	2	0	доод	2	2	2
ЗОРИЛТ 3.	Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл/ДНБ	хувь	2.4	6.1	дээд	10.0	10.0	10.0
	Тухайн аймаг, нийслэлийн гаргасан үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл/ тухайн аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн орлого	хувь	75.7 НЗДТГ	75.2 НЗДТГ	дээд	70.0	60.0	50.0
ЗОРИЛТ 4.	Арилжаа зохион байгуулах давтамж	нэгж	-	Сард 2 удаа	доод	Сард 2 удаа		
	Дахин санхүүжилтийн зориулалтаар гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны тоо	нэгж	0	1	дээд	2	2	2

*-Дахин санхүүжилтээс бусад өрийн зохицуулалтын арга хэмжээ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
НЭГДСЭН ХУРАЛДААНД
ОРОЛЦОХ АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС**

Хэлэлцэх асуудал: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоомжийн төслийг Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Утас
1	И.Батхүү	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113569
2	Ж.Ганбат	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99104599
3	Л.Энх-Амгалан	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга	80770972
4	Ц.Эрдэнэбат	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	88883666
5	Б.Анар	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга	99078437
6	Л.Балчинлуvsан	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга	88040439
7	П.Чандмань	Эдийн засаг, хөгжлийн Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын дарга	99099122
8	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99190219
9	Ж.Дэлгэржаргал	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга	99100568
10	С.Тулга	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	98110000
11	Б.Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
12	Г.Золбоо	Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга	99196439
13	О.Мягмардорж	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга	88886106
14	Б.Дэлгэрмаа	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга	99108157
15	Ц.Мөнхдэлгэр	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга	99199307
16	Л.Гантогтох	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга	99160950